


ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



2022 он



ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2022 он

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

- Б.Алтангэрэл Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
- Э.Батбаяр Хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
- Б.Галбадрах Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгэм, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор (Ph.D), дэд профессор
- Д.Буяннэмэх Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн судлаач-докторант (LL.M.)
- Ц.Ганчимэг Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны тэнхимийн эрхлэгч, хууль зүйн ухааны магистр (LL.M.)
-

© Нээлттэй Нийгэм Форум, 2022 он
Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

Хаяг: Монгол Улс,
Улаанбаатар хот-14240,
Сүхбаатар дүүрэг,
Жамьян гүний гудамж-5/1
Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ISBN: 978-9919-9926-5-1

Дэлхий нийтийн эрүүгийн ялын бодлого хувьсан өөрчлөгдөж, хорихоос өөр төрлийн ял түлхүү хэрэглэхийг зорих болсон энэ цаг үед Улсын Их Хурал зорчих эрхийг хязгаарлах ялыг 2015 оны Эрүүгийн хуульд шинээр тусгаад байна. Тус ялыг техник, эдийн засгийн хүчин зүйлээс шалтгаалан 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн билээ. Нээлттэй Нийгэм Форум нь тус ялыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө НОМОС хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн судлаачдад “Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх боломж” сэдвээр судалгааны ажил захиалан, үр дүнг нь тойм хэлбэрээр олон нийтэд хүргэсэн болно.

Энэхүү ялыг хэрэглэж эхлээд жил гаруй хугацаа өнгөрч буй тул ялын үр нөлөө, хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг судлах хэрэгцээ шаардлагыг харгалзан “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт” сэдэвт судалгааг Дотоод хэргийн их сургуулийн судлаачдын багаар гүйцэтгүүлэн Та бүхний сонорт хүргэж буйдаа баяртай байна. Уг судалгаагаар зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, түүний шинжийг онол, практикийн түвшинд авч үзэж, гадаад орны туршлага, өөрийн орон дахь хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, холбогдох санал, зөвлөмж дэвшүүлсэн болно.

Судалгаатай www.forum.mn цахим хуудас болон манай байгууллагын нийгмийн сүлжээнд хандан танилцах боломжтойг дуулгахад таатай байна. Бидний судалгааны ажилд Таны өгөх санал, шүүмж онцгой үнэ цэнтэй байх болно.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	6
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	8
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	9
НЭГ. УДИРТГАЛ.....	11
1.1. Судалгааны ажлын үндэслэл, шаардлага.....	12
1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт	12
1.3. Судалгааны хамрах хүрээ, арга зүй.....	13
1.4. Судлагдсан байдлын тойм.....	14
1.5. Судалгааны ач холбогдол	15
ХОЁР. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ.....	16
2.1. Зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, түүний онцлог.....	16
2.1.1. Хорихоос өөр төрлийн ялын шинж	16
2.1.2. Зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, түүний онцлог.....	20
2.2. Эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал	26
2.2.1. Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн хүний зорчих эрхийг хязгаарлаж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал.....	29
2.3. Гадаадын зарим орны туршлага.....	36
2.3.1. Америкийн Нэгдсэн Улс	36
2.3.2. Австралийн Холбооны Улс.....	37
2.3.3. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс.....	38
2.3.4. Бүгд Найрамдах Солонгос Улс	38
2.3.5. Бүгд Найрамдах Хятад Ард Улс.....	42
2.3.6. Оросын Холбооны Улс	44
2.3.7. Хэсгийн дүгнэлт.....	46
ГУРАВ. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	47
3.1. Олон улсын баримт бичиг	47
3.1.1. Токиогийн дүрэм	47
3.1.2. Эрүүгийн загвар хууль	51

3.2. Үндэсний хууль тогтоомж.....	53
3.2.1. Эрүүгийн хууль.....	53
3.2.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.....	54
3.2.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох эрх зүйн акт	55

ДӨРӨВ. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ61

4.1. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж буй байдал.....	61
4.1.1. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээд.....	61
4.1.2. Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн солих.....	62
4.2. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлж буй байдал.....	68
4.2.1. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт.....	68
4.2.2. Ялтны үйлдсэн гэмт хэрэг, зөрчил	83
4.2.3. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал.....	85

ТАВ. ДҮГНЭЛТ.....88

ЗУРГАА. САНАЛ, ЗӨВЛӨМЖ89

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ.....91

ХАВСРАЛТ94

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ХСИС	Хууль сахиулахын их сургууль

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 1. Судалгаанд оролцогчдын ажилласан жилийн судалгаа
- График 2. Эрүүгийн хуульд туссан ялын төрөл, эзлэх хувь
- График 3. Эрх зүйн зохицуулалтад өгсөн эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчдийн үнэлгээ
- График 4. 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналтад байгаа ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын хугацаа
- График 5. 2022 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэл хяналтад байсан зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны ял эдэлж буй байршил
- График 6. Ахлах болон шийдвэр гүйцэтгэгчдийн хүйсийн судалгаа
- График 7. Ахлах болон шийдвэр гүйцэтгэгчдийн төгссөн сургуулийн судалгаа
- График 8. Булган аймгийн хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлсэн байдал
- График 9. Дархан-Уул аймгийн хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлсэн байдал
- График 10. Орхон аймгийн хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлсэн байдал
- График 11. Сэлэнгэ аймгийн хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлсэн байдал
- График 12. Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй ялтны үйлдсэн гэмт хэргийн судалгаа
- График 13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх заалтыг зөрчсөн ялтны судалгаа
- График 14. Зорчих эрхийг хязгаарлах ялыг нь хорих ялаар сольсон ялтны судалгаа

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. БНСУ-ын цахим хяналтын зорилго
- Зураг 2. БНСУ-ын цахим гавын хөгжил
- Зураг 3. БНСУ-ын GPS байршил тогтоох систем
- Зураг 4. БНСУ-ын цахим хяналтын танилцуулга
- Зураг 5. БНСУ-ын цахим хяналтын системийн холбоос
- Зураг 6. БНХАУ-д зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглаж буй тоног төхөөрөмж
- Зураг 7. ОХУ-д зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглаж буй тоног төхөөрөмж
- Зураг 8. ОХУ-ын орон нутгийн шийдвэр гүйцэтгэх албанд ашиглаж буй тоног төхөөрөмж
- Зураг 9. Гарын цахим бугуйвчийн иж бүрдэл

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт
- Хүснэгт 2. Дүрмийн шаардлага
- Хүснэгт 3. Дүрэмд тусгагдсан хорихтой холбоогүй арга хэмжээг хэрэгжүүлэх
- Хүснэгт 4. Дэлхийн эрүүгийн загвар хуульд ялын төрөл туссан байдал
- Хүснэгт 5. Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ял туссан байдал
- Хүснэгт 6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зорчих эрхийг хязгаарлах ял туссан байдал
- Хүснэгт 7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг тусгасан байдал
- Хүснэгт 8. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох эрх зүйн актын зохицуулалт
- Хүснэгт 9. Шүүхээс зорчих эрх хязгаарлах ялыг шууд оногдуулсан ялтны судалгаа
- Хүснэгт 10. Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7.1-д заасан үндэслэлээр хорих ялыг нь зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон хоригдлын үйлдсэн гэмт хэргийн судалгаа
- Хүснэгт 11. Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7.2-т заасан үндэслэлээр хорих ялыг нь зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон хоригдлын үйлдсэн гэмт хэргийн судалгаа
- Хүснэгт 12. Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7.3-т заасан үндэслэлээр хорих ялыг нь зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон хоригдлын үйлдсэн гэмт хэргийн судалгаа
- Хүснэгт 13. Өршөөлийн хуульд хамрагдаж, зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон ялтны нас, хүйс, оршин суух газрын харьяаллын судалгаа
- Хүснэгт 14. Өршөөлийн хуульд хамрагдсан ялтнуудын өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан эсэх талаарх судалгаа
- Хүснэгт 15. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны тоо (2021, 2022 оны эхний хагас жилийн харьцуулалт)

- Хүснэгт 16. 2022 оны эхний хагас жилд зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хяналтад байгаа ялтны үйлдсэн гэмт хэргийн судалгаа
- Хүснэгт 17. 2022 оны эхний хагас жилд хяналт тавьж ажилласан ялтан, этгээдийн тоон үзүүлэлтийн харьцуулалт (Орон нутгаар)
- Хүснэгт 18. Шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын ачааллын судалгаа
- Хүснэгт 19. Ялтны гаргаж буй нийтлэг зөрчил
- Хүснэгт 20. Зорчих эрхийг хязгаарлах ялд хяналт тавихад тулгамдаж буй асуудал

НЭГ. УДИРТГАЛ

Дэлхийн ихэнх улс орны эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл баримтлал, зарчим давамгайлж байна.

Ял эдлүүлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийж үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь их хэмжээний зардал үүсгэж байгаагийн зэрэгцээ суллагдсан хүмүүс нийгмийн орчинд дасан зохицох чадвар муу, гэмт хэрэг дахин үйлдэхээс үл эмээх хандлагатай байгаагаас үүдэн хорих ялыг үр дүн багатай ялын төрөлд тооцдог.

Хорихоос өөр төрлийн буюу олон улсад алтернатив ял гэж нэрлэгддэг ял (alternative penalty) нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, тогтоосон хугацаанд хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгждэг.¹

Дэлхийн олон улс эрүүгийн ялын бодлогоо хүний эрхийг хангах, хүнлэг энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлэх, ялын чанга шийтгэлээс үндсэндээ татгалзах, гэмт этгээдэд хүмүүжил, төлөвшил олгох хүрээнд хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг хэрэглэх чиг хандлагатай байна.²

Манай улсын хувьд хорих ялаас татгалзах, үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний онцлог байдалд тохирсон ял оногдуулах замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2015 оны Эрүүгийн хуульд шинэ төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ял нэмж, хэрэгжилтийг нь цахим хэлбэрээр хянах нөхцөл бүрдүүлсэн.

Түүнчлэн Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдүүлнэ” гэх зорилтын хүрээнд “зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем” хөгжүүлэн, ял эдлүүлэх ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжсэнээр Үндсэн хуулиар тунхагласан, ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрхийг дээдлэх тулгуур зарчимд нийцүүлэх, гэмт этгээд ажиллаж хөдөлмөрлөн, гэр бүл, үр

¹ Ц.Очгэрэл. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. “Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017, 411 дэх тал.

² Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018, 29 дэх тал.

хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх, учруулсан хохирлоо нөхөн төлөх, хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлыг бууруулах зэрэг олон талын ач холбогдолтой.

Өнөөдрийн байдлаар хоригдолд ногдох өдрийн дундаж зардал 7231 төгрөг буюу жилд 2.639.619 төгрөг байна. Харин зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд ногдох өдрийн дундаж зардал 3313 төгрөг буюу жилд 1.209.173 төгрөг байгаа нь хорих ял эдлүүлэх зардлаас даруй 54.1 хувиар бага байна.³

1.1. Судалгааны ажлын үндэслэл, шаардлага

Монгол Улсад зорчих эрхийг хязгаарлах ялыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс оногдуулж эхэлснээс хойш иргэд, олон нийтийн зүгээс ял эдлүүлэх ажиллагааны практикт тухайн ялтныг хянахад ашиглаж буй техникийн шийдэл хангалтгүй, хүрэлцээ муу, улс орныг бүхэлд нь хамарсан хяналтын тогтолцоо сул, ялтны эрх зүйн байдал хангалтгүй, түүнчлэн ялтан оргон зайлах боломжтой зэрэг үзэл, хандлага нэлээд байна.

Иймд хөндлөнгийн байр сууринаас зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт, тулгамдсан асуудлыг судалж, шийдвэрлэх арга замын талаар санал, зөвлөмж боловсруулах шаардлагыг үндэслэн судалгааг хийж гүйцэтгэв.

1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт

Судалгааны ажлын зорилго нь зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, цаашид уг ялын үр нөлөөг дээшлүүлэхтэй холбоотой дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны багаас зорилгоо хангах хүрээнд дараах дэд зорилтуудыг дэвшүүлж ажиллалаа:

1. Зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, түүний онцлогийг тодорхойлох;
2. Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлж буй гадаадын зарим орны туршлага судлах;
3. Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх;
4. Шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж буй байдалд дүн шинжилгээ хийх;
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлж буй байдал, тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх;

³ Хууль зүй, дотоод хэргийн яам. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд шаардагдах зардлын тооцоо. УБ., 2020, 17 дахь тал.

6. Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох санал, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

1.3. Судалгааны хамрах хүрээ, арга зүй

Судалгааг хийхдээ хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны нэг төрөл болох зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийг тоон болон ярилцлагын судалгааны арга ашиглан гүйцэтгэлээ.

Энэ хүрээнд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны албан ёсны тоон мэдээлэлд тулгуурлан үнэлэв.

Мөн зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг судлах хүрээнд 64 ялтны хувийн хэргийг сонгон, дүн шинжилгээ хийлээ.


Судалгааны түүвэрт зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг гардан хэрэгжүүлдэг эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчдийг хамруулахыг эрмэлзсэн.

Судалгааны асуулгад улсын хэмжээнд ажиллаж буй эрүүгийн 65 шийдвэр гүйцэтгэгчээс 42 нь буюу 64.6 хувь нь хамрагдсан ба тэднээс дараах хэдэн асуулгаар санал авсан. Үүнд:

- Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар нь шаардлага хангаж буй эсэх;
- Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй хүндрэл, бэрхшээл;
- Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй ялтны гаргаж буй нийтлэг зөрчил;
- Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлэхэд удирдлагын дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагаа, хяналтын хэрэгжилт;
- Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлэх ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн санал хүсэлт.

Санал, асуулгын хүрээнд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын 21, Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн болон зарим орон нутгийн эрүүгийн 17 шийдвэр гүйцэтгэгчийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн хүрээнд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал, ялтны гаргаж буй нийтлэг зөрчил, дутагдал, шийдвэрлэх арга замын талаар санал, бодлоо солилцохыг зорьсон.

График 1. Судалгаанд оролцогчдын ажилласан жилийн судалгаа



Түүнчлэн зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй 24 ялтантай (Улаанбаатар хотын 16, орон нутгийн 8) ял эдлэх явцад учирч буй хүндрэл, бэрхшээлийн талаар ярилцлага хийв.

Харьцуулсан судалгааны хэсэгт судалгааны багийн гишүүн, доктор Б.Алтангэрэлийн 2018 онд Бүгд Найрамдах Солонгос Улс, 2019 онд Америкийн Нэгдсэн Улс, доктор Б.Галбадрахын 2021 онд Оросын Холбооны Улсын зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлж буй байдалтай танилцан, туршлага судалсан тухай материал, тус ялыг үр дүнтэй хэрэгжүүлж буй зарим орны эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Хүн амын төвлөрөлт, шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж буй байдлыг харгалзан Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийг сонгож, тус ялын хэрэгжилтэд шинжилгээ хийсэн.

1.4. Судлагдсан байдлын тойм

Эрүүгийн ял, түүний хэрэгжилтийн талаар хууль зүйн салбарын зарим эрдэмтэн, судлаачид цөөнгүй бүтээл туурвисан хэдий ч Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгээр хийж гүйцэтгэсэн судалгаанаас өөр зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг тодруулахад чиглэсэн судалгааны бүтээл хараахан үгүй байна. Үүнтэй холбоотойгоор өмнө хийгдсэн ном, бүтээлийг тоймлон үзье. Үүнд:

1. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол (Ялын тухай сургаал)⁴; Зохиогч бүтээлдээ ялын онол, үзэл баримтлалыг дэлгэрэнгүй тусгаснаас гадна ял тус бүрийн онцлог, мөн чанарыг онолын хувьд тодорхойлсон.
2. “Харьцуулсан эрүүгийн эрх зүй”⁵ нэг сэдэвт бүтээл; Энэхүү бүтээлд эрх зүйн бүлийн онцлогтой уялдуулан эрүүгийн эрх зүй, тухайлан ялын төрөл, хэлбэрийн талаар дэлгэрэнгүй тусгажээ.

⁴ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол (Ялын тухай сургаал). УБ., 2014.

⁵ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012.

3. “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа”⁶ гарын авлага;
Энэхүү гарын авлагад хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны нөхцөл, журмыг уламжлал, эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалтай уялдуулан авч үзсэн. Түүнчлэн хорихоос өөр төрлийн ялын тухай ойлголт, түүний мөн чанар, ял эдлүүлэх ажиллагааны зарчмыг тусгажээ.
4. “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судлал”⁷ нэг сэдэвт бүтээл;
Зохиогч бүтээлдээ дэлхийн улс орнуудын ялын тогтолцоо, чиг хандлага, ялын тогтолцоонд нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх ажиллагааны эзлэх байр суурь, мөн чанарыг тусгажээ.
5. “Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам (Харьцуулсан судалгаа)” судалгааны тайлан.⁸
Судалгааны тайланд гадаадын зарим орны зорчих эрхийг хязгаарлах ялын онцлог, хэрэгжүүлж буй арга хэлбэрийн талаар туссан байна.

1.5. Судалгааны ач холбогдол

Шинэ төрлийн ял болох зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулах нь эрүүгийн ялын зорилго, үр нөлөөг дээшлүүлэх, ял завших боломж олгохгүй байх, ял гарцаагүй байх зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

⁶ Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018.

⁷ Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судлал. УБ., 2017.

⁸ Нээлттэй Нийгэм Форум. “Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам (Харьцуулсан судалгаа)” судалгааны тайлан. УБ., 2016.

ХОЁР. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ

2.1. Зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, түүний онцлог

2.1.1. Хорихоос өөр төрлийн ялын шинж

Олон улсын ял оногдуулах зарчимд тодорхой санкцыг хуульчлан, оногдуулах явдлаас аль болох зайлсхийн, алтернатив нөхцөлийг тодорхой боломжит шийдлээр зохицуулах, хүнд биш хэргийн хувьд хянан харгалзах, торгох ял өргөн хэрэглэх, баривчлах болон хорих ялын доод хугацааг багаар тооцох, торгуулийг сүүлийн 6 сар хүртэлх сарын дундаж орлогоор тооцох, мөнгөн дүнгээр илэрхийлэх, хорихоос өөр төрлийн ялыг өргөжүүлэн, ял солих процедурыг оновчтой хэрэглэх практик түгээмэл хэрэглэгдэж байна.⁹

Зорчих эрхийг хязгаарлах ял нь хорихоос өөр төрөл буюу нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх ажиллагаанд хамаардаг тул ялын тогтолцоонд хорихоос өөр төрлийн ялын эзлэх байр суурь, онцлог шинжийг тодорхойлох нь чухал юм. Дийлэнх улс орны эрүүгийн хууль тогтоомжид ялын тухай ойлголтыг тодорхойлсон нэгдсэн томъёолол алга байна. Постсоциалист орнуудаас ОХУ, Украин, Казахстан, Армени, Узбекистан, Тажикистан зэрэг оронд “ял” (наказание) гэсэн нэр томъёогоор хэрэглэж тодорхойлсон бол Беларусь, Молдова, Монгол зэрэг улс “эрүүгийн хариуцлага” гэсэн ойлголтоор тодорхойлжээ.

1996 оны 2-р сарын 17-нд баталсан Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын Эрүүгийн загвар хуулийн 3-р хэсгийн 9-р бүлгийн 45-р зүйлд ял гэсэн ойлголтыг “шүүхийн тогтоолоор оногдуулах төрийн албадлагын арга хэмжээ” гэж тодорхойлсны дээр 45 дугаар зүйлийн 2-т “ял нь шүүгдэгчийг шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, засаж төлөвшүүлэх болон нийгмийн шударга ёсыг сэргээн тогтоох зорилгоор хэрэглэгдэнэ” гэжээ.¹⁰

Герман, Францын эрүүгийн эрх зүйн эх сурвалжид ялыг төрийн албадлагын арга хэмжээ гэхээсээ илүү шударга ёсыг хангах хэрэгсэл гэсэн утгаар үздэг бол эх газрын системийн орнуудад гэмт хэргийн хор уршигт тохирсон ялын уян хатан систем үйлчилдэг.

Манай улсад хэрэглэгдэж буй хорихоос өөр төрлийн ял гэсэн нэр томъёо нь дэлхийн улс орнуудад:

1. Нийгэм-олон нийтэд тулгуурласан ял (community sentence, community based sentence)¹¹;

⁹ Б.Алтангэрэл. “Эрүүгийн ялын гүйцэтгэлийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ” судалгааны ажлын тайлан. УБ., 2018.

¹⁰ Модельный уголовный кодекс “Рекомендательный законодательный акт Содружества Независимых Государств”. М., 1996, с.14.

¹¹ Зарим судлаачид “нийгэмд үйлчлэх ял”, “нийтийн тусын тулд үйлчлэх ял” зэргээр нэрлэх нь бий.

2. Сонгох ял (alternative sentence);
3. Хорихоос өөр төрлийн ял (non-custodial sentence)¹² зэргээр нэр томъёоны хувьд өөр боловч агуулгын хувьд төдий л ялгаагүйгээр хэрэглэгдэж байна.

“Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл” болон “сонгох хувилбараар оноох ял шийтгэл” гэсэн ойлголт зарчмын хувьд ижил утга илэрхийлнэ.

Сонгох хувилбараар оноох ял шийтгэл гэдэгт учруулсан хохирлын хэмжээг харгалзан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эдлэх ялыг нийгмээс тусгаарлахгүй хэлбэрийн ялаар орлуулан хэрэглэж буй төрийн албадлагын арга хэмжээг ойлгоно. Уг ял шийтгэлийн гарал үүслийг XVIII–XIX зууны зааг буюу соён гэгээрлийн эриний философийн хөгжлийн үетэй холбон авч үздэг. Учир нь энэ үеэс эхлэн эрх чөлөөг хязгаарлах буюу хорих ялыг ялтныг тарчлаан зовоох болон цаазаар авах ялын сонгох хувилбар болгон хэрэглэх болжээ.

Ийнхүү ял шийтгэлийн түүхэн хөгжил нь философи, нийгэм, ёс суртахуун, хүний эрхийн талаарх ойлголттой нөхцөлдөн ялын төрөл, хэмжээ, зорилгын талаарх онолын мэдлэг улам бүр баяжин пенелогийн (ял судлалын) шинжлэх ухаан үүссэн байна.

Ялыг тодорхойлон судлах гол салбарын нэг бол эрүүгийн эрх зүй бөгөөд гадаадын зарим оронд эрүүгийн эрх зүйг “гэмт хэргийн эрх зүй” (Англи, АНУ, Герман), “ял шийтгэлийн эрх зүй” (Франц, Болгар, Чех, Польш) зэргээр гэмт хэрэг болон ялыг тодотгох хэлбэрээр нэрлэдэг. Манай улсын практикт эдгээр ухагдахууныг нэгтгэн “эрүүгийн эрх зүй” гэнэ.

Харин пенелогийн шинжлэх ухааны хөгжил нь ялын мөн чанар, төрөл, хэлбэрийн оновчтой тогтолцоо бий болгох, үр нөлөөг нь дээшлүүлэхэд чиглэж байна.

Хорих ял нь хорихоос өөр төрлийн ялтай харьцуулахад дараах хэдэн онцлогтой. Үүнд:

- Хорих ялын хувьд “хүмүүжүүлэх” ба “цээрлүүлэх” гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Цээрлүүлэх хэлбэр нь зөвхөн хуулиар тогтоосон нөхцөл, журам, эрхийн хязгаарлалтын хүрээнд, тодорхой хугацаагаар байлгах мөн чанарыг илэрхийлнэ. Энэ утгаараа хорих ялд хүмүүжлийн гэхээсээ илүүтэй залхаан цээрлүүлэх шинж давамгайлна. Хорих газарт хэрэгжүүлж байгаа хөдөлмөрийн үйл ажиллагаа нь чөлөөт сонголтын бус албадлагын хэлбэрээр явагдана. Хоригдлыг нийгмээс тусгаарлан хүмүүжүүлнэ гэдэг ялангуяа өнөөгийн нөхцөлд боломжгүй байгаа нь практикаас харагдаж байна.
- Хорих ялд хүнлэг бус шинж чанар давамгайлдаг, учир нь хорих ял эдлүүлэх дэглэм нь гол төлөв цээрлүүлэх аргад тулгуурлах тул энэ хугацаанд хоригдлын зүгээс аливаа чөлөөт үйлдэл хийх, авьяас чадвараа хөгжүүлэх боломж нь хязгаарлагддаг.

¹² <https://www.gov.uk/community-sentences>.

- Хорих ял нь бусад ял шийтгэлийн нэгэн адил хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож байдаг. Хорих ял нь хоригдлын эрх зүйн байдалд дараах хэлбэрээр нөлөөлнө:
 - хоригдлын зарим эрх, эрх чөлөө бүрэн хязгаарлагдана (чөлөөтэй зорчих, сонгох, сонгогдох эрх);
 - хоригдлын зарим эрх, эрх чөлөөнд тодорхой хугацаанд хязгаарлалт тогтооно (хувийн халдашгүй байдал, захидал харилцаа);
 - хоригдолд түүний хувийн зан байдалд нийцүүлэн зарим төрлийн эрх, үүргийг нөхцөлтэйгөөр тогтооно (хувийн ариун цэврийг чанд сахих, хорих байрны дотоод журмыг дагаж мөрдөх);
 - хорих газрын алслагдсан байдал зэрэг ял шийтгэлийн агуулгад хамаарахгүй хүчин зүйлс хоригдлын эрх зүйн байдалд нөлөөлнө;
 - хоригдлын эрх зүйн байдалд хорих газрын дотоод дэглэмээс гадна хоригдлуудын дунд “бичигдээгүй хууль” байдлаар тогтсон эрүүгийн шинжтэй хүчин зүйлс тодорхой нөлөө үзүүлнэ (бусад хоригдлын зүгээс үзүүлэх дарамт шахалт, тогтсон дэглэм). Өөрөөр хэлбэл, хорих ял эдлэх нөхцөл нь хүнийг засаж хүмүүжүүлэхээсээ илүү “гэмт хэргийн мэргэшлийн дамжаа” болох магадлалтай.

Эдгээр хүчин зүйлс хоригдлын хүмүүжил, зан үйл, сэтгэл санаа, бие бялдар, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ нийгэмшүүлэхэд хүндрэл үүсгэдэг байна. Учир нь нийгмийн зүгээс хорих ялыг гол төлөв эергээр хүлээн авдаггүй тул хорих ял эдэлсэн байдал нь хүний амьдралд насан туршийн “хар толбо” болон үлддэг.

Эдгээр сөрөг үр дагаврыг даван туулах үр дүнтэй арга замд нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл зүй ёсоор тооцогдож байна. Учир нь хорих ялыг бодвол нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн хүмүүжлийн арга барил давамгайлна.

Хорихоос өөр төрлийн ял нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, түүнчлэн үйлдсэн гэмт үйлдлээ засаж залруулах боломжийг илүү олгодог бөгөөд ялын уламжлалт онолын хандлага буюу зөвхөн цээрлэл үзүүлэх явдлыг эрс шүүмжилсэн, нийгэм-олон нийтэд ил тод, нээлттэй байх, тэдний оролцоо, дэмжлэг, тусламжид тулгуурласан хэлбэртэй байхын зэрэгцээ эдийн засаг, нийгмийн үр өгөөжтэй ял эдлүүлэх тогтолцооны шинэ хэлбэр юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд юуны өмнө ял шийтгэлийн хэлбэрийг боловсронгуй болгох шаардлагатай. Учир нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг залхаан цээрлүүлэх, тарчлаан зовоох хэлбэрийн арга барил шүүхийн болон хууль сахиулах практикт өнөөг хүртэл амь бөхтэй оршсоор байна. Иймд олон нийтийн зүгээс эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг илүү хүнлэг, энэрэнгүй, ардчилсан хэлбэрт шилжүүлэх арга замыг тууштай эрэлхийлж эхэлсэн. Эдгээр арга замын нэг нь “нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл” буюу “хорихоос өөр төрлийн ял” юм.

Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл гэдэгт ялтны зарим эрхийг тодорхой болзол, нөхцөлтэйгөөр хязгаарлах замаар оноож буй ял шийтгэлийг ойлгоно. Уг ялыг тухайн этгээдийн хувийн зан байдал, ёс суртахууны төлөвшил, үйлдсэн гэмт хэргийн төрөл, нийгэмд учруулсан сөрөг үр дагавар, хохирлын хэмжээ, гэм буруугийн хэлбэр зэрэг олон хүчин зүйлийг харгалзаж оногдуулна.

Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэлийн давуу талууд нь:

1. Хүнлэг ёсны үзэл санаа давамгайлсан;
2. Ялтныг засаж хүмүүжүүлэх болон нийгэмшүүлэх боломжтой;
3. Эдийн засгийн хувьд хэмнэлттэй зэрэгт оршино.

Олон улсын туршлагаас харахад ял сонгох хувилбарын хүрээг тэлж өргөжүүлэхийн тулд юуны өмнө тухайн орны эрүүгийн болон ял, шийтгэл гүйцэтгэх тухай хуульд¹³ нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ялыг¹⁴ түлхүү тусгасан. Үүний тулд:

- ялын бодлогыг өөрчлөх;
- салбар хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах;
- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрчлөн шинэчлэх;
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль тогтоомжийн үзэл баримтлалыг илүү хүнлэг, энэрэнгүй болгох;
- сонгох хувилбараар оноох ял шийтгэлийн хэлбэрийг өргөжүүлэх замаар хорих ял оноох, албадлагын бусад арга хэмжээ хэрэглэх үндэслэл, шаардлагыг улам уян хатан болгоход гол анхаарлаа хандуулах нь зүйтэй юм.

Ял шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд:

- ялтанд үзүүлэх нөлөөллийн арга хэмжээний агуулга, арга барилыг боловсронгуй болгох;
- ял шийтгэл хэрэгжүүлж буй орчин нөхцөлийг сайжруулах;
- ялтныг нийгэмшүүлэх боломж бүрдүүлэх шаардлагатай.

Эдгээр шаардлагыг хорих ялаар хангах боломжгүй болох нь олон жилийн практикаас харагдаж байна. Ялын бодлого бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хүрээнд ялын оновчтой төрөл, хэлбэрийг хуульчлан тогтоож, сонгон хэрэглэх тухай үзэл баримтлал юм.

Монгол Улс дахь ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлаас харахад хорих ял эдлээд суллагдсан этгээд давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй¹⁵ байна. Энэ нь хорих байгууллагаас суллагдсаны дараа явуулах нийгэмшүүлэх ажлын тогтолцоо байхгүй, хууль сахиулах байгууллагуудын хүлээсэн чиг үүрэг тодорхой бус, хорихоос өөр төрлийн ял хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоогүй байгаатай холбоотой.

¹³ Монгол Улсын хувьд уг хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай гэж нэрлэсэн байна.

¹⁴ Монгол Улсын хувьд уг ялыг “хорихоос өөр төрлийн ял” гэж нэрлэсэн байна.

¹⁵ 2021 оны жилийн эцсийн дүнгээр ял эдэлж буй нийт хоригдогсдын 52 хувь нь давтан гэмт хэрэг үйлдсэн байна.

Өөрөөр хэлбэл, ял эдлүүлэх ажиллагааны тогтолцоо, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх, гадаадын зарим орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын туршлагаас суралцан, олон улсын чиг хандлага, загварт нийцүүлэх нь зүйтэй.

2.1.2. Зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, түүний онцлог

“Зорчих эрхийг хязгаарлах” гэсэн нэр томъёог судлан үзэхэд “зорчих” гэдэг нь *хүн нэг зүгийг чиглэн зорчих, ийш тийш зорчин явах*, “эрхийг хязгаарлах” гэдэг нь *эрхийг нь багасгах, хэмжээ тогтоох*¹⁶ гэсэн утга илэрхийлж байгаагаас дүгнэвэл хүний чөлөөтэй зорчих хөдөлгөөнийг хязгаарлах гэж үзэж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих” гэсэн иргэний эрхэд хязгаарлалт тогтоож байгаа нь уг ялын онцлог юм.

Энэхүү ялыг “эрх чөлөө хязгаарлах”, “зорчих эрхийг хасах”, “гэрийн хорио” зэрэг хэд хэдэн нэршлээр томъёолсон. Тухайлбал, Д.Баярсайхан бүтээлдээ гэрийн нөхцөлд хорих ял нь 1984 оноос хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор тухайн этгээдийн амьдарч буй орон байранд нь хатуу хязгаарлалтын дор хорьж цагдах ял юм¹⁷ гэжээ.

Гадаадын зарим оронд “цахим хяналт” (*electronic monitoring (EM)*), “хөлийн гав” (*ankle bracelet*), “радио долгионы төхөөрөмж” (*radio frequency*), “газар зүйн байршил тодорхойлогч” (*GPS*), “гэрийн хорио” (*home confinement*) зэрэг нэр томъёо хэрэглэгдэж байгаагаас манай улсын хувьд “зорчих эрхийг хязгаарлах ял” гэж томъёолсон.

Улсын Их Хурлаас 1998 онд Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр баталж, хууль тогтоомжийг шинэтгэх ажил эрчимтэй хийгдэн, энэ хүрээнд 2012 онд Хууль зүйн сайдын тушаалаар Эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, хуулийн төсөл УИХ-д 3 удаа өргөн баригдаж, 2 удаа буцаагдсаны эцэст 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр шинэчлэн найруулж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Дээрх хуулиар ялын бодлого, тогтолцоонд зарчмын шинжтэй дараах хэд хэдэн өөрчлөлт орсон:

1. Ялын бодлогыг зөөлрүүлэх, олон сонголттой, уян хатан болгох, хорих ялыг эцсийн арга хэмжээ болгон оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ түлхүү оногдуулах зэргээр нийгэм, хамт олон, гэр бүлийн дунд нийгэмшүүлэх;

¹⁶ ПГУА. Монгол хэлний их тайлбар толь. 2019.

¹⁷ Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012, 248-249 дэх тал.

- Олон улсын туршлага, зөвлөмж, хөгжингүй зарим улс орны эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг судалсны дүнд зорчих эрхийг хязгаарлах ялын шинэ төрөл нэмсэн. Ингэснээр хорих ял оногдуулах явдлыг багасгаж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр нийгэм, хамт олон, гэр бүлийн дунд нийгэмшүүлэх боломж бүрдэнэ гэж үзсэн.

Эрүүгийн хуульд ялын шинэ төрлийг хуульчлан, хорих ялыг гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөл, үйлдлийн арга, сэдэл, зохион байгуулалт, оролцооноос хамааран ялгамжтай оногдуулах, түүнчлэн нийгмийн хор аюул бага, болгоомжгүй байдлаар болон анх удаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихоос өөр төрлийн ялаар шийтгэж, нийгэмшүүлэх, нийгэм, сэтгэл зүй, гэр бүлийн харилцааны хүрээнд засан хүмүүжүүлэх зорилготойгоор нийтэд тустай ажил хөдөлмөр эрхлүүлэх, шаардлагатай тохиолдолд улс төрийн болон нийгэм, эдийн засгийн эрхэд нь хязгаарлалт хийх, зорчих эрхийг нь хязгаарлах зэргээр эдийн засгийн хувьд чирэгдэл багатай ял оногдуулахыг зорьсон байна.

Ялын үндсэн үзэл санаа нь ял шийтгүүлсэн этгээдийг гэрт нь буюу байнга амьдрах газарт нь хорих хэлбэрээр хэрэгждэг. Гэхдээ ялтан цахим гав буюу цахим хяналтын төхөөрөмж бүхий дохио дамжуулах, гаднын нөлөөлөлд тэсвэртэй, зориулалтын бусаар тайлах, суллах боломжгүй төхөөрөмж зүүх үүрэг хүлээн, урьдчилан тогтоосон зам, цагийн хүрээнд ажил, гэр, сургуульдаа явах боломжтой.

Зорчих эрхийг хязгаарлах ялын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр зүй зохистой, зөв амьдралд ороход нь туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг гэмт хэрэг дахин үйлдэх зан үйлээс нь татгалзуулах, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогч, бусад хүнийг хамгаалахад оршиж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэж буй ялын нэг төрөл мөн.¹⁸

Уламжлалт ялын төрөл болох цаазаар авах, хорих, торгох, нийтэд тустай ажил (албадан ажил) хийлгэх, албан тушаал эрхлэх болон тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлах зэрэг ялаас зорчих эрхийг хязгаарлах ял нь нэлээд онцлог ялгаатай.

Энэхүү ялыг хэрэгжүүлэхэд ялтны хөдөлгөөнд цаг алдалгүй хяналт тавих *RT* болон *GPS* байршил тодорхойлогч төхөөрөмж, согтуурал, мансуурал хэмжих багаж хэрэглэдэг. Тиймээс төхөөрөмжийг зөв сонгож хэрэглэх, төхөөрөмжийн болоод ашиглалтын зардал, хяналт тавих мэргэжлийн баг,

¹⁸ Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга). 2015, 5.5 дугаар зүйлийн 1.

мэргэжилтэн зэрэг асуудал уг ялыг хэрэгжүүлэхэд чухлаар тавигддаг. Мөн технологийн хөгжил, дэвшлийг хурдацтай нэвтрүүлэх, улс орныг бүхэлд нь, эсхүл тодорхой бүс нутгийг хамарсан сүлжээ шаардлагатай.

Энэхүү ялыг хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг судлах нь зөвхөн хууль зүйн шинжлэх ухааны судлагдахуун бус, техник, технологийн боломж нөхцөлийг судлахыг давхар шаардаж байна. Өөрөөр хэлбэл, техник технологийн дэвшил нь энэхүү ялыг илүү үр дүнтэй хэрэглэх шинэ нөхцөл, боломж бий болгож байдаг.

Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг шинээр хуульчилсан хэдий ч бэлтгэл хангах шаардлагатай байсан тул хэрэгжилтийг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулсан билээ.

Хүснэгт 1. Зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт¹⁹

Эрх бүхий байгууллагын хяналтад байх	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавих үйл ажиллагааг ойлгоно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын техник хяналт хариуцсан ажилтан суурин болон хөдөлгөөнт хяналтын тоног төхөөрөмжийг ялтны бие, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, шаардлагатай бусад газарт суурилуулж, хяналтын тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа болон ялтанд байнгын хяналт тавина. Ялтан тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл хэвийн ажиллагааг нь сарниулсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэж, гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.
Өөрийн оршин суух газраас явахыг хориглох	Өөрийн байнгын оршин суудаг гэж мэдүүлсэн газраас эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй дур мэдэн бүр, эсхүл түр хугацаагаар явахгүй байхыг ойлгоно.
Тодорхой газар очихыг хориглох	Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхийн шийтгэх тогтоолд нэрлэн заасан газарт байнга юм уу түр хугацаагаар очихыг хязгаарласан ойлголт юм. Тухайлбал, гэмт хэрэг үйлдэгдсэн газар, гэрч, хохирогч, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн, эсхүл хэрэг хянан шийдвэрлэхэд оролцсон албан хаагч, хэрэгт хамаарал бүхий бусад хүний байнга юм уу түр оршин суудаг орон байр, албан газар, бүс, засаг захиргааны нэгж зэргийг ойлгоно.

¹⁹ Г.Гантөмөр, С.Гантулга нар. Эрүүгийн эрх зүй (Ерөнхий анги). УБ., 2020, 380 дахь тал.

Шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих	Шүүхийн шийтгэх тогтоолд гэмт хэрэг үйлдсэн хүний зорчиж болохыг зөвшөөрч, нэрлэн заасан чиглэлийг ойлгоно. Тухайлбал, ажил хөдөлмөр эрхлэх, сургуульд суралцах, оршин суугаа газар, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх газар зэрэг болно.
Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 173, 174 дүгээр зүйлд заасан үндэслэл, тохиолдлыг харгалзан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр, эсхүл зорчих бүсийг байнга өөрчлөх арга хэмжээг ойлгоно.

Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно” гэж заасан нь уг ялын нэг онцлог юм. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг гэр бүлийнхээ гишүүдтэй, хүчиндэх гэмт хэрэг үйлдэгчийг хохирогч, гэрчтэй харилцахыг тодорхой хугацаанд хориглож болно.

■ Зорчих эрхийг хязгаарлах цахим хяналтыг хэрэгжүүлж буй байдал

Цахим хяналтын төхөөрөмж буюу байршил тогтоогч төхөөрөмжийн тусламжтайгаар хяналт тавьж буй орнуудын практикийг судлахад дараах байдлаар хэрэглэж байна. Үүнд:

1. Ялын төрөл;
2. Таслан сэргийлэх арга хэмжээний төрөл;
3. Хугацаанаас өмнө буюу тэнсэгдсэн ялтанд хяналт тавих;
4. Хорих ял эдлээд суллагдсан ялтанд хяналт тавих.

Дээрх төрлүүд нь өөр өөрийн онцлогтойгоор шүүхийн өмнөх, ял эдлүүлэх, ялаа эдэлж дууссаны дараах шатыг хамран хэрэгжиж байгаа боловч дараах нийтлэг талтай. Үүнд:

1. RT болон GPS төхөөрөмжийн тусламжтайгаар хяналтыг хэрэгжүүлдэг;
2. Хяналт нь шүүхийн өмнөх шатны таслан сэргийлэх арга хэмжээ, эсхүл зорчих эрхээ хязгаарлуулах ял авсан тодорхой хугацааг хамран хэрэгждэг;
3. Хяналтын нэгдсэн систем, сүлжээгээр хянадаг;
4. Хяналтын төхөөрөмжийн түрээс, ашиглалтын зардлыг хяналтад байгаа хүн хариуцдаг.

■ Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлж буй хэлбэр

Хяналтын төхөөрөмж нь гэрийн хорио гэсэн ойлголттой ямагт хамт хэрэглэгддэг бөгөөд ялтны байршил, шаардлагатай бусад мэдээллийг илтгэдэг. Зорчих эрхийг нь хязгаарласан хүнд гаднын нөлөөтэйгөөр тайлагдахгүй, усны болоод тодорхой хамгаалалт бүхий гар, хөлийн цахим гав зүүлгэдэг. Уг цахим гав нь тухайн этгээдийн оршин байгаа газар буюу

гэрт нь суурилуулсан хяналтын төхөөрөмжөөр дамжуулан дохиог төв рүү илгээдэг.²⁰ Гэрийн хяналтын төхөөрөмж нь ялтны гэрийн утасны шугамаар төв компьютер-серверт холбогдсон байдаг ба 24 цагийн турш хяналт тавьж, мэдээлэл дамжуулах чадамжтай.

Зорчих эрхийг хязгаарлахад идэвхгүй хэлбэрийн хяналт байх ба тухайн ялтанд цахим гав хэрэглэхгүйгээр утсаар холбогдож, өөрийн байдлыг тайлагнах, байршлаа илтгэж байхыг шаарддаг.

Радио долгионы идэвхтэй хяналт нь ялтны хөдөлгөөн бүрийг тухай бүрд дамжуулдаг. Хэрэв тухайн зорчих эрхээ хязгаарлуулсан ялтанд зүүсэн гар, хөлийн цахим гаваас ирж буй дохио нь баталсан зорчих хөтөлбөрөөс гажсан буюу зөвшөөрөгдсөн бүсээс гарсан, хориглосон газарт зорчсон байвал төв хяналтын системд аюулын дохио өгдөг. Дохио ирмэгц эрх бүхий холбогдох байгууллагад зөрчлийн талаар нэн даруй мэдэгдэж, холбогдох хариу арга хэмжээ авдаг. Зорчих эрхийн хязгаарлалт, цахим хяналтын нөхцөлийг зөрчсөн, хяналтын бүсээс гарсан, хориглосон газарт зорчсон, төхөөрөмжийн ашиглалтад санаатайгаар саад хийсэн, салгах, эвдлэхээр оролдсон зэрэг хориотой үйлдэл хийсэн ялтныг зөрчил гаргасан гэж үзэн ял шийтгэл оногдуулдаг.²¹

Байрлал тогтоох хяналтын төхөөрөмж буюу GPS төхөөрөмж нь ялтны байрлаж байгаа газрыг харуулсан гурван хэмжээс бүхий дүрс ялгаруулах бөгөөд сансрын хиймэл дагуулын тусламжтайгаар байршлыг тодорхойлон, тухайн цагт хаана байгаа талаарх мэдээллийг хяналтын төвд шууд дамжуулдаг. Байрлал тогтоох төхөөрөмж ашигласнаар ялтны гэмт хэрэг үйлдэх сэдэл, зан үйл багасдаг байна.²²

Судалгаагаар гэрийн хорио болон цахим гавын хяналтад байх нь адил үр дүнтэй байна гэсэн дүгнэлт гарчээ.²³ Насанд хүрээгүй 300 гаруй хүний дунд явуулсан судалгаагаар гэрийн хорионд байгаа болон хяналтын төхөөрөмжийн хяналтад байгаа хүмүүсийн гэмт хэрэг дахин үйлдэх эрсдэл, тоо хэмжээ нь адил байсан²⁴ гэсэн байна. Дээрх судалгаагаар тэдгээрийн тал хувь нь байнгын, үлдсэн тал нь хагас хяналтад байсан ба хяналт нь

²⁰ National Law Enforcement and Corrections Technology Center. 1999. Keeping Track of Electronic Monitoring. Washington D.C.: U.S. Department of Justice, National Institute of Justice.

²¹ National Law Enforcement and Corrections Technology Center. 1999. Keeping Track of Electronic Monitoring. Washington D.C.: U.S. Department of Justice, National Institute of Justice.

²² Stephen V., Randy Gainey, Marcia I. Cohen, Eoin Healy, Martha Yeide, Alan Bekelman, Amanda Bobnis. 2013. Monitoring High-Risk Gang Offenders with GPS Technology: An Evaluation of the California Supervision Program Final Report. Bethesda, MD: Development Services Group.

²³ Bonta, James, Suzanne Wallace-Capretta, and Jennifer Rooney. 2000. "Can Electronic Monitoring Make a Difference? An Evaluation of Three Canadian Programs." Crime and Delinquency 46(1):1-75.

²⁴ Wiebush, Richard G. 1993. "Juvenile Intensive Supervision: The Impact on Felony Offenders Diverted from Institutional Placement." Crime and Delinquency 39(1):68-89.

чанга, сул, тогтмол, түр зуур байгаагийн хооронд төдий л ялгаагүй байжээ.²⁵

Флорида мужийн Засан хүмүүжүүлэх газар 1987 оноос эхлэн уг төхөөрөмжийг ашиглаж ирсэн бөгөөд тэдний хийсэн судалгаагаар хяналтын төхөөрөмж нь нийгэмшүүлэх бусад хөтөлбөртэй харьцуулбал гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг 31 хувиар бууруулсан гэжээ. GPS төхөөрөмж нь радио долгионы төхөөрөмжөөс илүү үр ашигтай бөгөөд шууд үр дүнг илтгэж, хяналт алдах эрсдэлийг 6 хувиар бууруулжээ. Хяналтын төхөөрөмж нь хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хэрэглэхэд илүү үр нөлөөтэй байдаг байна.²⁶

Хяналтын төхөөрөмж нь тухайн үед гэмт этгээдийн байгаа бодит байрлалыг шууд тогтоох боломж олгодог давуу талтай. Үүний дүнд ялтан гэмт үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.²⁷

Цахим хяналтын төхөөрөмж биедээ зүүж авч явах нь сэтгэл зүйн дарамтад оруулах, бусад хүнээс ичих, санаа зовних байдал бий болгодог гэж үздэг судлаачид ч байна.

Олон улсад цахим хяналтын төхөөрөмж буюу GPS төхөөрөмж нь цаг уур, орчны нөхцөл байдал, газар зүйн байршил зэргээс шалтгаалан дохио сарних, тасалдах, алга болох тохиолдол гардаг бөгөөд өнөөдрийг хүртэл үүнийг шийдэж чадаагүй. Тиймээс тухайн этгээдийн хөдөлгөөнд тогтмол хяналт тавих боломж тодорхой хязгаартай гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Цахим хяналтын төхөөрөмжийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд тухайн улсын бүх нутаг дэвсгэрийг хяналтын төхөөрөмж холбогдон ажиллах боломж бүхий сүлжээтэй (интернэтийн утасгүй сүлжээ болон бусад) болгох, нийгмийн хяналтын сүлжээг сайжруулах шаардлага тулгардаг.

Эрүүгийн эрх зүй, тэр дундаа ял эдлүүлэх эрх зүйн хүрээнд хяналтын төхөөрөмж, цахим гав ашиглах нь ёс зүй, эрх зүйн болон практикийн олон тулгамдсан асуудал бий болгож байна. Тухайлбал, хяналтын төхөөрөмж нь тухайн ял шийтгүүлсэн хүний нийгмээс тусгаарлагдахгүйгээр засарч хүмүүжих, гэмт хэрэг дахин үйлдэхээс нь урьдчилан сэргийлэх зорилготой байдаг ч төхөөрөмж, техник технологиор дамжуулан хязгаарлалт, хараа хяналт тогтоох нь бусад иргэдэд ялтан гэсэн айдас төрүүлж, түүнээс зай барих байдал үүсгэдэг хэмээн үздэг судлаачид байна.

²⁵ Development Services Group, Inc. 2014. "Home Confinement and Electronic Monitoring." Literature Review. Washington, D.C.: Office of Juvenile Justice and Delinquency Prevention. http://www.ojjdp.gov/mpg/litreviews/Home_Confinement_EM.pdf

²⁶ Bales, William D., Karen Mann, Thomas G. Blomberg, Gerald G. Gaes, Kelle Barrick, Karla Dhungana, and Brian McManus. 2010. "A Quantitative and Qualitative Assessment of Electronic Monitoring." Tallahassee, Fla.: Florida State University, College of Criminology and Criminal Justice, Center for Criminology and Public Policy Research. <http://www.criminologycenter.fsu.edu/p/pdf/EM%20Evaluation%20Final%20Report%20for%20NIJ.pdf>

²⁷ Sklaver, Stacey L. 2010. "The Pros and Cons of Using Electronic Monitoring Programs in Juvenile Cases." Juvenile Justice Committee Newsletter, No.5. Washington, D.C.: American Bar Association.

Эдлээгүй үлдсэн хорих ялын хугацаанд зорчих эрхийн хязгаарлалт буюу цахим хяналтад байлгах нь гэр бүл, хамт олны дунд дасан зохицох, гэмт хэрэг дахин үйлдэхгүй байх боломжийг нөхцөлдүүлдэг. Жишээлбэл, Шинэ Зеландад явуулсан хяналтын төхөөрөмжийн үнэлгээний талаарх судалгаанд гэрийн хорионд гарсан ялтан уг төхөөрөмжид сэтгэл ханамж сайн байгаа бөгөөд хорих ял эдлэх үеийн дарамт, шахалт, сүрдүүлгээс хол байх, зайлсхийх боломж олгож байна гэжээ.

Аж үйлдвэрлэл, технологийн хөгжил хяналтын төхөөрөмжийн хэрэглээнд гол нөлөө үзүүлдэг бөгөөд зарим улсад ялтанд хяналтын төхөөрөмж суурилуулах, хянах ажлыг хувийн хэвшил хийх болсон байна. Үүнтэй холбоотойгоор хяналтын төхөөрөмжийг хэрхэн ашиглах талаарх сургалт явуулах, хяналтын менежментийг сайжруулах шаардлага үүсэж байгааг дурдахгүй байж болохгүй.

Харин хяналтын төхөөрөмжийн ашиглалтын зардлыг ялтан хариуцах нь хөдөлмөр эрхэлдэг, төлбөрийн чадвартай тохиолдолд асуудалгүй бөгөөд бага орлоготой, төлбөрийн чадваргүй тохиолдолд хүндээр тусаж болзошгүй юм.

2.2. Эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал

Дэлхийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн түүхэнд “зорчих эрхийг хязгаарлах ял” гэсэн нэршлээр хэрэглэж байсан түүхэн баримт байхгүй ч ялын агуулга, шинжийн хувьд төдий л ялгаатай бус “цөлөх”, “нутаг заах” ял хэрэглэж байсан уламжлал бий.

Эрх зүйн бичмэл хэм хэмжээ бүрэлдээгүй, хууль цааз батлагдан гараагүй эртний үед хүртэл хорихоос өөр төрлийн ял эдлүүлж байсан тухай түүхэн баримт байдаг. Тухайлбал, Египет, Майя, Спарт зэрэг эртний улсад хорихоос бусад төрлийн “торгууль авах, тамлах, цөлөх” зэрэг ялыг гэмт хэргийн хор уршгаас хамааруулан гэмт этгээдэд эдлүүлдэг байжээ.²⁸

МЭӨ III-МЭ IV зуун буюу Ромын эзэнт гүрний хөгжлийн оргил үед анхны бичмэл хууль, цааз батлагдаж, хорихоос өөр төрлийн ялын төрлүүд бий болж эхэлсэн бөгөөд тухайн үед (*pactio*, штраф) буюу төлбөр тооцох ял голлох байр суурь эзэлж байжээ. Харин МЭ 507-511 онд Франк, Визант, Саксон, Англи, Норманд, Германы нутгийн эзэмшил дээр төр, улс үүссэн үеэс нутгийн харьяаллаар хууль цааз тогтоох оролдлого гарчээ.²⁹ Тухайлбал, манай эриний 507-511 онд Франкийн төрийн баталсан “Салийн үнэн цааз” (*lex Salica*)-ыг баталсан нь тухайн үедээ дэвшил байсан бөгөөд тус хуульд хүн алсан этгээдэд зарим тохиолдолд торгох ял оногдуулахаар тусгасан байна. Тан улсын хаан Сюаньзуны (713-765 онд) үед эрүүгийн хариуцлагын төрөлд хорихоос өөр төрлийн ял нэмэгдсэнээр ялын олон төрөл бий болсон байдаг. Тухайн үед “банздах, цөлөх, ташуурдах, хар нүхэнд хийх, боол

²⁸ Э.Жамбалрагчаа. ИШПГЕГ-ын “Сүлд инфо” сэтгүүл. 2017, №2, 117 дахь тал.

²⁹ Мөн тэнд, 117 дахь тал.

болгох” зэрэг ял эдлүүлдэг байв. Магадгүй энэ цаг үеэс ялын төрөл болох “зорчих эрхийг хязгаарлах ял”-ын сонгомол эх, бидний нэрлэж заншсанаар “нутаг заах” буюу “цөлөх” ялыг улс орнууд эрүүгийн ялын бодлогодоо тусгаж, бусад төрлийн ял дундаас түлхүү хэрэглэх болсон гэж үзэж байна.

Английн алдарт философич Ж.Бентам XVIII зууны үед “Паноптикон” (*panopticon*) хэмээх хорих байрны загвар гаргасан бөгөөд энэхүү хорих байрны онцлог нь байгууламжийн гол цамхагт ганцхан харуул байх ба харуул хаашаа харж байгааг хоригдол мэдэх боломжгүй, гагцхүү хяналтад байгаа гэсэн сэтгэл зүйд тулгуурлан хорих байрыг зохион байгуулах санаа дэвшүүлсэн.³⁰ Зарим судлаачид Ж.Бентамын энэ загвар шинэ үеийн зорчих эрхийг хязгаарлах ял, цахим гавын талаарх үзэл санаа бүрэлдэх суурь болсон гэж үздэг ажээ.

XX зууны 2-р хагас буюу 1960-аад оноос АНУ-ын Харвардын их сургуулийн нийгмийн сэтгэл зүйн салбараас электрон хяналтын төхөөрөмж (цахим гав) нь эрүүгийн шүүхийн тогтолцооны чухал хэсэг болох тухай санаа дэвшүүлжээ. Тухайн үед Харвардын сэтгэл зүйн салбарт Роберт, Кирк Габле нар алдартай сэтгэл зүйчид болох Скиннер, Тимоти Лири нарын удирдлага дор суралцаж, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон өсвөр насны хүүхдийн хөдөлгөөнийг хянах тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр судалгаа явуулан, дээрх хүмүүсийн байршлыг цаг тухайд нь мэдэх боломж эрэлхийлж байжээ. Ингэхдээ хуучны цэргийн төхөөрөмжийг суурь болгон ашиглаж, төхөөрөмж зүүсэн үед тухайн байршлыг хаана ч байсан дамжуулж байжээ.³¹ Хэдийгээр зорчих эрхийг хязгаарлах ял хэрэглэх техник, технологийн боломж, үндэс суурь 1960-аад оны үед тавигдсан ч уг ялыг шүүхийн практикт хэрэглэх хүртэл 20 орчим жил болсон юм.

1983 онд АНУ-ын Нью-Мексико мужид энэ ялыг анх хэрэглэсэн бол үүний дараа Флорида муж түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр эхлүүлж, улмаар 1980-аад оны сүүл гэхэд АНУ-ын олон муж зорчих эрхийг хязгаарлах цахим гав, электрон хяналт хэрэглэх олон янзын хөтөлбөр эхлүүлэн³², 1987 он гэхэд уг ялаар шийтгүүлэгсдийн тоо 826³³, 1997 онд 75.000³⁴, 1998 онд 95000 болжээ.³⁵ Үүний дараа Канад, Австрали, Сингапур, Израил зэрэг улс өөрсдийн онцлогт тохирсон хөтөлбөр боловсруулж эхэлсэн байна.³⁶ Харин

³⁰ Нээлттэй Нийгэм Форум. “Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам (Харьцуулсан судалгаа)” судалгааны тайлан. УБ., 2016.

³¹ Emma Anderson. The Evolution of Electronic Monitoring Devices. <http://www.npr.org/>.

³² Jolin/Rogers, Journal of Contemporary Criminal Justice. 1989, p.141; Schmidt, Journal of Contemporary Criminal Justice 1989, p.138.

³³ A. K. Schmidt, “Use of Electronic Monitoring by Criminal Justice Agencies” (Washington, D.C.: Report for National Criminal Justice Research Service, 1988).

³⁴ Offender electronic technology. Community Corrections Resource [second edition]. Bureau of Justice Assistance U.S. Department of Justice. 2005, p.16.

³⁵ National Law Enforcement and Corrections Technology Center, Online Bulletin, National Institute of Justice (1999).

³⁶ RITA HAVERKAMP. Implementing Electronic Monitoring A comparative, empirical study on attitudes towards the measure in Lower Saxony/ Germany and in Sweden. p.13.

Европын улсуудад нэвтрүүлэхэд нэлээд удаашралтай байжээ.

Европын улсуудаас анх Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс 1989 онд шүүхийн өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээний төрөл хэлбэрээр цахим гав, электрон хяналтын хөтөлбөр туршиж эхэлсэн байна.³⁷

1990-ээд оны эхэн үед Нидерланд, Швед зэрэг улсад хорих ял эдэлж буй хоригдлын тоо илэрхий өсөх болсон³⁸ бөгөөд тэдний дунд хүч хэрэглэсэн, хар тамхи, мансууруулах бодисын хууль тогтоомж зөрчсөн гэмт хэрэгт холбогдсон хоригдлууд дийлэнх нь байсны зэрэгцээ хугацаанаас өмнө суллах эрх зүйн орчин хязгаарлагдмал байжээ. Тухайн цаг үеэс дээрх хоёр орон эрүүгийн ялын бодлогодоо томоохон шинэчлэл хийж, ял шийтгэлийн бодлогыг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн, цахим гав, электрон хяналтын төхөөрөмж хэрэглэж эхэлсэн байна.

Удалгүй Баруун Европын бусад улсад нэвтэрч, Бельги, Герман, Франц, Итали, Португал, Швейцар зэрэг улсын шүүх цахим гав хэрэглэн зорчих хөдөлгөөнд хяналт тавих ял оногдуулах болжээ.

1990-ээд оноос дэлхийн улс орнуудын эрүүгийн ялын бодлогод зорчих эрхийг электрон хяналтын төхөөрөмж, цахим гавын тусламжтайгаар хязгаарлах ял хэрэглэх байдал нэмэгдэж, томоохон байр суурь эзлэх болсон ба³⁹ GPS төхөөрөмжийн тусламжтайгаар ялтанд хяналт тавих боломжтой болсноор тодорхой бүс нутаг, чиглэлийн хүрээнд хяналт тавих болжээ.⁴⁰ Мэргэжилтнүүдийн судалснаар 2014 оны байдлаар АНУ-д 160.000 төхөөрөмж хэрэглэж байгаагийн тал хувийг GPS төхөөрөмж, үлдсэн хувийг нь RT төхөөрөмж эзэлж байна.⁴¹

АНУ-ын агаарын цэргийн хүчин GPS (*general positioning system*) буюу хиймэл дагуулын тусламжтайгаар байршил тогтоох технологи бүтээсэн нь иргэний хэрэглээнд нэвтэрч эхэлсэнтэй зэрэгцэн зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлэхэд GPS технологи хэрэглэж эхэлжээ.

Дэлхийн тойрог замд байгаа хиймэл дагуулын тасралтгүй дохио хүлээн авч дамжуулах технологид суурилан ажилладаг GPS технологийн тусламжтайгаар бүтээгдсэн электрон гав зүүсэн хүнийг зөвхөн гэрт нь байрлуулсан төв дамжуулагчийн радиусаар бус, тодорхой замын дагуу бүтэн цагийн хяналт тавих боломж нь энэхүү ялын хэрэглээг шинэ түвшинд гаргасан байна.

³⁷ G Mair; C Nee. Electronic Monitoring: The Trials and Their Results. 1990. <https://www.ncjrs.gov>.

³⁸ Compare the overview of the average prison population of Walmsley 1998.

³⁹ Haverkamp, in: Neue Kriminalpolitik 1999/4, p.4.

⁴⁰ James Kilgore. Electronic Monitoring Is Not the Answer Critical reflections on a flawed alternative. Urbana-Champaign Independent Media Center A part of the Media Action Grassroots Network (MAG-Net). 2015, p.8.

⁴¹ Interview with George Drake, President of Correct Tech, LLC, September 3, 2014, and July 30, 2015.

2.2.1. Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн хүний зорчих эрхийг хязгаарлаж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлал

Зорчих эрхийг хязгаарлах ял нь манай улсын хууль тогтоомжийн түүхэнд байгаагүй боловч иргэний оршин суух газраа чөлөөтэй сонгох, зорчих эрхэд хязгаарлалт тогтоож байсан түүхийн эх сурвалж байна. Тухайлбал, цөлөх, уг нутгаас зайлуулах зэрэг ял хэрэглэж байсан практик бий. Эдгээр ял нь тухайн этгээдийн зорчин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг хөндөж байгаагаараа зорчих эрхийг хязгаарлах ялтай төстэй гэж үзлээ.

■ “Их засаг” хууль

Академич Ж.Болдбаатар, профессор Д.Лүндээжанцан нар “Их засаг” хууль бол дэлхийн соёл иргэншлийн түүхийн бүхэл бүтэн нийгэм, улс төрийн байгуулал бүрэлдэн төлөвшихөд томоохон үүрэг гүйцэтгэсэн Эртний Вавилоны Хаммурапийн хууль, Энэтхэгийн Манугийн алдартай хуулиудтай эн зэрэгцэхүйц ач холбогдолтой цаазын нэн чухал баримт бичиг юм”⁴² гэж үнэлсэн байдаг.

“Их засаг” хуулиар хэдэн төрлийн ял хэрэглэхээр зааж байсан талаар судлаачдын дунд нэгдсэн ойлголт тогтоогүй хэдий ч профессор Г.Совд “цаазаар авах, ташуураар занчих, **цөлөх**, гянданд хорих”,⁴³ АНУ-ын эрдэмтэн Ж.Вернадский “цаазаар авах, гяндлах, **цөлөх**, ташуурдах ба шийдэмдэх, торгох, хөрөнгө хураах”⁴⁴ ял оногдуулж байсан хэмээн тус тус судлан дүгнэжээ.

■ Юань улсын нэвтэрхий хууль

“Их засаг” хуулийн дараах, түүний агуулга, зарчмыг хадгалсан хууль цаазын чухал эх сурвалж нь 1320 онд батлагдсан Их Юанийн нэвтэрхий хууль, Их Юанийн хууль зүйлийн бичиг (1271), Ертөнцийг засах магад хууль зэрэг юм. Юань улсын хуульд:

1. Туйвандах (богино банзаар 57 хүртэл занчих);
2. Чавчрагдах (сурт банзаар 6717 хүртэл занчих);
3. Дөнгөлөх;
4. Үйлтгүүлэх (биеийн хүнд хүчир ажил хийлгэх);
5. **Цөлөх** (энэ ялаар шийтгүүлэгчдийг байнга оршин суугаа газраас нь алс хол бөгөөд газар зүйн хувьд дордуулсан орчин, хатуу хараа хяналтад байлгах);
6. Алах гэсэн ялын төрлийг заажээ.⁴⁵

⁴² Э.Авирмэд, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997, 77 дахь тал.

⁴³ Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. УБ., 1973, 28 дахь тал.

⁴⁴ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (Ерөнхий анги). УБ., 2002, 36 дахь тал.

⁴⁵ Г.Гантөмөр, С.Гантулга нар. Эрүүгийн эрх зүй (Ерөнхий анги). УБ., 2020, 54 дэх тал.

■ Монгол-Ойрадын цаазын бичиг

Нэгдсэн улсын бутралын үед хамаарах хууль цаазын бичиг бол Монгол-Ойрадын цаазын бичиг юм. Тус цаазын бичигт олон төрлийн ялыг хуульчилж өгсөн ба тухайлбал, алах, хөрөнгө хураах, ураг төрлийг хаах, эхнэр хүүхдийг нь хоосруулан хөөх, цаазаар авах, эрхтнийг нь гэмтээх, хэрэгтнийг хоосруулах, газар нүхэнд хорих, мод ташуураар жанчих, мал, үнэт зүйлээр торгох, албан тушаал бууруулах, гэмт этгээд хохирогчийн талд биеэ тушаах, **цөлөх**, мөчийг нь эрүүдэх, баривчлах, гутаах, шахаа зэрэг төрөлтэй байсан⁴⁶ талаар судлаачид дурдсан.

■ Халх журам

Халх журмыг Монгол Манжид эзлэгдсэнээс хойш 18 жилийн дараа буюу 1709-1795 оны хооронд халхын ноёд, төр, шашны том зүтгэлтнүүд 20 гаруй удаа цугларан хуралдаж, хэлэлцэж тогтоосон гэдэг. Халх журамд цаазаар авах, ташуурдах, **цөлөх**, хорих, хэргэм зэрэг эвдэх, торгох, хөрөнгө хураах зэрэг ял хэрэглэж байжээ.⁴⁷

■ Монгол цаазын бичиг

Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг нь Манж Чин улсын үеийн эрүүгийн эрх зүйн түүхэн эх сурвалж юм. Монгол цаазын бичиг өөртөө гэмт хэргийн ойлголт, төрөл, оногдуулах ялын төрөл, хэмжээ, гэмт хэрэгтний насны хязгаар, хөөн хэлэлцэх хугацаа зэрэг орчин үеийн эрүүгийн эрх зүйн ойлголт багтаасан.

Монгол цаазын бичигт торгох, цаазаар авах, **цөлөх**, албадан ажил хийлгэх ялыг үндсэн ялын чанартайгаар, эд хөрөнгө хураах, боол болгох, жанчих, дөнгө зүүлгэх, ташуурдах, хэргэм зэрэг, албан тушаалын зэрэг бууруулах, пүнлүү хасах ялыг нэмэгдэл шинжтэйгээр хэрэглэж байжээ.⁴⁸

■ “Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм” (1913-1919)

Богд хаант Монгол Улсын Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яамны “Олноо өргөгдсөний тэргүүн оноос нааш олон яамнаас айлтгаад тогтоосон ба тусгайлан зарлиг буулгаж нийтээр дагаж буй хэргийн товчоо дэвтэр” хэмээх данс бүртгэлд 1911 оноос 1917 оны 4-р сар хүртэлх хугацаанд хааны зарлигаар тогтоосон хууль цаазын шинжтэй 63 бичиг бүртгэгдэж байжээ.⁴⁹ Тэдгээрийн нэг нь 1913-1919 оны хооронд “Таван яам хамт нийлж хувьсган тогтоож айлтгаад, одоогийн дагаж явах хууль, дүрмийн дэвтэр бичиг” буюу “Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм” хэмээх 12 зүйл бүхий эрх зүйн актыг эмхэтгэн мөрдөж байжээ.⁵⁰

⁴⁶ Э.Авирмэд, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1997, 75 дахь тал.

⁴⁷ С.Нарангэрэл. Халх журам Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэн тулгуур эх сурвалж болох нь. ЭШХ-ийн эмхэтгэл. УБ., 1999, 42 дахь тал.

⁴⁸ Б.Баярсайхан. Монгол цаазын бичиг. УБ., 2001, 99-133 дахь тал.

⁴⁹ Б.Содовсүрэн. Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз. 1911-1920. УБ., 1989, 56 дахь тал.

Богд хаант Монголын хууль цаазын бодлогоор дараах ял шийтгэл оногдуулдаг байжээ. Үүнд:

1. Хөвчдөн алах;
2. **Цөлөх**;
3. Торгох (малаар);
4. Занчих;
5. Үйлтгэх ял буюу албадан ажил хийлгэх;
6. Дөнгөлөх гэсэн ял оногдуулдаг байв.

■ Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг⁵¹

“Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” хэмээх хууль цаазын эх сурвалжийг зохиолгохоор 1915 онд Богд хааны зарлигаар комисс байгуулж, Манж Чин улсын үеийн “Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах явдлын яамны Хууль зүйлийн бичиг” болон бусад хуулийг нягтлан монгол хэлээр орчуулж таван дэвтэрт нэгтгэн, 1918 онд уг хуулийг хэлэлцэн баталжээ.⁵²

Хууль зүйлийн бичигт ташуур занчих ялыг 160 зүйлд, дөнгө дөнгөлөх ялыг 82 зүйлд, пүнлүү хасах ялыг 29 зүйлд, торгох ялыг 56 зүйлд, **цөлөх** ялыг 17 зүйлд, хөрөнгө хураах ялыг 2 зүйлд, цаазаар авах ялыг 48 зүйлд тусгасан байна.

■ Ардын хувьсгалын дараах үеийн эрүүгийн хууль тогтоомж

МАХН-ын анхны программ хэмээх удирдамжийн баримт бичигт хувьсгалын эхний жилүүдэд хуучин ёс журмыг халж, шинэ журам тогтоохдоо “эрх биш боловсрол нь дундад зууны үеэс дэмий хол өнгөрөөгүй бүхнийг харгалзуулж эдүгээгийн байдлыг зүйгээр шинэчлэн халах явдлыг үйлдвэл зохино”⁵³ гэжээ.

1922 оны 3 дугаар сарын 3-нд гаргасан захирах, захирагдах журмын тогтоолд “...ардын эрхт хэмжээт цаазат засгийн ёсон болбоос захирах захирагдахын ёсон ба эрүү шүүлт яллах, залхаахыг бүрнээ устгасан бус гагцхүү дээдэс нь доордыг учиргүйгээр эзэрхэж дарлах ба доордос нь мөн түүний эрх сүрд дарагдаж өгүүлэх газаргүй болон зүдэж дарлагдах муу суртлыг халж, ард түмэнд эрх чөлөө олгосон нь болой”⁵⁴ гэж тодорхойлжээ.

Ардын Засгийн газар 1921 оны 7 дугаар сарын 16-ны 4 дүгээр хурлын 8 дугаар тогтоолын 10, 11 дүгээр зүйлд тус улсад оршин сууж буй гадаадын харьяат ба ОХУ-ын харьяат хүнийг Монголын хуулиар шийтгэх, хэрэгт

⁵⁰ Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумьяацэрэн. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). УБ., 2011, 19 дэх тал.

⁵¹ Б.Баярсайхан, С.Жанцан нар. Дурдсан бүтээл. УБ., 2011, 36 дахь тал.

⁵² Ж.Урангуа, Б.Баярсайхан. Жинхэнэ дагаж явах хууль дүрэм (1913-1918). Эх бичгийн судалгаа. УБ., 2004, 10 дахь тал.

⁵³ БНМАУ-ын түүх. УБ., 1984, 363 дахь тал: МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ., 1966, I дэвтэр, 17 дахь тал.

⁵⁴ МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. I боть. УБ., 1996, 124 дэх тал.

холбогдогчийн гэм бурууг тогтоохдоо эд мөрийн баримт, гэрчийн мэдүүлгийг баримтлах, бие махбодыг зовоох, эрүү шүүлт хэрэглэхийг хоригложээ.⁵⁵

Засгийн газрын 1921 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 8 дугаар хурлын “Эрүү шүүлтийн тухай” тогтоолын 10 дугаар зүйлд “Аливаа гадаад, дотоодын хүмүүсийн эрүү шүүлтийн тухай хэлэлцээд аливаа гадаадын хүнтэй холбогдсон монгол хүнийг гадаадын хүний адил эрүү шүүлт хүлээлгэхгүй, эд мөр, хөндлөнгийн гэрчийг баримтлан шийтгэсүгэй. Дан ганц монгол хүн гэрээ, гэрчгүйд хэргийг хүлээхгүй бол юуны урьд эрүү шүүлт хэрэглэхгүйгээр үнэнийг олохыг хичээх ба хэрэв үнэн өчиг илрэхгүйд хүрвэл шүүлтийг зохисыг нь үзэж хэвээр хэмнэн хэрэглэхээр тогтов”. Тогтоолын 11 дүгээр зүйлээр хуучин хуульд байсан алах, цөлөх, дөнгө дөнгөлөх, пүнлүү хасах, золио авах ялыг хувьсгаж хорих, торгох ял болгон өөрчилсөн.

1921 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн Ардын Засгийн газрын хурлын 9 дүгээр тогтоолын 5 дугаар зүйлд “Эх орноосоо урвах гэмт хэргээс бусад гэмт хэрэгт алах, **цөлөх**, дөнгөлөх ялыг өөрчилж алах ялыг 10 жил хорих, алгуурлан алах ялыг 7 жил хорих, улсын хязгаарт цөлөх ялыг 3 жил хорих, зэргэлдээ аймагт цөлөх ялыг 1 жил хорих” ял болгон өөрчилж, ял эдлэх хугацаанд нь хоригдлоор хөдөлмөр хийлгэх болгожээ.⁵⁶

Нэг. 1926 оны Шүүх цаазын бичиг

1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр БНМАУ-ын анхны Эрүүгийн хууль буюу “Шүүх цаазын бичиг”-ийг батлан хэрэгжүүлж иржээ. Уг цаазын бичигт ялын төрлийг хуульчлахдаа онц аюултай гэмт хэрэгтнүүдэд шүүх цаазын бичгийн тусгай ангид хэрэглэхээр заасан алах, 1 өдрөөс 10 жил хүртэл хугацаатай албадан хөдөлмөрлүүлэх явдалтай хослуулан хэрэглэх хорих, 100 өдрөөс хэтрэхгүй хугацаатай засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, хөрөнгө хураах, 10 төгрөгөөс дээш хэмжээтэй торгох, албан тушаалаас огцруулах, БНМАУ-ын нутгаас хөөн зайлуулах, шүүхээс донгодох, аливаа эрхийг бүрэн, эсхүл заримыг хугацаагаар юм уу үүрд эвдэх буюу **уг газраас бусад газарт шилжин явах эрхийг үүрд эвдэх** зэрэг үндсэн ба нэмэгдэл ял тогтоож өгсөн байна.

Хоёр. 1929 оны Шүүх цаазын бичиг

Монгол орныг капиталист бус замаар хөгжүүлэх талаар МАХН-ын V, VI хурлаас дэвшүүлсэн зорилтыг шийдвэрлэх, улс оронд бий болсон дотоод, гадаадын нөхцөл байдал, хурцадмал байдлыг намжаах чухал нөхцөл болох хувьсгалт хууль ёсыг бэхжүүлэх, аливаа дайсагнасан үйл ажиллагааны эсрэг үр дүнтэй тэмцэл явуулах зорилгоор хууль цааз, тэр тусмаа эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгарсан байна.

⁵⁵ Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. УБ., 1954, 127-128 дахь тал.

⁵⁶ Б.Баярсайхан, С.Жанцан нар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). УБ., 2011, 78 дахь тал.

Ийм учраас 1929 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Засгийн газрын 30 дугаар хурлаар Шүүх цаазын бичгийг шинэчлэн баталж, 1926 оны хуулийг хүчингүй болгосон байна. 1929 оны Шүүх цаазын бичигт аливаа эрхийг бүрэн, эсхүл заримыг хугацаагаар юм уу үүрд эвдэх гэсэн заалтыг хасаж **уг газраас бусад газарт шилжин явах эрхийг 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хасахаар** хязгаартай тогтоож хүний эрхийг хангаж өгсөн байна.

Гурав. 1934 оны Шүүх цаазын бичиг

Улсын Бага Хурлаас 1934 оны 5 дугаар сарын 24-нд Шүүх цаазын бичгийг батлан гаргажээ.

Уг хуульд буудан алах, хорих, албадан ажил хийлгэх, улс төрийн болон хувийн зарим эрхийг 1-5 жилийн хугацаагаар хасах, **нутаг зайлуулах буюу нутаг зааж суулгах**, албан тушаалаас огцруулах буюу ажлаас хөөх, донгодох буюу олон нийтийн өмнө буруутгах, хөрөнгийг бүрэн юм уу заримыг хураах, мөнгө торгох, учруулсан гэм хорыг арилгах үүрэг даалгах, гадаадын иргэдэд бол улсын хязгаараас хугацаагаар юм уу бүр мөсөн хөөх гэж ялын тодорхой төрлүүдийг хуульчилсан төдийгүй эмнэлгийн чанартай албадах болон сурган хүмүүжүүлэх албадлагын арга хэмжээг нарийвчлан тогтоожээ.

Дөрөв. 1942 оны Эрцүгийн хууль

Улсын Бага Хурлаас 1942 оны 1 дүгээр сарын 17-нд тус хуулийг баталсан ба уг хуульд хорих ялыг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагерьт байлгаж ял эдлүүлэх, хорихгүйгээр албан ажил хийлгэх гэж өөрчлөн найруулж, буудан алах ялыг хувьсгалт төр засаг хийгээд улс нийтэд онц аюултай хүнд гэмт хэрэг үйлдэгчдэд оногдуулах онцгой арга болгосон байна. Түүнчлэн эцэг эх байх эрхийг хасах, тэтгэвэр авах эрхийг хасах зэрэг шийтгэл хэрэглэж байхыг шинээр тодорхойлон, **нутаг зааж суулгах** ял хэрэглэж болох гэмт хэргүүдийг шууд нэрлэн зааж өгсөн байна.

Тав. 1961 оны Эрцүгийн хууль

1961 оны Эрүүгийн хуульд буудан алах, хорих, **нутаг зааж суулгах, уг нутгаас зайлуулах**, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох, торгох, олон нийтийн өмнө буруушаах зэрэг ялын төрөл байсан байна.

Дээрх ялын төрлүүдээс нутаг зааж суулгах ял шийтгүүлсэн этгээдийг оршин суугаа нутгаас нь хугацаатайгаар зайлуулан тодорхой нутаг зааж суулгах ба үндсэн болон нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна. Нутаг заан суулгагдсан этгээдийг хөдөлмөрт хамруулах ажлыг тухайн орон нутгийн Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргаа хариуцдаг байсан бол уг нутгаас зайлуулах ял шийтгүүлсэн этгээдийг оршин суугаа нутгаас нь хугацаатай албадан зайлуулж, үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна. Нутаг зааж суулгах ял шийтгүүлсэн этгээд уг нутагт

очих замаасаа оргох буюу зааж суулгасан нутгаас оргон зайлсхийвэл гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.⁵⁷

Нутаг заах ялын зорилго нь ялтныг гэмт хэрэг дахин үйлдэх орчны нөхцөлөөс тусгаарлаж, тэр этгээдийн нийгмийн эсрэг зан төлөв, сөрөг нөлөөллөөс бусдыг урьдчилан сэргийлэхэд оршино гэжээ. Нутаг заагдсан этгээд тогтоосон хугацааны дотор тэрхүү нутгаас гадагш гарч явах эрхгүй бөгөөд энэ нь ялтны засрал хүмүүжилд эерэг нөлөө үзүүлж чадна гэж үзсэн нөхцөлд уг ялыг оногдуулдаг байжээ.

Нутаг заах ялыг нэмэгдэл ял болгон оногдуулахдаа үндсэн ялыг эдэлж дууссаны дараа эдлүүлдэг бол ялтан засран хүмүүжихэд нийгмээс тусгаарлан хорих ял оногдуулах шаардлагагүй гэж үзвэл үндсэн ялын чанартай хэрэглэдэг байжээ. Нутаг заах ялыг гэмт хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан этгээд, 8 хүртэлх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэйчүүдэд оногдуулахыг хориглосон байна.

Харин уг нутгаас зайлуулах ялыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн оршин байгаа тодорхой нутгийн орчин нь түүний цаашид дахин гэмт үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд нь нөлөөлөх юм уу эсхүл уг этгээд оршин суудаг нутагтаа байх нь бусад хүмүүсийг гэмт хэргийн замд татан оруулж болох муу нөлөөтэй нөхцөлд үндсэн болон нэмэгдэл ялын аль нэг хэлбэрээр оногдуулахаар зохицуулжээ.⁵⁸ Уг нутгаас зайлуулах ял нь ялтны тодорхой нутагт оршин суух эрхийг шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хасдаг учир заасан нутагт эргэж ирэх эрхгүй, харин оршин суух нутгаа сонгох эрхтэй байдаг байна.

Энэхүү ялыг ялтан засарч хүмүүжихэд нийгмээс тусгаарлан хорих ял оногдуулах шаардлагагүй гэж үзвэл үндсэн ялын чанартай хэрэглэдэг бол нэмэгдэл ял болгон оногдуулсан тохиолдолд үндсэн ялыг эдэлж дууссаны дараа эдлүүлдэг. Мөн нутаг зайлуулах ялыг гэмт хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан этгээд, 8 хүртэлх насны хүүхэдтэй болон жирэмсэн эмэгтэйчүүдэд оногдуулахыг хориглодог бөгөөд хоёр жилээс доошгүй, таван жилээс дээшгүй хугацаагаар оногдуулдаг зэрэг нь нутаг зааж суулгах ялтай ижил юм.

Зургаа. 1986 оны Эрүүгийн хууль

1986 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь бүтэц, хэлбэрийн хувьд өмнөх хуулиас харьцангуй сайжирсан хууль боловч социалист өмчийн харьцааг хамгаалан дэмжих, төлөвлөгөөт эдийн засаг, захиран тушаах дэглэмийн тогтвортой байдлыг албадлагаар баталгаажуулахад чиглэсэн заалт хадгалагдаж үлдсэн.⁵⁹

⁵⁷ Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн эрх. УБ., 1969.

⁵⁸ БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 1989, 39 дэх тал.

⁵⁹ Б.Баярсайхан, С.Жанцан нар. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). УБ., 2011, 105-109 дэх тал.

Уг хуульд ялын төрлийг хорих, **нутаг заах, уг нутгаас зайлуулах**, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, торгох, сахилгажуулах ангид явуулах, олон нийтийн өмнө буруушаах, эд хөрөнгө хураах, цэргийн болон тусгай алдар цолыг хасах зэргээр хуульчилж өгчээ.

Дээрх ялын төрлүүдээс **нутаг заах** ялыг ялтныг оршин суугаа газраас нь зайлуулан тодорхой нутагт албадан суулгахыг хэлэх ба үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна. Нутаг заан суулгагдсан этгээдийг хөдөлмөрт хамруулах ажлыг тухайн орон нутгийн Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргаа хариуцдаг байсан бол уг нутгаас зайлуулах ял гэдэг нь ялтанд тодорхой нутагт оршин суухыг нь хориглож, оршин суугаа газраас нь зайлуулахыг хэлэх ба үндсэн ба нэмэгдэл ялын шинжтэйгээр 2-5 жилийн хугацаагаар тогтоодог байсан байна.

■ 1990-2015 он хүртэлх эрүүгийн хууль тогтоомж

Нэг. 1993 оны Эрцүгийн хууль

1992 оны Үндсэн хууль нь Монголын ард түмний амьдралд түүхэн эргэлт хийж, эх орондоо иргэний, ардчилсан, хүмүүнлэг нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг тунхагласан билээ. Энэхүү Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн Улсын Их Хурлаас Эрүүгийн хуульд 1993 оны 2 дугаар сарын 15, 6 дугаар сарын 7-ны өдрүүдэд томоохон өөрчлөлт хийсэн юм. Уг хуульд ялын төрлийг торгох, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, хорих, цаазаар авах гэж тогтоон, нутаг заах, уг нутгаас зайлуулах, олон нийтийн өмнө буруушаах зэрэг ялыг хүчингүй болгожээ.

Хоёр. 2002 оны Эрцүгийн хууль

Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр Эрүүгийн хуулийг ерөнхий, тусгай ангиас бүрдсэн 11 хэсэг, 30 бүлэг, 305 зүйлтэйгээр баталсан бөгөөд хэрэгжих явцдаа 13 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон байна. Уг хуульд торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах гэсэн ялын төрлүүдийг хуульчилсан. 2002 оны Эрүүгийн хуульд хүний зорчих эрхийг хязгаарлахтай холбоотой ял, шийтгэл тусгагдаагүй.

Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдийн чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж ирсэн түүхэн баялаг уламжлалтай гэж үзэж болно. Харин “Зорчих эрхийг хязгаарлах ял” гэж нэрлэн, цахим хяналт тавих ажиллагааг хуульчлан, хэрэгжүүлэх практик нь эхлэлийн шатандаа явж байна гэж үзлээ.

2.3. Гадаадын зарим орны туршлага

2.3.1. Америкийн Нэгдсэн Улс

Тус улс сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хяналтын төхөөрөмж, цахим гав ашиглан хяналт тавьж ирсэн ба сүүлийн жилүүдэд хяналтад байгаа хүний тоо өссөөр байна.⁶⁰

АНУ-д гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмд нь хянах хөтөлбөрийн 20 гаруй хувьд хяналтын төхөөрөмж ашигладаг гэсэн судалгаа байна. Тус улсад зорчих эрхийн хязгаарлалтыг хянах төхөөрөмж, цахим гав нь дараах гурван нөхцөлд хэрэглэгдэж байна:

1. Шүүхийн өмнөх үе;
2. Ял оногдуулах үе;
3. Хугацаанаас өмнө суллах үе.

Шүүхийн өмнөх үеийн хяналтад анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүн хамрагддаг ба хэрэг шийдвэрлэх хүртэл хугацаагаар хяналтад байлгаж байгаа нь манай улсын таслан сэргийлэх арга хэмжээтэй төстэй байна.

Хугацаанаас өмнө суллах үе шатанд хорих газраас суллагдаж байгаа этгээдийг хамруулан, зорчих эрхийг нь хязгаарлаж, хяналтын хугацаа дуусах хүртэлх хугацаанд төхөөрөмжийн хяналтад байлгадаг. Зорчих эрхийн хязгаарлалтад байгаа ялтны төрлөөс хамааран ямар хязгаарлалт, хяналтад байлгах нь өөр өөр байна. Энэ нь энгийн хөл хорионы цаг тогтоох болон хөдөлгөөнийг нь бүрэн хязгаарлах гэсэн хоёр шатлалтай.⁶¹

Эхний шатлал буюу энгийн хөл хорио нь тухайн этгээдийг тодорхой цагийн турш гэртээ байхыг шаарддаг. Хоёр дахь шатлал нь тухайн этгээдийг гадагш гарахыг урьдчилан зөвшөөрч, тодорхой хугацаанаас бусад хугацаанд гэртээ байхыг шаарддаг ба гадагш гарахыг зөвшөөрсөн хугацаанд (09:00-19:00 цагийн хооронд) хөдөлмөр эрхлэх, сургуульд сурах, эмчилгээ хийлгэх, сүмд очих, өмгөөлөгчтэйгөө уулзах, шүүх хуралдаанд оролцох болон шүүхийн бусад шийдвэрийг биелүүлэх боломж олгодог.

Зорчих эрхийн хязгаарлалтын хамгийн хүнд хэлбэр нь шүүх хуралдаанд оролцох, эмнэлгийн тусламж авахаас бусад хугацаанд 24 цагийн турш гэртээ байхыг шаарддаг.⁶²

Хяналтын төхөөрөмж ашиглан зорчих эрхийг хязгаарлах хяналт хэрэглэх нь хэд хэдэн ашигтай талтай гэж тус улсын судлаачид үздэг. Энэ нь зорчих эрхийн хязгаарлалт болон хяналтын төхөөрөмжийг дэмжигчид ут

⁶⁰ Ralph K., and Robert S. Gable. 2005. "Electronic Monitoring: Positive Intervention Strategies." Federal Probation 69(1). Kansas Department of Corrections. 2014. House Arrest-Juvenile Corrections. Olathe, Kan.: Johnson County Department of Corrections.

⁶¹ Darren. 2000. "Overview of the Federal Home Confinement Program 1988-1996." Federal Probation 64(2): 11-18.

⁶² Darren. 2000. "Overview of the Federal Home Confinement Program 1988-1996." Federal Probation 64(2): 11-18.

төхөөрөмж, хөтөлбөр нь санхүүгийн хэмнэлттэй, гэмт хэрэг дахин үйлдэх явдлыг бууруулдаг, ял сонгох хэлбэр бий болгодог, ялтны байрлаж байгаа газрыг тухай бүр хянах боломж олгодог зэрэг ашиг тусыг дурдан, хамгийн гол нь хоригдлын тоог багасгах бөгөөд хорихтой холбогдон гарах өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг бууруулдаг гэжээ.

Санхүүгийн хэмнэлтийн ашиг тус нь татвар төлөгчийн мөнгө болон хорих газар, тухайн гэмт этгээдэд гаргах зардлыг хэмнэдэг. Бодит зардлын хэмнэлтийг хоёр ял хэрэгжүүлэх зардалтай харьцуулж үзвэл зорчих эрхийг хязгаарлах ялыг хаана хэрэгжүүлж байгаагаас үл хамааран өдөрт дунджаар 5-10 доллар зарцуулдаг бол хоригдолд нэг өдрийн 100-160 доллар зарцуулдаг байна. Түүнчлэн зорчих эрх нь хязгаарлагдсан гэмт этгээд ажил хийн, хяналтын төхөөрөмжийн түрээс болон ашиглалтын зардал төлж байгаа нь төсвийн хэмнэлтэд ихээхэн дөхөм үзүүлдэг ажээ.⁶³

2.3.2. Австралийн Холбооны Улс

Өмнөд, хойд Австралийн эрх зүйн тогтолцоонд хорих ялыг зарим тохиолдолд хяналтын төхөөрөмжийн хяналтад гэрийн хорионд эдлэхийг зөвшөөрсөн хууль хэрэгждэг. Хойд Австралийн 1995 оны Ял эдлүүлэх тухай хуульд ялтныг ял эдлэх хугацаанд нь гэрт нь үргэлжлүүлэн хорьж, үлдсэн ялыг эдлүүлж болохоор заан, хяналтын төхөөрөмж зүүхийг шаарддаг. Түүнчлэн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг хохирогчоос тусгаарлах, хамгаалахын тулд хорио тогтоох хэлбэрээр ашиглаж байна.

Австралийн Хүний эрхийн комисс хорих ялаар шийтгүүлсэн хүнийг хорилгүйгээр, хяналтын төхөөрөмжийн хяналт дор ял эдлэх сонголт өгөх ёстой хэмээн зөвлөдөг.

Баруун Австралид шүүх хуралдаанаас өмнө хяналтын төхөөрөмж ашиглаж болох талаар зохицуулалт байдаг ба 1982 оны Батлан даалтын тухай хуульд зарим тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэгч офицерын хяналт дор сэжигтэн, яллагдагчийг гэрийн хорионд хорихыг хүлээн зөвшөөрдөг.

Түүнчлэн Өмнөд Австралид хорих ял эдлэх сүүлийн 6 сарын хугацаанд хяналтын төхөөрөмж ашиглан суллаж болдог ба ялтан уг хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ гаргах эрхтэй.⁶⁴

Баруун Австралийн 1995 оны Захиргааны хяналтын тухай хуульд зааснаар ялтан цахим хяналтын төхөөрөмжийг байрлаж амьдрах газар болон биедээ суулгах, суурилуулахыг өөрөө зөвшөөрсөн байх шаардлагатай ба шүүх ялтныг байнгын хяналтад байлгах шийдвэр гарган гэр, эсхүл биед нь хяналтын төхөөрөмж суурилуулдаг байна.

⁶³ Sklaver, Stacey L. 2010. "The Pros and Cons of Using Electronic Monitoring Programs in Juvenile Cases." Juvenile Justice Committee Newsletter, No.5. Washington, D.C.: American Bar Association.

⁶⁴ Matt Black and Russell G.Smith. Electronic Monitoring system in Criminal Justice. Australian institute of Criminology.Canberra, 2003, p.3.

2.3.3. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

Английн болон Уэльсийн Эрүүгийн шүүхийн тухай хуулийн дагуу шийтгүүлсэн хүмүүст 2003 оноос гэрийн хөл хорио тогтооход цахим бугуйвч хэрэглэж эхэлсэн. Англи даяар цахим хяналтын хэрэглээ эрс нэмэгдэж, 1999-2000 онд 9000, 2004-2005 онд 53,000 болтлоо өсжээ. 2004-2005 онд Английн Дотоод хэргийн яам цахим хяналтад 102,3 сая фунт стерлинг зарцуулсан бөгөөд тухайн зардлыг хорих ялын зардлаас бага гэж үзжээ. Ялтан шагайндаа электрон гавтай байх бөгөөд гэрт нь суурилуулсан хүлээн авагчид тогтмол дохио өгдөг, хяналтын зарим системд GSM (Үүрэн холбооны глобал систем) байхгүй тохиолдолд суурин утастай холбогддог бол ихэнх тохиргоо нь шалгалтын компанитай холбогдсон гар утасны систем ашигладаг.

2012 онд тус улсын Бодлого солилцоо, судалгааны төвөөс өөрийн орны цахим хяналтын хэрэглээг судалж, бусад улс орон, ялангуяа АНУ-д ашиглагдаж буй технологийн шинэ загвартай харьцуулах замаар зөвлөмж өгсөн нь цахим хяналтыг сайжруулахад нөлөөлсөн байна. Англи, Уэльст 2017 оны Эрүүгийн хуулийн нэмэлтээр хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн хүмүүс, 2018 оноос сэтгэцийн өвчтэй хүмүүст цахим хяналт тавьж эхэлсэн нь сэтгэцийн эрүүл мэндийн өмгөөлөгчдөөс багагүй шүүмжлэл дагуулжээ.⁶⁵

ИБУИНХУ-ын бүрэлдэхүүнд багтах Шотландын тухайд 2002 оноос эхлэн шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял хэрэглэх болсон бөгөөд цахим гав, хяналтын төхөөрөмжийн үйлчилгээг Засгийн газар, хувийн компани хоорондын байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг.⁶⁶ Шотландад цахим гав, хяналтын төхөөрөмжийг шүүхийн өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээ авах, ял шийтгэл эдлүүлэх болон суллагдсаны дараах хяналтын хэлбэрээр хэрэглэдэг. Мөн тэндхийн байршил дамжуулах болон мэдээлэл дамжуулах төхөөрөмжийн тусламжтай тавих хяналт нь дараах төрөлтэй. Үүнд:

- цагдан хорих шаардлагагүй гэж үзсэн сэжигтэнд тавих хяналт;
- зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүнд тавих хяналт;
- тэнсэн суллагдсан хүнд тавих хяналт (гэрийн хорионд оруулах, эсхүл хяналтын бүсээс гарахгүй байх, тодорхой маршрутаар зорчих нөхцөл тулгах);
- мансууруулах бодис хэрэглэсэн эсэхэд тавих хяналт гэх мэт.

2.3.4. Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын Гэмт хэрэгтнийг хянан харгалзах, цахим төхөөрөмж ашиглах тухай хуулийн зорилго нь хууль сахиулах байгууллагын албан хаагчаас зарим төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээд, хорих газраас суллагдсан хүнд

⁶⁵ Kathy Padgett, William Bales and Thomas Blomberg (2006) "Under Surveillance: An Empirical Test of the Effectiveness and Consequences of Electronic Monitoring" *Criminology and Public Policy*, pages 61-91.

⁶⁶ Development of Electronic Monitoring in Scotland A Consultation on the Future Direction of the Electronic Monitoring Service. September 2013. www.scotland.gov.uk. p.2.

байршил тогтоох төхөөрөмж суулган гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмд дасан зохицуулах, бусад иргэдийг гэмт халдлагаас хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино гэжээ.

Уг хууль дараах бүтэцтэй:

- I бүлэгт: Ерөнхий зүйл, зорилго, нэр томьёо, хариуцлага;
- II бүлэгт: Ял эдлүүлэх үеийн хяналт;
- III бүлэгт: Хугацаанаас өмнө суллагдсан этгээдэд тавих хяналт;
- IV бүлэгт: Зарим төрлийн гэмт хэрэгт тавих цахим хяналт;
- V бүлэгт: Төхөөрөмж ашиглалт;
- VI бүлэгт: Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тус тус зохицуулсан.

Зарим төрлийн гэмт хэрэг гэдэгт хүчиндэх, насанд хүрээгүй хүүхэд уруу татах (гэмт хэрэгт татан оруулах, өөрийн хүсэл зорилгыг ёс бусаар гүйцэлдүүлэхэд ашиглах) гэмт хэрэг, хүний амь насны эсрэг гэмт хэрэг, дээрмийн гэмт хэргийг хамааруулдаг.

Прокурор зарим төрлийн гэмт хэрэгт цахим хяналт тогтоох саналыг шүүхэд гаргах ба шүүхээс цахим хяналтад байх хугацааг тогтоохдоо:

- 3 жил хүртэлх хорих ялаар шийтгэгдэх гэмт хэрэгт 1-10 жил хүртэл;
- 3 жилээс дээш хорих ялаар шийтгэгдэх гэмт хэрэгт 3-20 жил хүртэл;
- цаазын болон бүх насаар хорих ялд 10-30 жил хүртэл;
- олон төрлийн гэмт хэрэгт нэгэн зэрэг шийтгүүлсэн тохиолдолд хамгийн хүнд гэмт хэрэгт ногдуулах төхөөрөмж суурилуулах хугацааны 2/1 хүртэлх хугацаагаар нэмэгдүүлэх бөгөөд нийт гэмт хэрэгт ногдуулах төхөөрөмж зүүх дээд хугацааны нийлбэрээс хэтрэхгүйгээр;
- 19 нас хүрээгүй этгээдийн хувьд төхөөрөмж зүүх хугацааг 2 дахин багасгаж тогтооно.

Гэм буруугүй нь шүүхээр тогтоогдсон, торгох, тэнсэн харгалзах ялаар шийтгүүлсэн тохиолдолд шүүх цахим төхөөрөмж зүүх саналаас татгалзана.

Цахим хяналтын тогтолцоо гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн биед байршил тогтоох хяналтын төхөөрөмж (гав) зүүн 24 цагийн турш байршлыг нь тодорхойлж, хянан харгалзагчийн удирдлага, хяналтад байлгахыг хэлнэ.

Цахим хяналтын ажилтан мөнгө, бэлэг сэлт авч, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төхөөрөмжийг салгасан, гэмтээсэн бол 2-оос дээш жилийн хорих ялаар шийтгэх ба хяналтад байгаа этгээд төхөөрөмжийг санаатай салгаж, мэдээллийг доголдуулсан, хууль бус аргаар мэдээллийг өөрчилсөн бол 7 жил хүртэлх хугацаагаар хорих, эсвэл 20 сая вон хүртэлх хэмжээгээр торгох шийтгэл оноохоор зохицуулсан.

Зураг 1. БНСУ-ын цахим хяналтын зорилго




Хорих ял эдлээд суллагдсан этгээдэд тавих цахим хяналтын хугацаа нь:

- үндсэн ялын хугацаа дууссан этгээдэд 1-30 жил хүртэл;
- 19 нас хүрээгүй этгээд хуульд тусгайлан заасан гэмт хэрэг үйлдсэн бол ял эдэлснээс хойш 2 жил хүртэл;
- өвчний улмаас хугацаанаас өмнө суллагдсан бол 3 жил хүртэл;
- хугацааны өмнө суллагдсан бол үлдсэн хугацааг оруулаад 10 хүртэл жил;
- ял хойшлуулсан, тэнсэн харгалзсан бол 5 хүртэлх жилийн хугацаанд хэрэглэнэ.

Зураг 2. БНСУ-ын цахим гавын хөгжил

Анхны загвар	2-р	3-р	4-р
 0.49% • Зөөлхөн, нимгэн • Биед эвтэйхэн	 0.85% • Холбоосыг сайжруулсан	 1.40% • Уян ган хийцтэй • Зүүхэд төвөгтэй, хүний биед хэт мэдрэгдэмтгий	 0.23% 1.34% • Цэнэглэдэг зай • Зэвэрдэггүй ган хийцтэй


Зураг 3. БНСУ-ын GPS байршил тогтоох систем



Зураг 4. БНСУ-ын цахим хяналтын танилцуулга

Гав	Орон байрны (суурин)	Байршил тогтоогч
		
Зөөврийн цэнэглэгч	Гэрийн	Машины
		
Уут	Цэнэглэгч адаптер	Цэнэглэгч суурь
		

Зураг 5. БНСУ-ын цахим хяналтын системийн холбоос



2.3.5. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ 2010 оноос эхлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд хууль сахиулах байгууллагын хяналт, хариуцлагаас зугтах, ял завшихыг оролдох арга хэлбэр улам нарийсаж, оргон зайлах явдал удаа дараа гарах болсон, түүнчлэн оргосон этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдсэн, сэжигтэн, яллагдагч, тэнсэн харгалзсан ялтанд биечлэн хяналт тавих боломжгүй байгаа зэрэг нөхцөл байдлыг харгалзан цахим хяналт тавих эрх зүйн орчин бүрдүүлж, хяналтын тоног төхөөрөмж нэвтрүүлсэн байна.

Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн дутмаг байдлаас үүдэн биечлэн хяналт тавих боломж муу, хяналт тавьж ирсэн арга, хэлбэр нь хоцрогдсон гэсэн дүгнэлт гарсан бөгөөд прокурорын байгууллагын удаа дараагийн шаардлага ч зохих нөлөө үзүүлсэн байна. Үүний дүнд “цахим бугуйвч, хяналтын систем” нэвтрүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдүүлж, хяналт тавих боловсон хүчний асуудлыг шийдвэрлэснээр тус байгууллагын чадавх сайжирч, цахим хяналтыг тасралтгүй тавих нөхцөл бололцоог бүрдүүлжээ.

Тус улсын Эрүүгийн хуулийн “Цахим бугуйвч хэрэглэх” гэсэн бүлэгт хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтан, өсвөр насны гэмт хэрэгтэн, цагдан хорих шаардлагагүй гэж үзсэн сэжигтэн, яллагдагчид цахим төхөөрөмж ашиглан байршлыг нь тогтоож, хяналт тавих зохицуулалт тусгажээ.

2012 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 8 дугаар зүйлд “хорихоос өөр төрлийн ял оногдуулах” заалт тусгасан нь тус улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд гарсан томоохон шинэчлэлт юм.⁶⁷ Тус нэмэлт, өөрчлөлтийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт үйлдсэн гэмт хэргийн шинж, нөхцөл байдалд үндэслэн гэмт этгээдэд тэнсэн харгалзах ял оногдуулах бөгөөд ялтны сурч боловсрох, ажиллах эрхийг хөндөлгүйгээр тодорхой газарт нэвтрэх, зарим хүмүүстэй холбоо барих, уулзахыг нь хориглох заалт тусгажээ.

⁶⁷ 1979年新中国刑法颁布(Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт).

Дээрх зохицуулалтын хүрээнд 2011 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Ардын дээд шүүх, Ардын дээд прокурорын газар, Олон нийтийн аюулгүй байдлын яам, Хууль зүйн яам хамтран “Тэнсэн харгалзах ял шийтгүүлсэн гэмт этгээдийг цахим хяналтад авах болон цахим бугуйвч, хяналтын тоног төхөөрөмж хэрэглэх тухай” журам батлан мөрдөж эхэлжээ.

Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн 9-р зүйлд хорихоос өөр төрлийн ялыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, олон нийтийн аюулгүй байдлыг хангах байгууллага хэрэгжүүлнэ гэж заажээ. Тус улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилтийг прокурор, хуулийн байгууллагаас гадна олон нийтийн аюулгүй байдлыг хангах байгууллага бүх нийтийн идэвхтэй оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан үр дүнтэй гүйцэтгэхээр заасан нь анхаарал татаж байна.

БНХАУ-ын прокурорын байгууллагаас шүүхийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг хангах зорилгоор цахим хяналтын үр дүнд шалгалт зохион байгуулж, тогтоосон хэм хэмжээ зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх үндсэн чиг үүрэг хэрэгжүүлдэг.

Зураг 6. БНХАУ-д зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглаж буй тоног төхөөрөмж

Д/д БНХАУ-д 2019 оны байдлаар ашиглагдаж буй цахим хяналтын төхөөрөмж		
1	Цахим бугуйвчийг ялтны гар утастай холбон хяналт тавих боломжтой.	
2	Хяналт тавих чиг үүрэг бүхий алба хаагч нь ялтанд зүүлгэсэн цахим бугуйвчийг өөрийн утастай холбож, хяналт тавих боломжтой.	
3	Цахим бугуйвчийг ялтанд зүүлгэхэд ашиглах багаж, хэрэгсэл	
4	Цахим бугуйвчийн шинэчилсэн загвар	

Цахим бугуйвчаар хяналт тавих ажил ихээхэн ахицтай байгааг 2011-2019 он хүртэл уг ялыг эдэлсэн ялтны 62 хувь буюу 40.000 хүн гэмт хэрэг дахин үйлдээгүй гэсэн судалгааны дүн харуулна.⁶⁸ “GPS”-ийн байрлал тогтоогч нь сансрын хиймэл дагуул болон дохио дамжуулагч үндсэн станцын хүчин чадлаас шууд хамаардаг бөгөөд БНХАУ нь үйлдвэрлэгч орны хувьд цахим бугуйвч ашиглах хугацаанд гарсан алдаа, дутагдлыг технологийн дэвшилтэй уялдуулан сайжруулж, хөгжүүлсээр байна.

Сүүлийн жилүүдэд Шанхай, Хэбэй, Хэнань, Жиангсу, Ханжоу, Анхуй, Шангдун, Шаньши, Хунань, Гуандун зэрэг газарт олон нийтийн аюулгүй байдлыг хангах байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хамтран цахим бугуйвч (5G технологи) ашиглан хорихоос өөр төрлийн ялыг илүү хялбар, шинэ арга хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж буй “5G технологи” нь орчин үеийн өндөр хурдны интернэт сүлжээ бөгөөд уг технологийг ашигласнаар цахим бугуйвчийн “GPS”-ийн байрлал тогтоогч илүү нарийвчлалтай зааж, хяналт нь илүү сайжирчээ.

Цахим бугуйвчийн цахилгаан хангамжийн технологийн хувьд литийн полимер зай ашиглаж байгаа бөгөөд энэ нь доорх давуу талтай. Үүнд:

- хүнд хэлбэрийн металл агуулаагүй;
- зайн доторх хэсэг нь шингэн (электролит) төлөвтэй бөгөөд асарахаас сэргийлж хуванцар бүрхүүл, гадаргатай хийгдсэн;
- зай нь дурын хэлбэрт хувирах боломжтойгоос гадна бусад загвараас харьцангуй хөнгөн;
- мэдээ өгөх, дамжуулах давтамжийг тохируулах замаар хугацааг сунгаж, багасгаж болно;
- богино хугацаанд цэнэглэж, цэнэгээ удаан барьдаг байна.

2.3.6. Оросын Холбооны Улс

Тус улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2001 оноос зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд цахим бугуйвч ашиглаж эхэлсэн байна. Тухайн цаг үед зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд гадаад орны хяналтын төхөөрөмж, цахим бугуйвч хэрэглэж байсан бөгөөд 2011 оноос эх орондоо үйлдвэрлэх болсноор зардлаа 4 дахин бууруулсан ба 2013 онд цахим бугуйвч, хяналтын тоног төхөөрөмж үйлдвэрлэхэд нийт 10.944.000 сая рубль төсөвлөжээ.⁶⁹

Өнөөгийн байдлаар Засгийн газрын 2010 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 198 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Ялтныг хянах аудио болон электрон техник, хэрэгслийн жагсаалт батлах тухай”⁷⁰ журам, Хууль зүйн

⁶⁸ “电子手铐” -社区矫正人员电子手环在实践中的应用探讨 Олон нийттэй харилцах албанаас цахим бугуйвчид хийсэн судалгаа.

⁶⁹ ФСИН России: Ведомственная целевая программа «Внедрение современных информационно-коммуникационных технологий в деятельность Федеральной службы исполнения наказаний на 2011–2013 годы». М., 2010, с.66 (хандалт-2018.01.10).

⁷⁰ ОХУ-ын хууль тогтоомжийн эмхэтгэл. 2010, №14. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_99050/.



сайдны 2010 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 258 дугаар тушаалаар батлагдсан “Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлэх журам”-аар тус ялыг эдлүүлэх нөхцөл, журмыг зохицуулж байна. Төхөөрөмжийг ОХУ-ын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дэргэдэх Мэдээлэл, техникийн хангамжийн төвд⁷¹ үйлдвэрлэдэг.

Зураг 7. ОХУ-д зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглаж буй тоног төхөөрөмж

Д/д	ОХУ-ын ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй цахим бугуйвч, дагалдах тоног төхөөрөмжийн танилцуулга		
1	Браслет электронный	Электрон бугуйвч	
2	Стационарное контрольное устройство	Байнгын хяналтын төхөөрөмж	
3	Мобильное контрольное устройство	Хөдөлгөөнт хяналтын төхөөрөмж	
4	Ретранслятор	Дахин дамжуулагч: суурин болон хөдөлгөөнт хяналтын төхөөрөмжийн хүлээн авах хүчин чадлын хүрээг нэмэгдүүлэгч	
5	Персональный трекер	Алба хаагчийн трекер: Хиймэл дагуулын ГЛОНАСС/GPS системийн тусламжтайгаар байршил тогтоох алсын зайн дохиоллын нэгэн төрлийн электрон гав	
6	Цахим бугуйвчийн техникийн үзүүлэлт	✓ -100-гаас +100 градуст ажиллах боломжтой; ✓ 5 метр гүн давстай болон цэвэр усанд 15 минут хүртэл хугацаанд байлгахыг тэсвэрлэх боломжтой.	

⁷¹ Федеральное государственное унитарное предприятие “Центр информационно-технического обеспечения и связи Федеральной службы исполнения наказаний”.
<http://www.citosfsin.ru/company/index.php>.

Зураг 8. ОХУ-ын орон нутгийн шийдвэр гүйцэтгэх албанд ашиглаж буй тоног төхөөрөмж

Д/д	Орон нутгийн техник хэрэгсэл ба мэдээллийн төвийн төхөөрөмж		
1.	Сервер мониторинг	Мониторинг сервер: бүх мэдээллийг тусгай программ, дэлгэцээр хянах аппарат	
2.	Сервер аудиовизуального контроля	Аудио хяналтын сервер: дуу хоолойн мэдээлэл дамжуулах, хадгалах, хүлээн авах хяналтын цогц аппарат	
3.	Стационарный пульт мониторинга	Байнгын удирдах мониторинг	
4.	Мобильный пульт мониторинга	Зөөврийн удирдах мониторинг	

2.3.7. Хэсгийн дүгнэлт

Судалгааны хүрээнд харьцуулан судалсан гадаадын зарим орны гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зорчих эрхийг хязгаарлаж буй байдлыг судлан үзвэл дараах хэлбэртэй байна. Дэлхийн ихэнх оронд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цахим бугуйвч зүүн хяналт тавьж буй дараах хэлбэрүүд байна. Үүнд:

- Шүүхийн шатанд буюу цагдан хорихгүйгээр таслан сэргийлэх арга хэмжээ болгон хэрэглэх;
- Эрүүгийн хууль тогтоомждоо гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах зорчих эрхийг хязгаарлах ял гэсэн ялын төрөл болгон хэрэглэх;
- Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтанд, тухайлбал, нийтэд тусгай ажил хийлгэх ял эдэлж буй этгээдэд хяналт тавих хэрэгсэл;
- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний буюу мансууруулах, согтуурах донтой этгээдэд хяналт тавих хэрэгсэл;
- Хорих ял эдэлж байгаад суллагдсан буюу ял тэнссэн, хугацааны өмнө суллагдсан этгээдэд хяналт тавих.

Манай улсын хувьд цахим хяналтын систем, эрх зүйн зохицуулалтыг сайжруулснаар олон улсын чиг хандлагад нийцсэн хяналтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.

ГУРАВ. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

3.1. Олон улсын баримт бичиг

3.1.1. Токиогийн дүрэм

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоолоор “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм)-ийг 7 бүлэг 23 зүйлтэйгээр батлан гаргасан нь хорих ялаас татгалзах, хорихоос бусад төрлийн ял шийтгэлийг өргөн хэрэглэх нөхцөлийг зарчмын хувьд бүрдүүлсэн чухал зохицуулалт болсон.

Токиогийн дүрэм⁷² нь хорих ялын хэрэглээг багасгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэх зорилго агуулж, нийгмийн болон хохирогчийн ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тохиолдолд хохирогчтой зөвлөлдөж байхыг зөвлөжээ. Энэхүү дүрэмд хорихоос өөр төрлийн арга хэмжээнд хэрэглэх дараах үндсэн зарчмуудыг тусгасан.⁷³ Үүнд:

- хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа этгээдийн наад захын баталгааг хангах;
- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хандах олон нийтийн идэвхтэй оролцоог хангах, нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг нь хөгжүүлэхэд дөхөм үзүүлэх;
- үндэсний эрүүгийн хууль тогтоомжийн бодлого, зорилтыг харгалзан хэрэглэх;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын тухайд нийгмийн сонирхол, хохирогчийн эрх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх хоорондын зүй зохистой харьцааг хангах;
- хорих ял хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжоор хангах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийгэмд, хэвийн амьдралдаа эргэж орох хэрэгцээ, шаардлага, хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн хууль тогтоомж дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулах.

Дүрмийн гол зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг төрийн эрх бүхий байгууллагын хяналтад авах замаар хүмүүжүүлэх, нийгмийн хэвийн

⁷² Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012, 159 дэх тал.

⁷³ НҮБ-ын Ерөнхий Ассамблей. “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм). 1990.

амьдралдаа эргэж ороход нь туслах, хорих ялаас татгалзах, ялын нөлөөг цээрлүүлэхээс илүү гэмт хэрэг дахин үйлдэж давтан гэмт хэрэгтэн болохоос сэргийлэхэд чиглүүлэх явдал юм.

Үүнээс гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ нь үр дүнгээ өгч байгаа тохиолдолд уг арга хэмжээг хугацаанаас нь өмнө өөрчлөх, хүчингүй болгох, үр дүнд хүрээгүй тохиолдолд шууд хорих ял хэрэглэхээс зайлсхийн хорихоос өөр төрлийн арга хэмжээгээр солих зэрэг зохицуулалт санал болгосон байна. Түүнчлэн хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий алба хаагч нь амьдралын туршлагатай, мэргэжлийн зохих бэлтгэлтэй, хувийн шинж чанараар тохирох хүн байвал зохино хэмээн тусгайлан тодорхойлсон.

Хорихоос өөр төрлийн арга хэмжээг сонгох бололцоотой нөхцөлд шүүн таслах эрх бүхий байгууллага дараах байдлаар шийдвэрлэж болохоор зохицуулсан. Үүнд:

- a. сануулах, зэмлэх, буруушаах зэрэг аман арга хэмжээ;
- b. хариуцлагаас тэнсэн чөлөөлөх;
- c. иргэний зарим эрхийг нь хасах;
- d. нэг удаагийн болон өдрийн торгууль зэрэг мөнгөн шийтгэл оногдуулах, эдийн засгийн арга хэмжээ авах;
- e. хөрөнгө хураах, эд хөрөнгө өмчлөх эрхийг нь хасах тогтоол гаргах;
- f. хохирогчид эд хөрөнгийг нь буцааж өгөх, хохирол төлөх тогтоол гаргах;
- g. тэнсэх, шийтгэлийг хойшлуулах;
- h. хорихоос тэнсэн суллах болон шүүхийн хяналт тогтоох;
- i. нийгмийн тустай хөдөлмөр хийлгэх тухай тогтоол гаргах;
- j. тодорхой газар нутагт заавал ирж бүртгүүлж байх болзол тогтоох;
- k. гэрийн хорионд байлгах;
- l. хорихтой холбоогүй бусад арга хэмжээ авах;
- m. дээр дурдсан арга хэмжээнүүдийг хослуулан хэрэглэх.

Дүрмийн заалтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хүний шашин шүтлэг, арьсны өнгө, нас, хүйс, хэл, улс төрийн болон бусад үзэл, нийгмийн гарал үүсэл, эд хөрөнгийн байдал, төрсөн газар зэргээр ялгаварлан гадуурхахгүйгээр хэрэглэнэ. Мөн хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх явцад тухайн этгээд эрх нь зөрчигдсөн гэж үзвэл гомдол гаргах эрхтэй байхаар заасан.

Хүснэгт 2. Дүрмийн шаардлага

Д/д	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үе шат	Дүрмийн шаардлага
1	Шүүхийн өмнөх шат	Тодорхой хэрэг мөрдөн шалгах хийгээд нийгэм, хохирогчийг хамгаалах зорилгоор шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулах явдлыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны онцгой арга хэмжээ болгож хэрэглэх ёстой.
2	Шүүхийн шат ба тогтоол гаргах үе	Хорихоос өөр төрлийн арга хэмжээг сонгох бололцоотой нөхцөлд шүүхийн байгууллага шийдвэр гаргахдаа эрх зүйн зөрчил гаргагчийг засан хүмүүжүүлэх шаардлага, нийгмийн болон хохирогчийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг анхааралдаа авбал зохих бөгөөд шаардлагатай тохиолдолд хохирогч этгээдтэй зөвлөлдөж байгууштай.
3	Шийтгэх тогтоол гарсны дараах шат	Эрх бүхий байгууллага эрх зүйн зөрчил гаргасан этгээдүүд нийгмийн хэвийн амьдралд түргэн эргэж ороход нь туслах, хорихоос татгалзах, тогтоол гарсны дараа хорихоос өөр төрлийн арга хэмжээг сонгох өргөн боломжтой байна.

Шийтгэх тогтоол гарсны дараа доорх арга хэмжээг авч болно:

- чөлөө олгох ба засан хүмүүжүүлэх хагас шоронгийн байгууллагад байлгах;
- ажил, сургалттай нь холбогдуулж чөлөөлөх;
- хугацааг богиносгох;
- уучлал үзүүлэх.

Хүснэгт 3. Дүрэмд тусгагдсан хорихтой холбоогүй арга хэмжээ

Д/д	Төрөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Хяналт	- Хэрэг зөрчил дахин үйлдэх явдлыг багасгах, архаг хэрэгтэн болохоос сэргийлэх, нийгмийн амьдралд түргэн ороход нь туслах замаар хэрэгт дахин орооцолдох магадлалыг нь бууруулахад хяналтын зорилго оршино. Хяналтыг хуулиар тодорхойлогдсон тодорхой нөхцөлтэйгөөр эрх бүхий байгууллага гүйцэтгэнэ. - Зөрчил гаргагчид туслахад чиглэсэн хяналтын болон харилцааны илүү үр ашигтай хэлбэрийг тохиолдол бүрд тодорхойлно. Хяналт болон харилцаа, хандлагыг үе үе хянан хэлэлцэж шаардлагатай хэмжээгээр засаж залруулна. Эрх зүйн зөрчил гаргагчдад хэрэгцээтэй үед нь сэтгэл санаа, эд хөрөнгийн туслалцаа үзүүлэх ёстой ба нийгэмд, хэвийн амьдралдаа эргэж орохыг нь хөнгөвчлөх, нийгэмтэй харилцаа холбоогоо бэхжүүлэх боломж олгоно.
2	Үйлчлэх хугацаа	Хорихоос өөр төрлийн арга хэмжээний үйлчлэх хугацаа хуульд зааснаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанаас илүү байх ёсгүй. Хэрэв үр дүнгээ өгч байвал авсан арга хэмжээг хугацаанаас нь өмнө зогсоож болно.

3	Болзол, нөхцөл	- Эрх бүхий байгууллага нь зөрчил гаргагчид болзол тогтоосон бол хохирогчийн болон зөрчил гаргагчийн эрх ашиг, нийгмийн сонирхлыг тооцох ёстой. Биелүүлбэл зохих болзол нь бодитой, тодорхой, бололцооны хэрээр аль болох цөөн байх ёстой бөгөөд эрх зүйн зөрчил үйлдсэн этгээд гэмт хэргийн замд буцаж орох магадлалыг багасгах, засран хүмүүжих, нийгэмдээ нэгдэх боломжийг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн байхын сацуу хохирогч этгээдийн эрэлт хэрэгцээг бодолцсон байвал зохино. - Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх эхний үе шатанд эрх зүйн зөрчил гаргагч этгээдэд түүний эрх, үүргийг оролцуулан тухайн арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулах болзлын талаар амаар болон бичгээр ойлгуулж тайлбарлана.
4	Харилцах ажиллагаа	- Ганцаарчилсан ажил, хамтарсан арга хэмжээ, эрх зүйн зөрчил үйлдсэн олон янз ангиллын этгээдүүдийн оршин суугаа газраар хэрэгжүүлэх хөтөлбөрүүд ба тусгайлан харилцаа гэх зэрэг төрөл бүрийн аргыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрэлт хэрэгцээнд илүү тохируулахын тулд боломжтой хэргүүд дээр хорихоос өөр төрлийн тухайн арга хэмжээнд тааруулан боловсруулбал зохино.
5	Болзол зөрчих ба сахилга бат	- Гэмт хэрэг үйлдсэн этгээд мөрдвөл зохих болзлоо зөрчсөн тохиолдолд хорихоос өөр төрлийн арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгож болно. - Хорихоос өөр төрлийн арга хэмжээг өөрчлөх буюу хүчингүй болгох шийдвэрийг эрх зүйн зөрчил гаргагч болон хяналт тавьж байсан ажилтнаас гаргаж өгсөн баримт сэлтийг сайтар судалсны үндсэн дээр эрх бүхий байгууллага гаргана. - Хорихоос өөр төрлийн арга хэмжээ нь амжилтгүй болбол энэ нь хорих ял хэрэглэхэд шууд хүргэхгүй. - Хорихоос өөр төрлийн арга хэмжээг солих буюу өөрчлөх тохиолдолд эрх бүхий байгууллага нь хорихоос бусад өөр төрлийн зохих арга хэмжээ тогтоохыг эрмэлзэнэ. Хорихтой холбоогүй өөр төрлийн арга хэмжээ олдоогүй тохиолдолд хорих арга хэмжээг хэрэглэж болно. - Болзол зөрчсөн тохиолдолд эрх зүйн зөрчил гаргагчийг баривчлах болон хяналтын дор хорьж саатуулах эрх мэдлийг хуулиар тогтоох ёстой. - Хорихоос өөр төрлийн арга хэмжээг өөрчилсөн, хүчингүй болгосон тохиолдолд эрх зүйн зөрчил гаргагч шүүхийн болон эрх бүхий хараат бус бусад байгууллагад гомдол гаргах эрхтэй.
6	Олон нийтийн оролцоо	- Хорихоос өөр арга хэмжээ авагдсан эрх зүйн зөрчил гаргагч, түүний гэр бүл, нийгмийн хоорондох холбоог бэхжүүлэх чухал хүчин зүйл, гол нөөц бололцоо болохынх нь хувьд олон нийтийн оролцоог урамшуулахыг зөвлөсөн.
7	Нийгмийн ухамсар ба хамтын ажиллагаа	- Хорихоос өөр төрлийн арга хэмжээг дэмжихэд Засгийн газрын байгууллагууд, хувийн сектор болон иргэдийг хөхиүлэн дэмжинэ. Олон нийтийн оролцоо зайлшгүй чухал гэдгийг ухамсарлуулах зорилгоор онол-практикийн бага хурал, семинар, симпозиум, бусад арга хэмжээг байнга зохион байгуулж байвал зохино. Энэ үйл ажиллагаанд олон нийтийн мэдээллийн бүх төрлийн хэрэгслийг үр дүнтэй ашиглах шаардлагатай.
8	Сайн дурынхан	- Энэ арга хэмжээнд сайн дурынхны оролцоо чухал тул тэднийг сонгох, сургах, шаардлагатай даатгалд хамруулах, зөвшөөрөгдсөн зардлыг тэдэнд олгох, энэ үйл ажиллагаанд тэд оролцож байгааг нийгмээрээ хүлээн зөвшөөрч, талархан дэмжих нь чухал юм.

Олон улс эрүүгийн эрх зүйдээ хүний эрхийг хангаж, хүнлэг, энэрэнгүй ёсны хандлагыг тусгаж, ялын хатуу чанга бодлогоос татгалзан, улмаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн хорихоос өөр төрлийн арга хэмжээг өргөн дэлгэр хэрэглэх чиг хандлагатай байна. НҮБ ч энэ байр суурийг баримталсан баримт бичиг гаргах замаар гишүүн орнууддаа үүрэг болгох болсон. Нөгөө талаас хорих ялын нийгэмд үзүүлэх үр нөлөө төдий л өндөр байдаггүйг дэлхий нийт хүлээн зөвшөөрч байна.

Дүрэмд цахим гав, цахилгаан буюу электрон хяналтын төхөөрөмж, согтууруулах ундаа-мансууруулах бодис хэмжигч зэргийг хэрэглэх талаар шууд зааж өгөөгүй ч хэрэг зөрчил дахин үйлдэх магадлалыг багасгахад хяналтын зорилго оршино гэж заасантай дээрх төхөөрөмжийн тусламжтайгаар хяналт тавих зорилго нийцэж байгаа юм.

Монгол Улсын хувьд энэхүү жишиг дүрэмд нэгдсэн бөгөөд Монгол Улсын Олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх учиртай тул манай улс хорихоос өөр төрлийн ял хэрэглэх эрх зүйн орчноо дүрэмд нийцүүлэн сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

3.1.2. Эрүүгийн загвар хууль

Эрүүгийн эрх зүйн салбарт глобалчлал, интеграцчиллын үйл явц нэвтэрч эхэлсэнтэй холбоотойгоор дэлхийн хэмжээний эрүүгийн загвар хууль гаргах, олон улсын хэмжээнд дагаж мөрдөх ялын үзэл баримтлал боловсруулах ажил 2003 оноос эрчимтэй өрнөсөн байна. Үүний дүнд НҮБ-ын болон Харьцуулсан эрүүгийн эрх зүй судлалын олон улсын хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр, олон улсын шинжээч, судлаач, эрдэмтдийн оролцоотойгоор, В.Коннор, К.Рауш нарын хянан тохиолдуулсан Дэлхийн эрүүгийн загвар хуулийг 2007 онд гаргасан. Энэ загвар хууль 17 бүлэг, 200 зүйл, 300 шахам тайлбарыг өөртөө багтаасан 526 хуудас бүхий томоохон хэмжээний чухал хэрэглэгдэхүүн болжээ.⁷⁴

Ялын бодлогын хувьд энэ хуульд аль нэг системийн онцлогийг тусгаагүй, харин дундын буюу жишиг зарчим, хандлага түлхүү тусгагджээ. Эрүүгийн загвар хуулийн 38 дугаар зүйлийн 3-т хугацаатай хорих ялын доод, дээд хэмжээг заахдаа 1-5, 2-10, 3-15, 5-25, 10-30 жил гэсэн интервалт нормативыг жишиг болгон тогтоосон байна. Түүнчлэн ял оноохдоо гэмт хэргийн хор аюул, хууль зөрчсөн байдлын түвшин, хэмжээ, яллагдаж буй этгээдийн засрах боломж болон нийгмийн шударга ёс сэргээгдсэн эсэхийг харгалзан оновчтой шийдэж байх нөхцөлийг заажээ.

⁷⁴ Model Codes for Post-conflict Criminal Justice Model. Vivienne O'Conner and Colette Raush editors, Peasbuilding and the Rule of law. W.P.L., 2007.

Хүснэгт 4. Дэлхийн эрүүгийн загвар хуульд ялын төрөл туссан байдал

Ялын төрөл		
Үндсэн	Сонгох	Нэмэлт
Бүх насаар нь хорих	Шүүхийн тогтоол гүйцэтгэхийг хойшлуулах	Торгууль, нөхөн төлбөр
Хугацаатай хорих	Нийгмийн үйлчилгээнд хамруулах	Эрх хасах, хянан харгалзах
Торгох	Гэрийн хяналтад байлгах	Үйл ажиллагаа, албан тушаал эрхлэхийг хориглох
		Эх орноосоо албадан гаргах

Ялын бодлогын хүрээнд дэлхий дахинд дараах өөрчлөлт хийгдэж байна. Үүнд:

- цаазаар авах ялыг халах (99 улсад бүрэн халсан, зөвхөн 58 улсад хэрэглэдэг);
- бие махбодын шийтгэлээс татгалзах (33 улсад л хэрэглэдэг);
- цөллөгийн хөдөлмөрийг халах (Европ, Ази тивийн олон улс, АНУ-ын хууль тогтоомжоос хассан);
- нийт хөрөнгө хураах ялаас татгалзах (Франц, Монгол, Зүүн Европын улсууд);
- хорихоос өөр төрлийн ял хэрэглэх (торгууль, албадан ажил, тэнсэн, нийтэд тустай ажил, гэрийн хорио);
- эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл нэмэх (хохирогчтой эвлэрсэн, аргагүй хамгаалалтын хэмжээ хязгаарыг өргөтгөсөн, хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар гэсэн ойлголт бий болсон);
- насанд хүрээгүй гэмт хэрэгтний эрүүгийн эрх зүйн шийтгэлийг өргөтгөх;
- олон үйлдлийг гэмт хэрэгт тооцохоо больж, захиргааны зөрчлийн хэмжээнд авч үзэх (жижиг хулгай, танхай, үр хөндөх г.м).

Улс орнууд хүмүүнлэгийн чиглэлийн хүрээнд өөрчлөлт хийгээд эхэлжээ. Баруун Европын дийлэнх улс орон цаазаар авах ялыг халсан ба албадан ажил хийлгэх, эд хөрөнгийг бүхэлд нь хураах ялыг хязгаарлаж, нийгмийн үйлчилгээ, хөтөлбөрт хамруулах, нөхөн төлбөр оноох ялаар орлуулан сольж ялын бодлогодоо өөрчлөлт оруулжээ.


Ялын төрлийг хэрэглэх зарчимд туйлын тодорхой санкцыг хуульчлах явдлаас аль болох зайлсхийх, алтернатив нөхцөлийг тодорхой боломжит шийдлээр зохицуулж өгөх, хүнд биш хэргийн хувьд хянан харгалзах, торгох ял өргөн хэрэглэх ба баривчлах болон хорих ялын доод хугацааг багаар тооцох (5 хоногоос 3 сар), торгуулийг сүүлийн 6 сарын долоо хоног болон сарын дундаж орлогоор тооцох, мөнгөн дүнгээр илэрхийлэх, түүнчлэн хорихоос өөр төрлийн ялыг өргөжүүлэх, ял солих процедурыг оновчтой хэрэглэх зэрэг практик жишиг гадаадын зарим оронд түгээмэл нэвтрэн хэрэглэгдэж байна.

3.2. Үндэсний хууль тогтоомж

3.2.1. Эрүүгийн хууль

2015 оны Эрүүгийн хуульд нийт 1088 үйлдлийг гэмт хэрэгт тооцож “хорих, торгох, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх болон эрх хасах” ялын төрлийг үндсэн болон нэмэгдэл ялын чанартайгаар ногдуулах тухай заасан байна.⁷⁵

График 2. Эрүүгийн хуульд туссан ялын төрөл, эзлэх хувь



Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг 240 буюу хөнгөн 121, хүнд 119 гэмт хэрэгт ногдуулахаар тогтоожээ. Мөн зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хорих ялын аль нэгийг сонгож хэрэглэхээр хүнд гэмт хэргийн 119, хөнгөн гэмт хэргийн 57 заалт буюу “хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”, “олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг”, “авлига, албан тушаалын гэмт хэрэг”, “хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг”-т түлхүү ногдуулахаар хуульчилсан.⁷⁶

Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлд зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, түүнийг оногдуулах үндэслэл, уг ялыг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалт тусгажээ.

⁷⁵ Э.Жамбалрагчаа, Э.Урангоо. “Монгол Улсын Эрүүгийн хууль дахь ялын хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ, гадаад орны зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажиллагааны туршлага, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”. ШШГЕГ-ын “Сүлд инфо сэтгүүл”. УБ, 2021, 53 дахь тал.

⁷⁶ Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015.

Хүснэгт 5. Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ял туссан байдал

Д/д	Үндэслэл	Хуулийн зохицуулалт
1	Ялын төрөл	- Зорчих эрхийг хязгаарлах ялыг үндсэн ялаар хэрэглэнэ.
2	Ял солих	- Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн бол ял шийтгүүлсэн гэмт хэрэгт нь хорих ял оногдуулахаар заасан эсэхээс үл хамааран эдлээгүй үлдсэн ялыг эрүүгийн хуульд заасан журмын дагуу сольж, хорих ял оногдуулна.
3	Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа	- Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй: • Зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн; • Зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн; • Зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн.
4	Зорчих эрх хасах ял дээр нэмж эрх хасах ял оногдуулах	- Шүүх эрх хасах ялыг зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс хугацааг тоолно.
5	Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах	- Шүүх хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа зорчих эрхийг хязгаарлах ялын нэг хоногийг нэг хоногийн хорих ялаар тооцон эдлүүлэхээр шийдвэрлэж болно.
6	Цагдан хоригдсон хугацааг тооцох	- Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг зорчих эрхийг хязгаарлах ялын нэг хоногоор тооцож эдлэх ялаас хасна.
7	Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ялаас өвчний учир чөлөөлөх	- Зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлж байх үедээ өөрийн эрүүл мэндэд санаатай хохирол учруулсан хүнийг ялаас чөлөөлөхгүй.

Судалгааны хүрээнд Эрүүгийн хуульд шүүхээс гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд ял оногдуулахдаа зөвхөн хорих ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан ба зорчих эрхийг хязгаарлах ялыг зааж өгөөгүй байгааг анхаарах нь зүйтэй.

3.2.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр батлагдан, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зорчих эрхийг хязгаарлах ялын талаар дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт 6. Эрцүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зорчих эрхийг хязгаарлах ял туссан байдал

Д/д	Үндэслэл	Зохицуулалт
1	Хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх	- Ял эдлүүлэх боломжгүй байдал үүсвэл прокурор нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын саналыг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргуулна. - Шинжээчийн дүгнэлт, байгууллагын саналд тулгуурласан прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүгч ялтанд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, сэтгэцийн эмгэг судлалын тусгай, эсхүл бусад эмнэлэгт байлгах, эсхүл түүнийг цаашид ял эдлэхээс чөлөөлөх тухай шийдвэр гаргана. - Ялаас өвчний учир чөлөөлөх тухай шүүхийн шийдвэр гарсан бол тухайн ялтныг даруй суллана. - Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол прокурорын дүгнэлтийг үндэслэн ял эдлүүлэх асуудлыг шүүх хянан шийдвэрлэнэ.
2	Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх үндэслэл	- Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих, хорих ялаас хугацаанаас нь өмнө суллаж, хяналт тогтоох, хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх асуудлыг уг тогтоолыг ямар шүүх гаргасныг харгалзахгүйгээр тогтоол биелүүлж байгаа газрын шүүх шийдвэрлэнэ.
3	Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх журам	- Шүүх ялтныг зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх, эмнэлгийн байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ дүгнэлт гаргасан шинжээчийг байлцуулж болно. - Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих, хорих ялаас хугацаанаас нь өмнө суллаж, хяналт тогтоох тухай асуудлыг шийдвэрлэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

3.2.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох эрх зүйн акт

2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр батлагдаж, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын хэлбэр, ашиглах тоног төхөөрөмж, түүний зардал, ял эдлүүлэх нөхцөл, журмыг өөрчлөх болон ялтны хүлээх үүрэг, хариуцлагын талаар тусгажээ.


Хүснэгт 7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг тусгасан байдал

Д/д	Үе шат	Хийгдэх ажиллагаа
1	Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх	- Ахлах шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн этгээдийг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн хамт хүлээж авна. - Ахлах шийдвэр гүйцэтгэгч шүүхийн тогтоол, магадлалыг тоо бүртгэлд оруулан эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гаргаж, ажлын 3 өдрийн дотор тойрог хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид хуваарилж, энэ тухай прокурорт мэдэгдэнэ.
2	Ял эдэлсэн хугацааг тоолох	- Шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болж, ялтанд цахим бугуйвч зүүлгэсэн өдрөөс эхлэн тоолно.
3	Тоног төхөөрөмж сонгон, суурилуулах	- Ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл, тоног төхөөрөмж сонгох ба техник хяналтын ажилтан цахим бугуйвчийг ялтны биед, бусад тоног төхөөрөмжийг орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, шаардлагатай бусад газарт суурилуулж, төхөөрөмжийн сери, дугаарыг бүртгэнэ. - Шийдвэр гүйцэтгэгч ялтны ял эдлэх бүсийг тогтоон, хяналтын программ хангамжид дараах байдлаар тусгана: 1. Шүүхийн шийдвэрт эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглохоор заасан бол оршин суугаа хаягийг тогтоож, зөвшөөрсөн бүсийг боломжит хэмжээ, хязгаараар; 2. Шүүхийн шийдвэрт эрх бүхий байгууллагын хяналтад тодорхой газар очихыг хориглохоор заасан бол хориглосон газрын хаяг, байршлыг тогтоон, нэвтрэхийг хориглох бүсийг боломжит хэмжээ, хязгаараар;

4		3. Шүүхийн шийдвэрт эрх бүхий байгууллагын хяналтад тодорхой чиглэлээр зорчихоор заасан бол оршин суугаа хаяг, байршлаас зөвшөөрсөн газар хүртэл явган болон тээврийн хэрэгслээр зорчих чиглэлийг тодорхойлж, боломжит хэмжээ, хязгаараар; 4. Шүүхийн шийдвэрт эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх гэж заасан бол оршин суугаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээгээр; 5. Шүүхээс тодорхой хүнтэй уулзах, бусадтай харилцахыг хориглохоор заасан бол уулзахыг хориглосон иргэний оршин суугаа газар, ажлын байр, зорчих чиглэлийн дагуу ялтныг нэвтэрхийг хориглосон бүсийг боломжит хэмжээ, хязгаараар тусгана.
5	Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд хяналт тавих	- Техникийн хяналт гэж цахим хяналт, удирдлагын төвөөс хяналтын нэгдсэн систем болон цахим бугуйвчаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд тавих 24 цагийн хяналтыг хэлнэ; - Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд сард хоёроос доошгүй удаа биечилсэн хяналт тавина.
6	Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг түдгэлзүүлэх	- ялтан ял эдлүүлэх ажиллагаанаас оргон зайлсан, нас барсан гэж зарлагдсан, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон; - гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас ял эдлүүлэх боломжгүй болсон; - ялтан байнга оршин суугаа газраас бусад газарт 3 сараас дээш хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах шаардлагатай болсон.
7	Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг дуусгавар болгох	- ялтан шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг бүрэн эдэлж дууссан; - ялтныг өвчний учир хугацаанаас нь өмнө ялаас чөлөөлсөн; - шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээгээр солих тухай шүүхийн шийдвэр гарсан; - ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон; - ялтанд өршөөл, уучлал үзүүлсэн; - ялтан нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсоноос хойш 2 жилийн хугацаа өнгөрсөн; - ялтан хэрэг хариуцах чадваргүй болсон.

Эрүүгийн 34 шийдвэр гүйцэтгэгчээс “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт хэр оновчтой байна гэж үздэг вэ?” гэсэн асуултад 26 буюу 76.4 хувь нь “сайжруулах шаардлагатай”, 7 буюу 20.5 хувь нь “хангалтгүй”, 1 буюу 2.9 хувь нь “сайн” гэж хариулсан нь эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх шаардлага байгааг харуулж байна.

График 3. Эрх зүйн зохицуулалтад өгсөн эрцүгийн шийдвэр гүйцэтгэгчдийн үнэлгээ



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой асуудлыг судлан үзэхэд ялтны хүлээх үүргийн талаар дэлгэрэнгүй тусгаснаас бус эдлэх эрхийг нь орхигдуулсан гэж үзэж болохоор байна. Тухайлбал:

1. Хуулийн 171.1-д “ахлах шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл, тоног төхөөрөмжийг тогтооно” гэж заасан нь ялтан гар, хөлийн бугуйвчийг өөрөө сонгох боломжийг хаасан;
2. Хуулийн 173 дугаар зүйлд “зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчлөхдөө прокурорын зөвшөөрснөөр ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг 30 хүртэл хоногийн хугацаанд өөрчилж болно” гэсэн нь ялтан гэнэт тохиолдсон (өвчилсөн, гэр бүлийн гишүүн нас барсан, байгалийн гамшиг, осол г.м.) асуудлаар ажлын бус өдөр, цагт хэнд, хэрхэн хүсэлт гаргах нь тодорхой бус;
3. Хуулийн 175.1-д “ялтан ял эдлүүлэх журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд 1 сард 5 хүртэл хоногийн шагналын хоног олгож болно” гэсэн нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлснийх нь төлөө урамшуулах байдалд хүргэж байна гэж үзлээ.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг зохицуулахтай холбоотойгоор Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас дараах тогтоол, дүрэм, журам баталжээ.

*Хүснэгт 8. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох
эрх зүйн актын зохицуулалт*

Д/д	Эрх зүйн акт	Зохицуулах зүйл
1	Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”;	- Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд техникийн хяналт тавихад гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласан зардлыг тооцох, санхүүжүүлэх, зардлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцаа;
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А-234/А/103 дугаар тушаалаар батлагдсан “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”;	- Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл, тавих хяналт, мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой харилцаа;
3	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/246 дугаар тушаалаар батлагдсан “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих тоног төхөөрөмж ашиглах журам”;	- Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд гар, хөлийн цахим бугуйвч, хяналтын бусад тоног төхөөрөмж суурилуулахтай холбоотой харилцаа;
4	ШШГЕГ-ын даргын 2017 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/165 дугаар тушаалаар батлагдсан “Хоригдол, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд шагналын хоног олгох, хоригдлыг ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох тухай санал гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн дүрэм”;	- Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд шагналын хоног олгох арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагаа болох хуралдаантай холбоотой харилцаа;
5	ШШГЕГ-ын даргын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/85 дугаар тушаалаар батлагдсан “Цахим хяналт, удирдлагын төвийн ажиллах журам”;	- Цахим хяналт, удирдлагын төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, түүнд тавих хяналт, төвийн тоног төхөөрөмж, түүний ашиглалттай холбоотой харилцаа;

6	ШШГЕГ-ын даргын 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/47 дугаар тушаалаар батлагдсан “Зорчих эрхийг хязгаарлах ялын маягт”;	- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтныг бүртгэх хуудас; - зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны дэлгэрэнгүй бүртгэл; - зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд техникийн зааварчилгаа өгсөн тухай тэмдэглэл; - хувийн баталгаа; - зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд эрх, үүрэг танилцуулсан тухай тэмдэглэл, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд хяналтын тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл; - зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих тухай санал; - зөрчлийн тэмдэглэл; - зөрчлийг газар дээр нь шалгасан тухай тэмдэглэл; - утсаар шалгасан тухай тэмдэглэл; - зорчих эрхийг хязгаарлах ялын нөхцөл, журмыг түр өөрчлөх тухай тогтоол; - зорчих эрхийг хязгаарлах ялын нөхцөл, журмыг өөрчлөх тухай санал; - цахим бугуйвч, тоног төхөөрөмж ашигласан зардлыг төлөх мэдэгдэл; - цахим бугуйвч, тоног төхөөрөмж гэмтээсэн, устгасан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх мэдэгдэл; - зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны хяналтын хувийн хэрэгтэй танилцсан талаарх прокурорын тэмдэглэл.
7	ШШГЕГ-ын даргын 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А/91 дугаар тушаалаар батлагдсан “Эрүү, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хяналтын хувийн хэргийг хянан шийдвэрлэх, нэгдсэн бүртгэл хөтлөх үйл ажиллагааны журам”.	- Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шийдвэрийг үндэслэн хувийн хэрэг нээх, цахим сан үүсгэж, нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, хяналт тавих, хяналтын хувийн хэргийг шилжүүлэх, татан хянах, хаахтай холбоотой харилцаа.

Дээрх тушаал, шийдвэр нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн өдөр тутмын үйл ажиллагаа буюу тайлан мэдээ, судалгаа хөтлөх, зардлыг тооцохтой холбоотой харилцааг зохицуулсан ба ялтны ял эдлэх нөхцөл, журмыг нарийвчлан зохицуулаагүй гэж үзлээ.

ДӨРӨВ. ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

4.1. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж буй байдал

Шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ялыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дараах хоёр хэлбэрээр оногдуулж иржээ. Үүнд:

1. Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шууд оногдуулах;
2. Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн солих зэрэг болно.

4.1.1. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээд

2021 онд шүүхээс нийт 11264 хүнд ял оногдуулснаас хорих ял 2518 буюу 22.3 хувь, торгох ял 6179 буюу 54.8 хувь, нийтэд тустай ажил хийлгэх ял 1518 буюу 13.4 хувь, зорчих эрхийг хязгаарлах ял 1049 буюу 9.3 хувийг нь тус тус эзэлж байсан бол 2022 оны эхний хагас жилд нийт 7577 эрүүгийн хэрэг шийдвэрлэж 8008 хүнд ял оносноос хорих ялаар 1541 хүн буюу 19,2 хувь нь, торгох ялаар 4448 хүн буюу 55.5 хувь нь, нийтэд тустай ажил хийлгэх ялаар 856 буюу 10.6 хувь нь, зорчих эрхийг хязгаарлах ялаар 1176 хүн буюу 14.5 хувь нь шийтгүүлсэн байна.

Улсын хэмжээнд 2021 онд 1049 хүнийг зорчих эрх хязгаарлах ялаар шийтгэж байсан бол зөвхөн 2022 оны эхний хагас жилд 1176 хүнд уг ялыг оногдуулжээ.

Хүснэгт 9. Шүүхээс зорчих эрх хязгаарлах ялыг шууд оногдуулсан ялтны судалгаа

Д/д	Нутаг дэвсгэр	Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хүний тоо		Өсөлт, бууралт
		2021 он	2022 оны эхний хагас жил	
1	Улаанбаатар	488	587	+99
2	Архангай	37	55	+18
3	Баян-Өлгий	13	17	+4
4	Баянхонгор	29	29	
5	Булган	9	39	+30
6	Говь-Алтай	14	9	-5
7	Говьсүмбэр	7	3	-4
8	Дархан-Уул	13	27	+14
9	Дорноговь	31	25	-6
10	Дорнод	14	39	+25

11	Дундговь	4	5	+1
12	Завхан	37	23	-14
13	Орхон	87	41	-46
14	Өвөрхангай	19	38	+19
15	Өмнөговь	9	8	-1
16	Сүхбаатар	19	14	-5
17	Сэлэнгэ	13	25	+12
18	Төв	55	71	+16
19	Увс	31	13	-18
20	Ховд	5	23	+18
21	Хөвсгөл	32	22	-10
22	Хэнтий	83	63	-20
	Нийт	1049	1176	+127

4.1.2. Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн солих

УИХ-аас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлан, мөн оны 7 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн даган мөрдөж буй Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулийн үйлчлэлийн хүрээнд хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольжээ.

Уг хуулийн зорилтыг “Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зарим гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэлээс нэг удаа өршөөн хэлтрүүлэх, чөлөөлөх, хасах, ялын төрлийг солихтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино”⁷⁷ хэмээн тодорхойлжээ.

Хуулийн үйлчлэлд 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн, 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 24 цаг 00 минутаас өмнө 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг хамааруулсан.

Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3 дугаар зүйлд хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн солих үндэслэлийг заасан.

⁷⁷ “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2021, №26.

Өршөөл үзүүлэх тухай хууль, 7.1 дүгээр зүйл, 2021 он

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд заасан Бусдын эд хөрөнгийг хулгайлах (Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэг) гэмт хэрэг, Эрүү шүүлт тулгах (Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.1 дэх хэсэг), 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд заасан Хулгайлах (Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг), Дээрэмдэх (Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), Залилах (Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), Хөрөнгө завших (Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг), Мал хулгайлах (Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах (Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), Эрүү шүүлт тулгах (Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл), Хууль бусаар ан агнах (Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), Хууль бусаар мод бэлтгэх (Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг), Ой, хээрийн түймэр тавих (Эрүүгийн хуулийн 24.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх (Эрүүгийн хуулийн 24.8 дугаар зүйл) гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтны шүүхээс оногдуулсан хорих ялын эдлээгүй үлдсэн ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солино.

Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар улсын хэмжээнд 576 хоригдлын эдэлж байсан хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон байна.

Хүснэгт 10. Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7.1-д заасан үндэслэлээр хорих ялыг нь зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон хоригдлын үйлдсэн гэмт хэргийн судалгаа

Орон нутаг	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	Эрүү шүүлт тулгах	Дээрэмдэх	Залилах	Эд хөрөнгө завших	Мал хулгайлах	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	Хууль бусаар ан агнах	Хууль бусаар мод бэлтгэх	Ой, хээрийн түймэр тавих	Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх
Улаанбаатар	97	3	23	64	9	2	54				
Архангай	3					16					
Баян-Өлгий					1						
Баянхонгор	3										
Булган	1		2	1		1					

Говьсүмбэр	6		2		1	4	1				
Дархан-Уул	13		4	6		2	3				1
Дорноговь	1		1			15					
Дорнод		1			1					1	
Дундговь			1								
Завхан	7		1		2	3					3
Өвөрхангай	7		12	3		5	5	1			
Сүхбаатар								1			
Сэлэнгэ	9		19	10		4	12				
Төв	17		4	11	3	14	25				1
Увс	3			1		8			2		1
Хөвсгөл	1		1	1				1			
Хэнтий	12		3	3	1	13	1		1		
Нийт	180	4	73	100	18	87	101	3	3	1	6

Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар хорих ялыг дүйцүүлэн сольсон гэмт хэргийн дийлэнхийг бусдын эд хөрөнгийг хулгайлах (180 буюу 31 хувь), мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах (101 буюу 18 хувь), залилах (100 буюу 17.3 хувь) гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Өршөөл үзүүлэх тухай хууль, 7.2 дугаар зүйл, 2021 он

2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд заасан Хулгайлах (Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2, 2.4 дэх заалт), Дээрэмдэх (Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг), Мал хулгайлах (Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг), Хууль бусаар ан агнах (Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг) гэмт хэрэг үйлдэж шүүхээс таван жил, түүнээс бага хугацаагаар хорих ял оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн ял нь таван жил, түүнээс бага хугацаа үлдсэн бол хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солино.

Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт зааснаар улсын хэмжээнд 715 хоригдлын эдэлж байсан хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон байна.

Хүснэгт 11. Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7.2-т заасан үндэслэлээр хорих ялыг нь зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон хоригдлын үйлдсэн гэмт хэргийн судалгаа

Д/д	Байршил	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	Дээрэмдэх	Мал хулгайлах
1	Улаанбаатар	148	50	6
2	Архангай	9	5	18
3	Баянхонгор	7		8
4	Булган	12	1	4
5	Говьсүмбэр	22	4	10
6	Дархан-Уул	39	9	
7	Дорноговь	1		1
8	Дорнод	3		14
9	Орхон	2	1	2
10	Завхан	1	5	
11	Өвөрхангай	36		24
12	Өмнөговь	1		1
13	Сүхбаатар	6		10
14	Сэлэнгэ	48		5
15	Төв	53	23	15
16	Увс	2		20
17	Хөвсгөл	7		13
18	Хэнтий	34	5	30
Нийт		431	103	181

Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт зааснаар хорих ялыг дүйцүүлэн сольсон гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэг 431 буюу 60.2 хувь, дээрэмдэх хэрэг 103 буюу 14.4 хувь, мал хулгайлах хэрэг 181 буюу 25.3 хувийг тус тус эзэлж байна.

Өршөөл үзүүлэх тухай хууль, 7.3 дугаар зүйл, 2021 он

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 6.2, 6.3-т заасан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн өсвөр насны хүнд оногдуулсан ялаас хоёр жилийг хасаж, эдлээгүй үлдсэн хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солино.

Улсын хэмжээнд Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт зааснаар хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (ЭХ-ийн 11.1 дүгээр зүйл) гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 1, хулгайлах (ЭХ-ийн 17.1

дүгээр зүйл) гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 3, дээрэмдэх (ЭХ-ийн 17.2 дугаар зүйл) гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 3, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх (ЭХ-ийн 20.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 1, өсвөр насны нийт 8 хоригдлын хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон байна.

Хүснэгт 12. Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7.3-т заасан үндэслэлээр хорих ялыг нь зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон хоригдлын үйлдсэн гэмт хэргийн судалгаа

Д/д	Байршил	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	Хулгайлах	Дээрэмдэх	Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх
1	Улаанбаатар	1	2	2	1
2	Өмнөговь		1		
3	Төв			1	
Нийт		1	3	3	1

Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-7.3 дахь хэсэгт зааснаар эрэгтэй 1240, эмэгтэй 51, насанд хүрээгүй 8, нийт 1299 хоригдлын ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольжээ.

Хүснэгт 13. Өршөөлийн хуульд хамрагдаж, зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон ялтны нас, хүйс, оршин суух газрын харьяаллын судалгаа

Д/д	Харьяалал	Эрэгтэй	Эмэгтэй	Насанд хүрээгүй	Нийт
1	Улаанбаатар	403	44	4	451
2	Архангай	50	1		50
3	Баян-Өлгий	1			1
4	Баянхонгор	15	3		18
5	Булган	23			23
6	Говь-Алтай				0
7	Говьсүмбэр	52			52
8	Дархан-Уул	77			77
9	Дорноговь	19		3	22
10	Дорнод	20			20
11	Дундговь	1			1
12	Завхан	22			22
13	Орхон	5			5
14	Өвөрхангай	95			95

Хүснэгт 13-ын үргэлжлэл

15	Өмнөговь	3			3
16	Сүхбаатар	17			17
17	Сэлэнгэ	109			109
18	Төв	162	2	1	165
19	Увс	36	1		37
20	Ховд				0
21	Хөвсгөл	24			24
22	Хэнтий	106			106
42	Нийт	1240	51	8	1299

Хүснэгт 14. Өршөөлийн хуульд хамрагдсан ялтнуудын өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан эсэх талаарх судалгаа

Д/д	Шүүхийн нэр	Урьд өмнө гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн байдал			Нийт
		Анх удаа	2 удаа	3-аас дээш удаа	
1	Улаанбаатар	273	113	77	463
2	Архангай	25	16	10	51
3	Баян-Өлгий		1		1
4	Баянхонгор	11	6	1	18
5	Булган	8	7	8	23
6	Говь-Алтай				0
7	Говьсүмбэр	19	13	20	52
8	Дархан-Уул	36	13	28	77
9	Дорноговь	14	3	5	22
10	Дорнод	14	4	2	20
11	Дундговь			1	1
12	Завхан	11	5	6	22
13	Орхон	1	4		5
14	Өвөрхангай	27	33	35	95
15	Өмнөговь	1	1	1	3
16	Сүхбаатар		3	4	7
17	Сэлэнгэ	27	34	49	110
18	Төв	85	39	38	162
19	Увс	30	4	3	37
20	Ховд				0
21	Хөвсгөл	16	5	3	24
22	Хэнтий	46	36	24	106
42	Нийт	644	340	315	1299

Өршөөлийн хуульд хамрагдан хорих ялыг нь зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольсон ялтнуудын 644 буюу 49.5 хувь нь анх удаагийн ял шийтгэлтэй, 340 буюу 26.1 хувь нь 2 удаагийн ял шийтгэлтэй, 315 буюу 24,2 хувь нь 3-аас дээш удаагийн ял шийтгэлтэй, 21 буюу 1.6 хувь нь урьд өмнө өршөөлийн хуульд хамрагдаж байсан байна.⁷⁸

4.2. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлж буй байдал

4.2.1. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны харьяа аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс нь хариуцсан нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн зорчих эрхийг хязгаарлах ялыг шууд оногдуулан, эсхүл хорих ялыг дүйцүүлэн сольж эхэлснээс хойш 2022 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд нийт 3524 ялтанд хяналт тавьжээ. Эдгээрийн 2225 буюу 64.2 хувьд нь зорчих эрхийг хязгаарлах ял шүүхээс оногдуулсан бол 1299 буюу 35.8 хувийг Өршөөл үзүүлэх тухай хуульд хамруулан хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольжээ.

Хүснэгт 15. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны тоо (2021, 2022 оны эхний хагас жилийн харьцуулалт)

Үзүүлэлт		2021 оны эхний хагас жил	2022 оны эхний хагас жил (өмнөх оны үлдэгдэл)	Өмнөх оны мөн үетэй харьцуулсан өсөлт
Бүртгэл хяналтад байсан нийт ялтны тоо		32	2234	+2202
Хяналтаас хасагдсан ялтны тоо		32	797	+765
Үүнээс:	Ялыг биечлэн эдэлж дууссан	11	489	+478
	Ялыг хорих ялаар сольсон	-	275	+275
	Өршөөлд хамрагдсан	-	4	+4
	Хэрэгсэхгүй буюу хүчингүй болсон	-	16	+16
	Өвчний учир ялаас чөлөөлсөн	-	1	+1
	Нас барсан		12	+12
Хяналтад үлдсэн ялтны тоо		21	1437	+1416

Шүүхээс 2022 оны эхний хагас жилийн байдлаар 1176 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан бөгөөд тэдгээрийн өмнө нь ял шийтгүүлж байсан

⁷⁸ Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн тайлан (2021 он).

эсэхийг судлан үзвэл анх удаа ял шийтгүүлсэн нь 748 буюу 63.6 хувь, хоёр ба түүнээс дээш гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн нь 428 буюу 36.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 16. 2022 оны эхний хагас жилд зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн хяналтад байгаа ялтны үйлдсэн гэмт хэргийн судалгаа

№	Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, хэсэг	Гэмт хэрэг үйлдсэн ялтны тоо	Эзлэх хувь
1	Хулгайлах (ЭХ-ийн 17.1)	241	20.4
2	Мал хулгайлах (ЭХ-ийн 17.12)	293	24.9
3	Дээрэмдэх (ЭХ-ийн 17.2)	143	12.1
4	Залилах (ЭХ-ийн 17.3)	133	11.3
5	Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах (ЭХ-ийн 20.7)	107	9.0
6	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (ЭХ-ийн 11.6)	102	8.6
7	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (ЭХ-ийн 27.10)	34	2.8
8	Хөрөнгө завших (ЭХ-ийн 17.4)	32	2.7
9	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (ЭХ-ийн 11.4)	23	1.9
10	Хууль бусаар ан агнах (ЭХ-ийн 24.5)	20	1.7
11	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх (ЭХ-ийн 11.7)	17	1.4
12	Хууль бусаар мод бэлтгэх (ЭХ-ийн 24.6)	13	1.1
13	Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох (ЭХ-ийн 12.5)	10	0.8
14	Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах (ЭХ-ийн 22.1)	8	0.6

Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд нь техникийн болон биечлэн хяналт тавьдаг.

■ Техникийн хяналт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд техникийн хяналт тавих чиг үүрэг бүхий Цахим хяналт, удирдлагын төв ажиллаж байна. Төвийн үйл ажиллагаа тасралтгүй зохион байгуулагдах бөгөөд ерөнхий зохицуулагч хоногийн ээлжийг ахалж, сүлжээний инженер, техник хяналтын ажилтан, операторын бүрэлдэхүүнтэй 4 ээлжээр ажилладаг. Тус төв нь ШШГЕГ, хэлтэстэй мэдээлэл шууд

солилцох бөгөөд техникийн хяналт тавих, цахим бугуйвч, хяналтын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх өрөөтэй байхаас гадна шаардлагатай үед ашиглах сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, цахим бугуйвчийн нөөц, хяналтын программ хангамжтай байна. ИШГЕГ-аас цахим бугуйвч болон хяналтын тоног төхөөрөмжийн мэдээллийг шуурхай хүлээн авч, сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэх нь төвийн үүрэг юм. Төвийн үйл ажиллагаанд цахим хяналтын дараах төхөөрөмжүүд ашиглагдаж байна.⁷⁹ Үүнд:

- Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем;
- Цахим бугуйвч;
- Үүрэн холбооны сим;
- Хяналтын дэлгэц (LCD дэлгэц);
- Цахим бугуйвчийн цэнэглэгч, нөөц цэнэг хураагуур;
- Сервер компьютер;
- Серверийн дагалдах тоног хэрэгсэл;
- Серверийн бусад компьютерт шаардлагатай хэрэглээний программ хангамж;
- Зөөврийн хяналтын төхөөрөмж (IPAD);
- Бусад.

Өнөөгийн байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг зөвхөн үүрэн холбооны сүлжээ орсон газарт хангах боломжтой тул хамгийн түгээмэл тархсан үүрэн холбооны оператор болон 2G сүлжээ дэмждэг цахим бугуйвч сонгон ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж байна.

Ялтанд тавих техникийн хяналтыг үүрэн холбооны сүлжээ (сим карт, 2G data) буюу мэдээлэл дамжуулагч (GPS)-ийн тусламжтайгаар гэмт этгээдийн байршил, хөдөлгөөнийг тогтоож, тухайн мэдээллийг цахим хяналтын системд мэдээлэх байдлаар хэрэгжүүлдэг.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглагдаж буй цахим бугуйвч нь БНХАУ-д үйлдвэрлэсэн бөгөөд 2G сүлжээний “data” буюу интернэтийн хурдаар мэдээлэл дамжуулан, цахимаар хяналт тавих боломжтой байдлаар зохицуулагдсан.

Зураг 9. Гарын цахим бугуйвчийн иж бүрдэл



⁷⁹ ИШГЕГ. Цахим хяналт, удирдлагын төвийн ажиллах журам. УБ., 2021.

2G сүлжээ нь тархцын хувьд манай орны нутаг дэвсгэрийг өргөн хамрах хэдий ч мэдээлэл, дохио дамжуулах хурд нь “384 kbps” буюу 3G сүлжээнээс даруй 112 дахин бага хурд, хүчин чадалтайгаас гадна үүрэн холбооны ачааллаас шалтгаалан сүлжээ унах, тодорхойгүй хугацаагаар тасрах, мэдээлэл дамжуулагч нь цемент, төмөр, бетон, тоосгоор баригдсан барилга, байгууламж болон байгалийн төрөл бүрийн тогтоц (өндөр уул, даваа, нугачаа)-той газар ойж сарнин, “алдах, хүлцэх” тохиолдол түгээмэл байдаг.

Цахим бугуйвчаар хяналт тавихад дараах хүндрэл үүсэж байна. Үүнд:

- Цахим бугуйвчийн цэнэг дууссан тохиолдолд дахин цэнэглэхэд төвөгтэй, суурин цахилгааны эх үүсвэрээр зориулалтын (толин) цэнэглэгчээр бүрэн цэнэглэсэн үедээ цэнэгээ барих хугацаа нь хагас өдөр буюу 10-12 цагаас хэтрэхгүй;
- Зориулалтын (толин) цэнэглэгчээр суурин цахилгаан эх үүсвэрт холбож бүрэн цэнэглэхэд дунджаар 1 цаг 30 минутын хугацаа зарцуулдаг бөгөөд цэнэглэх хугацаанд ялтан нэг цэгт хөдөлгөөнгүй удаан байрлах шаардлагатай, цахим бугуйвчийн зориулалтын (толин) цэнэглэгч нь хэтэрхий богино тул цэнэглэхэд хүндрэлтэй (толин цэнэглэгчийн урт 40 см);
- Зөөврийн цэнэглэгчээр цахим бугуйвчийг зөвхөн нэг удаа бүрэн цэнэглэх боломжтой ба бүрэн цэнэглэхэд 30-40 минут зарцуулж 4-5 цагийн хугацаанд цэнэгээ барьдаг;
- Цахим бугуйвчийн байршил тогтоогч (GPS) нь орон байр (объект)-наас гарах хөдөлгөөн хийгээгүй үед хиймэл дагуулаас ирсэн мэдээллийн сүүлчийн байршилд тухайн цагт гацаж, явсан маршрутыг заадаггүй;
- Үүрэн холбооны тархцын антеннаас хамаарсан сүлжээний тасалдал, доголдол болон дата дугаар ашиглахтай холбогдон гарсан зардал, төлбөрийн асуудал зэрэг болно.

Булган, Сэлэнгэ аймагт зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй 20 ялтантай ярилцахад бүгд “Цахим бугуйвчийг цэнэглэхэд хүндрэлтэй, цэнэг нь хурдан дуусдаг” гэсэн яриа, өгүүлэлтэй байна.

Цахим бугуйвчийн сүлжээ, байршил заагчийн талаар судлан үзэхэд дараах дүгнэлтэд хүрсэн. Үүнд:

- Гэр хороолол, монгол гэр, хувийн байшинд хиймэл дагуул хөдөлгөөн мэдрэхэд саатах зүйл байхгүй тул байршил хэвийн заадаг;
- Орон сууц, объектод орсон үед хиймэл дагуулаас байршлын мэдээ хүлээн авах боломжгүй, ойлтын цэг үүссэнээр байршил тогтоогч (GPS)-ийн огноо тухайн хөдөлгөөн хийсэн сүүлчийн цагийг заан гацаж, дараагийн цагийг заахгүй байгаа нь ялтныг цахим хяналтаас алдах, ял завшуулах эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэж байна.

Цахим бугуйвч нь “хүний биед харшил өгөхгүй, хүний гар болон хөлд зүүхээр тохируулсан, хөнгөн жинтэй, ус, доргио, шорооны хамгаалалттай, халуун, хүйтнийг тэсвэрлэх” боломжтой бөгөөд “таслах, тайлах, оролдох” үед хяналтын нэгдсэн системд анхааруулга өгөх горимоор ажилладаг.

Цахим бугуйвч “Зорчих эрхийг хязгаарлах ялын хяналтын систем”-д 9 төрлийн анхааруулга дохио ирүүлэх боломжтой. Үүнд:

- цэнэг дуусаж байна;
- цэнэг дуусаж байна, яаралтай цэнэглэнэ үү;
- зөвшөөрөгдсөн бүсээс гарсан;
- яаралтай үеийн дуудлага (SOS);
- маршрутаас гарсан;
- хориглосон бүсэд 200 метр ойртсон;
- хориглосон бүсэд нэвтэрсэн;
- бугуйвч, оосор тайлагдсан;
- бүсийн хязгаарт 200 метр ойртсон.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчдийн дунд хийсэн хэлэлцүүлгийн хүрээнд ял эдлүүлэх ажиллагааны явцад бүсийн хязгаарт 200 метр ойртсон анхааруулга их ирж байгаа нь шүүхийн шийтгэх тогтоолын дагуу тухайн бүсийг зурж системд оруулахдаа хяналтад орж буй ялтанд зорчих бүсийн хязгаарыг сайн мэдээлээгүй, түүнчлэн “Зөвшөөрөгдсөн бүсээс гарсан” гэсэн анхааруулга нь зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан бүсийн хязгаарыг мэдэхгүй гарах, зарим тохиолдолд цахим бугуйвчаас шалтгаалсан маршрут хэвийн зааж байхад байрлал тогтоогч нь 5-10 секундний хугацаанд үсэрч, байрлал буруу зааж байгаа зэрэг зөрчил их байна гэжээ.⁸⁰

Судалгааны дүн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, техник хяналтын ажилтнуудын хэлэлцүүлгээс гаргасан саналыг нэгтгэсний дүнд цахим хяналтыг сайжруулах хүрээнд дараах асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

1. Ялтны мэдээллийг бүрэн судлахуйц мэдээлэл татах платформыг холбох;
2. Геодезийн нарийвчилсан зураглалаар хот, аймаг, дүүрэг, баг, хороодын хилийн бүсийг харуулсан хязгаарыг зөв тогтоож хөгжүүлсэн, байр, орон сууцны дугаар, гудамжны нэршил, хашааны тоот зэргийг дэлгэрэнгүй харуулсан газрын байршлын зураглалыг хөгжүүлэх;
3. Шагналын хоног олгох дэд цэс нэмэх;
4. Цахим бугуйвчаас хяналтын системд ирж байгаа анхааруулга нь хяналтын хэсэгт ирэхэд дуут дохио өгдөг байх;

⁸⁰ Дархан-Уул аймагт 2022 онд зохион байгуулагдсан “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаа, тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлгийн тэмдэглэл.

5. Цахим хяналт, удирдлагын төвд ашиглагдаж байгаа 2G сүлжээг дэмждэг 2280 ширхэг цахим бугуйвчийг өргөн хүрээний 3G сүлжээнд нэвтрүүлэх;
6. “Тусгай дугаарт мессежний үйлчилгээ” нэвтрүүлэх, программчлалын интерфэйсийг холбох;
7. Өргөн хүрээний 3G сүлжээг нэвтрүүлэх боломжгүй тохиолдолд 2G сүлжээний хүчин чадлыг сайжруулах тоног төхөөрөмжийн судалгаа хийж, ял эдлүүлэх ажиллагаанд нэвтрүүлэх боломжийг судлах;
8. Цахим бугуйвчийн цэнэг хурдан дуусдаг үзүүлэлтийг өөрчлөх;
9. Зарим тохиолдолд хүний биед харшил өгч, гарын арьсыг түлэх тохиолдол гарч байгааг анхаарах;
10. Байршил алдаатай заадаг, оосор нь хэврэг, хос түгжээ нь эвдэрдэг, соронз нь хөлдөж хугардаг тул чанарыг нь сайжруулах;
11. Биеийн температур алдаатай заадаг, сүлжээ муу барьдаг зэргийг сайжруулах;
12. Гараас мултлах үед дохио ирдэг болгох, сүлжээгүй газар гацахад заавал механикаар тохируулж байгааг өөрчлөх;
13. Гарын цахим бугуйвчийг цэнэглэхэд хүндрэлтэй, зориулалтын цэнэглэгч хурдан эвдэрдэг, цэнэглэх явцад хэт халж, бугуйвчийн их бие шатах зэрэг асуудал гарч байгааг сайжруулах шаардлагатай.

Техникийн хяналтын хүрээнд анхаарал татсан өөр нэг асуудал нь хяналтын тоног төхөөрөмжийн зардал бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 169.1-д ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэгтэй гэж заасан.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд техникийн хяналт тавихдаа гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглаж байгаа бөгөөд үүнд дараах зардлыг хамааруулна:

1. Үүрэн холбооны сүлжээний (сим карт, дата, зурвас илгээх) ашиглалтын зардал;
2. Гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал.

Шийдвэр гүйцэтгэгч ашиглалтын зардлыг тооцохдоо тоног төхөөрөмж ашиглах хугацааны зардлыг хоногоор, хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг тухайн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаанд харьцуулж, сүлжээний хоногийн зардлыг нэмж, ял эдлэх хоногт үржүүлэн тооцож байна.⁸¹

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд техникийн хяналт тавихад ашигласан тоног төхөөрөмжийг санаатайгаар устгасан, гэмтээсэн,

⁸¹ Засгийн газрын 94 дүгээр тогтоол. Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам. 2021.

эсхүл хэвийн ажиллагааг нь сарниулж, дахин ашиглах боломжгүй болгосон бол хуульд заасан хариуцлага ногдуулж, холбогдон гарах зардлыг тооцон ял шийтгүүлсэн болон бусад гэм буруутай этгээдээр төлүүлдэг.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч зардлын тооцооллыг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг хоног, сар, улирал, жилээр тооцон ялтнаар нөхөн төлүүлэх шийдвэр гаргах ба шийдвэрт нөхөн төлүүлэх зардал, хохирлын хэмжээ, нөхөн төлөх үүрэг бүхий этгээдийн овог, нэр, зардал төвлөрүүлэх данс, төлөх хугацаа, нөхөн төлөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар тусгана. Шийдвэр гүйцэтгэгч ялтан, эсхүл гэм буруутай этгээдэд нөхөн төлүүлэх тухай шийдвэрийг хүргүүлж, тогтоосон хугацаанд биелүүлэх мэдэгдэх хуудас гардуулж, тэмдэглэлээр баталгаажуулна.

Зардал, хохирол нөхөн төлөх шийдвэрийг биелүүлэх үүрэг хүлээсэн этгээд ялын хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө зардлыг бүрэн барагдуулах бөгөөд шийдвэр гүйцэтгэгч зардал, хохирлын мөнгө хүлээн авсан баримтыг 3 хувь үйлдэж, санхүүгийн баримт болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэгт хавсарган, 1 хувийг мөнгө тушаасан этгээдэд олгодог.⁸²

Ял шийтгүүлсэн этгээд зардал, хохирол нөхөн төлөх шийдвэрийг заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд ялаа эдэлж дууссанаас хойш 30 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгч шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар гүйцэтгүүлдэг байна. Зардал нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр гарч, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар шийдвэрлүүлэх хүртэлх хугацаанд тухайн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх ба орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар ялтнаас нөхөн гаргуулж, буцаан төвлөрүүлдэг.

Журамд өсвөр насны хүний зардлыг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хариуцахаар зохицуулсан. Гэтэл Иргэний хуулийн 503.1-д “7-14 хүртэлх насны болон эрх зүйн чадамжгүй иргэний бусдад учруулсан гэм хорыг тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч хариуцан арилгана” гэж тухайлан заасан. Тиймээс өсвөр насны буюу хэрэг хариуцах чадвартай, 14-18 насны хүний хувьд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь тухайн үүргийг хариуцуулсан нь ял халдаан хэрэглэж буй нэг хэлбэр гэж үзэхээр байна.

Ял шийтгүүлсэн этгээдийг дараах үндэслэлээр зардлаас чөлөөлж болохоор зохицуулсан. Үүнд:

1. Асран хамгаалах хүнгүй, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 60 ба түүнээс дээш насны ахмад настан;
2. Хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон ялтан;

⁸² Мөн тэнд.

3. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, 4 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх;
4. Гурав хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх;
5. Бүтэн өнчин хүүхэд.

Шийдвэр гүйцэтгэгч нь зардлаас чөлөөлүүлэх тухай ялтны хүсэлт, засаг захиргааны нэгжийн тодорхойлолт, эрх бүхий байгууллагын дүгнэлт, шаардлагатай бусад баримтыг хавсарган ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргана. Ахлах шийдвэр гүйцэтгэгч санал, холбогдох баримт бичгийг хянаж үзээд зардлын төлбөрөөс чөлөөлөх, эсхүл татгалзсан шийдвэрийн аль нэгийг гаргана. Ахлах шийдвэр гүйцэтгэгч зардлаас чөлөөлөхөөс татгалзсан тохиолдолд тухайн орон нутгийн шийдвэр гүйцэтгэх албаны даргад гомдол гаргах эрхтэй.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчдийн дунд хийсэн хэлэлцүүлэг, судалгааны асуулгын хүрээнд аймаг, нийслэл дэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсүүдэд зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлэхэд нь зориулан улсын төсөвт тусгайлан суулгасан зардал байхгүй байгаагаас ялтанд биечилсэн хяналт тавих, цахим бугуйвч, бусад техник хэрэгсэл засварлах, шинээр худалдан авах, ялтан болон хамаарал бүхий бусад хүмүүст зориулсан сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах, ялтныг ялаас зайлсхийсэн, зайлсхийхийг завдсан тохиолдолд таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, оргон зайлсан ялтныг эрэн сурвалжилж, олж баривчлах үйл ажиллагаа доголдох магадлалтай байгаа тул зардлыг шийдвэр гүйцэтгэх албаны төсөвт тусгадаг тогтолцоонд шилжих шаардлагатай гэж үзлээ.


■ Биечилсэн хяналт

Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд сард хоёроос доошгүй удаа биечилсэн хяналт тавьж, тэмдэглэл хөтлөх ба ажлын бус өдөр, эсхүл шөнийн цагаар хянах ажиллагаа явуулах тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчид энэ тухай мэдэгдэж, тэмдэглэлд тусгана.

Алслагдмал орон нутагт ял эдэлж буй ялтны хувьд цагдаагийн байгууллагад хандан шалгуулах ба цагдаагийн байгууллага нь мэдээллийг шалгаж, холбогдох материалыг тухайн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ирүүлнэ.


Ялтан биечлэн, эсхүл бусдаар дамжуулан шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн, эсхүл зөрчихийг завдсан талаарх мэдээллийг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь хүн, хуулийн этгээдээс авна.

График 4. 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналтад байгаа ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын хугацаа



Шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ялын хугацааг дийлэнх тохиолдолд 1 жил хүртэл хугацаагаар оногдуулж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж, цахим хяналтад байгаа 2234 (өмнөх оны хяналтад байгаа ялтны тоо нэмэгдсэн) ялтны 1086 буюу 48.6 хувь нь нийслэлд, 1148 буюу 51.3 хувь нь орон нутагт ял эдэлж байна.

График 5. 2022 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэл хяналтад байсан зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны ял эдэлж буй байршил




Зорчих эрхийг хязгаарлах ялд биечлэн хяналт тавих үүрэг гүйцэтгэж буй эрүүгийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчдийн 33 буюу 34.3 хувь нь нийслэлд, 63 буюу 65.7 хувь нь орон нутагт харьяалагдаж байна.

Нийслэлд харьяалагдаж буй 4 ахлах шийдвэр гүйцэтгэгч, 29 шийдвэр гүйцэтгэгчээс 1 ахлах шийдвэр гүйцэтгэгч, 9 шийдвэр гүйцэтгэгч нь зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг дагнан хариуцаж байгаа бөгөөд орон нутагт ажиллаж байгаа 27 ахлах шийдвэр гүйцэтгэгч, 36 шийдвэр гүйцэтгэгч

хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг бүхэлд нь хариуцаж байна.


Улсын хэмжээнд 2022 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар ажиллаж байгаа 30 ахлах шийдвэр гүйцэтгэгч, 62 шийдвэр гүйцэтгэгчийн судалгааг гаргалаа.

График 6. Ахлах болон шийдвэр гүйцэтгэгчдийн хүйсийн судалгаа



Төгссөн сургуулиар нь ангилж үзвэл ахлах шийдвэр гүйцэтгэгчдийн 1 буюу 3.3 хувь нь Дотоод хэргийн их сургууль, 5 буюу 16.6 хувь нь Хууль сахиулахын их сургууль, 4 буюу 13.3 хувь нь Цагдаагийн академид суралцаж төгссөн бол үлдсэн 20 буюу 66.6 хувийг бусад сургуулийн төгсөгчид; шийдвэр гүйцэтгэгчдийн 16 буюу 25.8 хувь нь Дотоод хэргийн их сургууль, 4 буюу 6.4 хувь нь Хууль сахиулахын их сургууль, 1 буюу 1.6 хувь нь Цагдаагийн академид суралцаж төгссөн бол үлдсэн 41 буюу 66.1 хувийг бусад сургуулийн төгсөгчид эзэлж байна.

График 7. Ахлах болон шийдвэр гүйцэтгэгчдийн төгссөн сургуулийн судалгаа



Эрх зүйч мэргэжил эзэмшсэн байдал чухал бөгөөд өнөөгийн байдлаар зөвхөн Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны

сургуульд “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа” гэсэн хичээл заадаг ба хуулийн бусад их, дээд сургуулийн тухайд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” хичээлийн хүрээнд 2 цагийн багтаамжтай заадаг тул тухайн ажилтны онолын мэдлэгийг давтан болон мэргэшүүлэх сургалтаар нэмэгдүүлэх шаардлага урган гарч байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 2017 онд шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2017 онд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан 3155, 2018 онд 13365, 2019 онд 19369, 2020 онд 22507, 2021 онд 21799, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 14236 этгээдэд тус тус хяналт тавин ажиллажээ. Энэ нь жил тутам хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан ялтан, этгээдийн тоон үзүүлэлт нэмэгдэж байгааг харуулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А/247/А/167/303 дугаар хамтарсан тушаалаар баталсан жишиг нормативын дагуу эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийг нийслэлд 160, орон нутагт 120 ялтан, этгээдэд хяналт тавьж ажиллуулахаар тогтоосон боловч хорихоос өөр бүх төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж байгаагаас шалтгаалан ачааллын хувьд харьцангуй өндөр байна.

Хүснэгт 17. 2022 оны эхний хагас жилд хяналт тавьж ажилласан ялтан, этгээдийн тоон үзүүлэлтийн харьцуулалт (Орон нутгаар)

Д/д	Аймаг, нийслэл дэх ШШГТ, хэлтэс	Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн орон тоо	Хяналт тавьж ажилласан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтны тоо				Хяналт тавьж ажилласан албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн тоо	Нийт ялтан, этгээдийн тоо	Нэг шийдвэр гүйцэтгэгчид ноогдож буй хүн
			Зорчих эрхийг хязгаарлах	Нийтэд тустай ажил хийлгэх ялтай	Торгох	Эрх хасах			
1	Нийслэл	31	744	165	1008	651	1084	3652	210
2	Архангай	1	57	2	27	44	88	218	654
3	Баян-Өлгий	2	30	5	25	53	59	172	215
4	Баянхонгор	2	39	6	25	23	114	207	258
5	Булган	1	15	1	27	14	88	145	435
6	Говь-Алтай	1	15	1	18	18	73	125	375
7	Говьсүмбэр	1	8	5	13	9	12	47	141

Хүснэгт 17-гийн үргэлжлэл

8	Дархан-Уул	1	31	8	63	37	95	234	702
9	Дорноговь	2	29	1	35	30	100	195	292
10	Дорнод	1	45	8	36	58	128	275	825
11	Дундговь	1	7	1	28	21	36	93	279
12	Завхан	2	37	7	6	28	82	151	231
13	Орхон	2	67	2	39	38	82	228	285
14	Өвөрхангай	2	43	5	26	36	91	201	301
15	Өмнөговь	2	18	1	27	36	75	156	234
16	Сүхбаатар	1	25	2	8	23	40	98	294
17	Сэлэнгэ	3	25	8	66	53	176	328	328
18	Төв	2	33	6	35	33	63	170	212
19	Увс	2	49	6	22	26	116	219	274
20	Ховд	2	22	3	32	45	90	192	286
21	Хөвсгөл	2	30	8	26	49	119	232	290
22	Хэнтий	1	69	23	22	22	121	257	771

Дээрх судалгаанаас харахад шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчид батлагдсан жишиг нормативаас нийслэлд 25 хувиар, орон нутагт даруй 3 дахин илүү ялтан, этгээдэд хяналт тавьж байна. Эндээс дүгнэхэд ялтан, этгээд бүрд хүрч хяналт тавих боломж хязгаарлагдмал болж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад хүндрэл учрахаар байна. Ялангуяа нормативаас хэт их байгаа аймгуудыг дурдвал Архангай, Дархан-Уул аймагт 4 дахин, Дорнод, Хэнтий аймгийн хувьд 5 дахин их байна.

Хүснэгт 18. Шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын ачааллын судалгаа

Д/д	Аймаг, нийслэл дэх ШШГГ, хэлтэс	Нэг шийдвэр гүйцэтгэгчид ноогдож буй ялтан	Норматив ёсоор тогтоосон байдал	Нормативтай харьцуулсан байдал
1	Нийслэл	210	160	+50
2	Архангай	654	120	+534
3	Баян-Өлгий	215	120	+95
4	Баянхонгор	258	120	+138
5	Булган	435	120	+315
6	Говь-Алтай	375	120	+255
7	Говьсүмбэр	141	120	+21
8	Дархан-Уул	702	120	+582
9	Дорноговь	292	120	+172
10	Дорнод	825	120	+705


11	Дундговь	279	120	+159
12	Завхан	231	120	+111
13	Орхон	285	120	+165
14	Өвөрхангай	301	120	+181
15	Өмнөговь	234	120	+114
16	Сүхбаатар	294	120	+174
17	Сэлэнгэ	328	120	+208
18	Төв	212	120	+92
19	Увс	274	120	+154
20	Ховд	286	120	+166
21	Хөвсгөл	290	120	+170
22	Хэнтий	771	120	+651

Судалгааны хүрээнд Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ зэрэг аймгийн хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг судаллаа.

■ Булган аймаг дахь зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт

Булган аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг эрүүгийн ахлах шийдвэр гүйцэтгэгч 1, шийдвэр гүйцэтгэгч 1, техник хяналтын ажилтан 1, нийт 3 алба хаагч хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 оны эхний хагас жилд зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн 25 ялтанд хяналт тавьж ажилласнаас ялаа бүрэн эдэлж дууссан 7, ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчсөн үндэслэлээр ялыг нь хорих ялаар сольж шийдвэрлэсэн 3, нийт 10 ялтан хяналтаас хасагдаж, 2022 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар 15 ялтан хяналтад байна.

График 8. Булган аймгийн хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлсэн байдал




Тус газрын эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг оролцуулан сард дунджаар 435 ялтанд хяналт тавьж ажилласан нь нормативаас даруй 315 хүнээр илүү байлаа.

■ Дархан-Уул аймаг дахь зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт

Дархан-Уул аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг эрүүгийн ахлах шийдвэр гүйцэтгэгч 1, шийдвэр гүйцэтгэгч 1, техник хяналтын ажилтан 1, шуурхай албаны ажилтан 1, нийт 4 алба хаагч хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 оны эхний хагас жилд зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн 63 ялтанд хяналт тавьж ажилласнаас ялаа бүрэн эдэлж дууссан 19, ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчсөн үндэслэлээр шүүхээс ялыг нь хорих ялаар сольж шийдвэрлэсэн 12, хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 1, нийт 32 ялтан хяналтаас хасагдаж, 6 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар 31 ялтан хяналтад байна.

График 9. Дархан-Уул аймгийн хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлсэн байдал




Тус газрын эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг оролцуулан сард дунджаар 702 ялтанд хяналт тавьж ажилласан нь нормативаас даруй 582 хүнээр илүү байлаа.

■ Орхон аймаг дахь зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт

Орхон аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг эрүүгийн ахлах шийдвэр гүйцэтгэгч 1, шийдвэр гүйцэтгэгч 1, техник хяналтын ажилтан 1, шуурхай албаны ажилтан 1, нийт 4 алба хаагч хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 оны эхний хагас жилд зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн 97 ялтанд хяналт тавьж ажилласнаас ялаа бүрэн эдэлж дууссан 14, ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчсөн үндэслэлээр шүүхээс ялыг нь хорих ялаар сольж шийдвэрлэсэн 16, нийт 30 ялтан хяналтаас хасагдаж, 6 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар 67 ялтан хяналтад байна.

График 10. Орхон аймгийн хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлсэн байдал




Тус газрын эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг оролцуулан сард дунджаар 285 ялтанд хяналт тавьж ажилласан нь нормативаас даруй 165 хүнээр илүү байлаа.

■ Сэлэнгэ аймаг дахь зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт

Сэлэнгэ аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг эрүүгийн ахлах шийдвэр гүйцэтгэгч 1, шийдвэр гүйцэтгэгч 1, техник хяналтын ажилтан 1, нийт 3 алба хаагч хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 оны эхний хагас жилд зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн 27 ялтанд хяналт тавьж ажилласнаас ялаа бүрэн эдэлж дууссан 12, өршөөлд хамрагдсан 1, нийт 13 ялтан хяналтаас хасагдаж, 6 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар 14 ялтан хяналтад байна.

График 11. Сэлэнгэ аймгийн хэмжээнд зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлсэн байдал



Тус газрын эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг оролцуулан сард дунджаар 328 ялтанд хяналт тавьж ажилласан нь нормативаас даруй 208 хүнээр илүү байлаа.

Судалгааны хүрээнд зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад шийдвэр гүйцэтгэгчээс гадна техник хяналтын ажилтнаар хангаж бүтэц, орон тооны хувьд бэхжүүлэх, ялтан гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтмол хугацаанд биечилсэн хяналт тавих, байршил, хөдөлгөөнд шалгалт хийх, эрэн сурвалжлагдаж байгаа ялтныг эрж хайх чиг үүрэг бүхий ажилтан бий болгох шаардлага байна гэж дүгнэлээ.

4.2.2. Ялтны үйлдсэн гэмт хэрэг, зөрчил

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журам зөрчсөн ялтанд зөрчил дахин гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар сануулж, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх ярилцлага хийн тэмдэглэл үйлдэх ба ялтан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд уг ялыг хорих ялаар солих санал гаргана.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.1-д зааснаар техникийн хяналтын ажилтан нь мэдээллийн санд зөрчлийн дохио ирсэн даруйд хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, зөрчлийн талаарх мэдээллийг хүргүүлэх ба шийдвэр гүйцэтгэгч ирүүлсэн зөрчлийн тухай мэдээллийг биечлэн шалгаж, шалтгаан, нөхцөлийг тогтоодог.

Ялтан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэхэд ашиглах тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл хэвийн ажиллагааг нь сарниулсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэж, учирсан хохирлыг нь гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг байна.

2021 оноос 2022 оны 6 дугаар сарын 1 хүртэлх хугацаанд зорчих эрхийг хязгаарлах ялыг нь хорих ялаар сольсон 427 ялтан байгаагаас гэмт хэрэг дахин үйлдсэн 32 (7.4 хувь), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д заасан ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчсөн 395 ялтан байна.⁸³

⁸³ Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны 2022 оны эхний хагас жилийн тайлан.

График 12. Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй ялтны үйлдсэн гэмт хэргийн судалгаа





График 13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх заалтыг зөрчсөн ялтны судалгаа



Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх явцад ялтан ямар төрлийн зөрчил түлхүү гаргаж байгаа талаарх асуултад эрүүгийн 34 шийдвэр гүйцэтгэгч доорх байдлаар хариулжээ.


Хүснэгт 19. Ялтны гаргаж буй нийтлэг зөрчил

Гаргаж буй зөрчил	Шийдвэр гүйцэтгэгчийн	
	тоо	хувь
Цахим бугуйвч цэнэггүй болгох	15	44,1
Бүс зөрчих	7	20,5
Оргон зайлах	9	26,4
Цахим гавыг унтраах	2	5,8
Төлбөр төлөхөөс зайлсхийх	1	2,9

Дээрх гэмт хэрэг, зөрчил үйлдсэний улмаас зорчих эрхийг хязгаарлах ялыг нь хорих ялаар сольсон 427 ялтны 318 буюу 76.2 хувь нь Өршөөл

үзүүлэх тухай хуульд хамрагдан, хорих ялаа зорчих эрхийг хязгаарлах ялаар солиулсан ялтан байна. Зорчих эрхийг хязгаарлах ялыг нь хорих ялаар сольсон ялтнуудын 131 нь буюу 30.6 хувь нь нийслэлд, 296 нь буюу 69.3 хувь нь орон нутагт оршин суудаг.

График 14. Зорчих эрхийг хязгаарлах ялыг нь хорих ялаар сольсон ялтны судалгаа



4.2.3. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал

Судалгааны хүрээнд зорчих зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад учирч буй хүндрэл бэрхшээлийн талаарх асуултад эрүүгийн 34 шийдвэр гүйцэтгэгч оролцож, доорх байдлаар хариулсан болно.

Хүснэгт 20. Зорчих эрхийг хязгаарлах ялд хяналт тавихад тулгамдаж буй асуудал

Тулгамдаж буй асуудал	Шийдвэр гүйцэтгэгчийн	
	тоо	хувь
Сүлжээ доголддог, системийн хурд муу, гацдаг.	14	41,1
Цахим бугуйвч цэнэг муу барьдаг.	7	20,5
Биечлэн хяналт тавих болон оргосон ялтныг эрэн хайх ажиллагааны зардал байхгүй.	6	17,6
Цахим бугуйвчийн эвдрэл их.	3	8,8
Биечлэн хяналт тавихад ачаалал ихтэй.	3	8,8
Алба хаагчийн аюулгүй байдал хангалтгүй.	1	2,9

Судалгааны явцад зарим ялтны хувийн хэрэгт дүн шинжилгээ хийж үзэхэд дараах бэрхшээл, хүндрэл байна. Үүнд:

- 1. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан ялтан нь ял эдлэх хугацаандаа ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчиж, улмаар гэмт хэрэг дахин үйлдсэн байхад шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял дахин оногдуулж байгаа нь хариуцлагын үр нөлөөг сулруулж байна.

Кейс 1.

“Б” овогтой “П” нь 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 2021/ШЦТ/28 дугаар шийтгэх тогтоолоор ЭХ-ийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2, 2.4-т зааснаар 4 сар 26 хоногийн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлэн ял эдэлж байх хугацаандаа замын хөдөлгөөнд оролцож, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтыг зөрчсөний улмаас зам тээврийн осол гаргаж, хүн дайрч, биед нь хүндэвтэр хохирол учруулсан (ЭХ-ийн 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг) гэмт хэрэг үйлдсэн байх тул Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 2022/ШЦТ/04 дүгээр шийтгэх тогтоолоор зорчих эрхийг нь 4 сараар хязгаарлах ял оногдуулж, эдлээгүй үлдсэн 2 сар 23 хоногийн ял дээр тухайн ялыг нэмж, нэгтгэн 6 сар 23 хоногийн зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэжээ.

2. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны дахин болон өмнө үйлдсэн гэмт хэрэгт хорих, торгох, нийтэд тустай ажил хийлгэх зэрэг үндсэн ялыг тус тусад нь эдлүүлэхээр шүүх шийдвэрлэсэн тохиолдолд аль ялыг нь эхэлж эдлүүлэх талаар нэгдсэн ойлголтод хүрэх, шүүхийн шийдвэрт энэ талаар тодорхой заах хэрэгтэй байна.

Кейс 2.

“Я” овогтой “Х” нь Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 2021/ШЦТ/99 дүгээр шийтгэх тогтоолоор 1 жилийн зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн. Ял эдлэх хугацаандаа Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 2021/ШЦТ/125 дугаар шийтгэх тогтоолоор ЭХ-ийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг үйлдэж, 380 цагийн нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлснийг зэрэгцүүлэн эдлүүлэхээр тогтоосон.

3. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа хувь хүний зан үйл, гэмт хэргийн байдал, байнга оршин суух хаяг, төлбөрийн чадвар, хувийн нөхцөл байдал, сүлжээний хамрах хүрээний тархалт зэргийг харгалзан хориглолт, хязгаарлалт, бүсийг нарийвчлан тогтоогоогүйгээс ялтанд ял эдлүүлэхэд хүндрэл үүсэхээр байна.

Кейс 3.

Ялтан “М” овогтой “Д” нь Сонгинохайрхан дүүргийн 39-р хороо Хангайн 51-р гудамжны 5 тоот хаягт бүртгэлтэй боловч шийтгэх тогтоолд тусгагдсан хаягт оршин суудаггүй, ам бүл 1, оршин суух тогтсон хаяггүй.

Зорчих эрхийг хязгаарлах ялд тавьж буй хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр эрүүгийн 34 шийдвэр гүйцэтгэгч дараах саналуудыг гаргасан болно:

- Ялтны хувийн байдал (оршин суух хаяг, хөдөлмөр эрхлэлт, үйлдсэн гэмт хэрэг, хувийн зан байдал)-ыг харгалзан шүүхээс уг ялыг оногдуулж байх;
- Цахим хяналтын сүлжээг сайжруулах;
- Цахим бугуйвчийн техникийн үзүүлэлт, хүртээмжийг сайжруулах;
- Оргосон ялтныг эрэн сурвалжлах нэгж бий болгох;
- Ялтан оргосон тохиолдолд оршин суух хаягийг нь олж тогтоон, албадан ирүүлж ялыг хорих ялаар солих асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх хүртэлх хугацаанд саатуулах зохицуулалт бий болгох;
- Ял эдлэхээс зайлсхийсэн хугацааг нарийвчлан тооцож, ял эдэлсэн хугацаанд тооцохгүй байх;
- Ял эдлэх явцдаа цагдан хоригдсон, зөрчлийн хуулиар шийтгүүлж баривчлагдсан тохиолдолд ялыг түдгэлзүүлэх;
- Хяналтын үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг шийдвэрлэх;
- Ялтны байрлал, маршрутын хүрээ, хязгаарлалтын нарийвчлалыг улам тодорхой болгох;
- Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж буй этгээдэд шагналын хоног олгох асуудлыг холбогдох хууль, журмаар нарийвчлан зохицуулж өгөх;
- Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл журмыг өөрчлөх, ялыг хорих ялаар солих асуудлаар прокурорын байгууллагатай нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай зэрэг эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

ТАВ. ДҮГНЭЛТ

Судалгааны хүрээнд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтийг судлан, тулгамдсан асуудлуудыг тодорхойлохыг эрмэлзсэний үр дүнд дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Зорчих эрхийг хязгаарлах ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр, хамт олон, гэр бүлийнхээ орчинд суралцах, хөдөлмөрлөх эрхийг нь ханган хэрэгжүүлж буйгаараа ихээхэн ач холбогдолтой байна. Ял эдлүүлэх энэхүү ажиллагаанд хянах-нийгэмшүүлэх ажлыг зөв хослуулж зохион байгуулснаар гэмт хэрэг дахин үйлдэх явдлыг бууруулахад чухал түлхэц болох юм.
2. Дэлхийн улс орнуудын шүүхийн практикт шүүхийн өмнөх, ял эдлүүлэх, хорих ял эдлээд хугацаанаасаа өмнө суллагдах үеүдэд зорчих эрхийг хязгаарлах арга хэмжээг сонгож хэрэглэдэг жишиг нэгэнт тогтжээ. Монгол Улсын хувьд цахим хяналтын системээ шинэчлэн, эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтаа сайжруулсан нөхцөлд дээрхийн адил бүх төрлийн ял, албадлага, таслан сэргийлэх арга хэмжээнд үүнийг хэрэглэх боломжтой гэж үзлээ.
3. Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг 240 төрлийн буюу ихэвчлэн үйлдэгддэг хөнгөн 121, хүнд 119 гэмт хэрэгт ногдуулахаар тогтоосон ба шүүхээс уг ялыг ногдуулсан тоо сард 45-50, жилд дунджаар 540-600 ялтнаар өсөх магадлалтай байгаа үед цахим хяналтыг сайжруулах шаардлага тулгарч байна.
4. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны хяналтад ашиглаж буй цахим бугуйвч, техникийн бусад хяналт шинжлэх ухаан, технологийн хөгжилтэй уялдан үргэлж шинэчлэгдэж байгаа өнөө үед манай улсын ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж буй технологи хоцрогдсон байна. Иймд цахим хяналтын төхөөрөмжийн шинэчлэлт, хүртээмжийг улс орныг бүхэлд нь хамарсан байдлаар зохион байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх нь зүйтэй.
5. Улсын хэмжээнд жилд дунджаар хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан 25000 орчим ялтан, этгээдэд холбогдох шүүхийн шийдвэр хэрэгжүүлэх ажиллагаанд жилд дунджаар 1.1-1.2 тэрбум төгрөг зарцуулагдахаар байгаа бөгөөд энэ нь хорих ял эдлүүлэх ажиллагааны зардлаас даруй 10-15 дахин бага юм. Тиймээс хорихоос өөр төрлийн, тэр дундаа зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах нь улс орны эдийн засагт ч чухал ач холбогдолтой байна.
6. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны өдөр тутмын хяналтыг сайжруулахад аймаг, орон нутгийн хэмжээнд биечилсэн хяналт хэрэгжүүлэх, эрэн сурвалжлах чиг үүрэгтэй алба хаагчийн орон тоо бий болгох, нэмэгдүүлэх шаардлагатай гэж дүгнэлээ.

ЗУРГАА. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Судалгаанд тулгуурлан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй дараах хууль, журамд өөрчлөлт оруулах саналтай байна:

Хүснэгт 20. Зорчих эрхийг хязгаарлах ялд хяналт тавихад тулгамдаж буй асуудал

№	Хууль, журмын нэр	Өөрчлөлт оруулах санал
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	171.1. Ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны саналыг үндэслэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл, тоног төхөөрөмжийг тогтооно.
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	173.1. Ялтан зайлшгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, гэр бүлийн гишүүн нь хүндээр өвчилсөн, нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон зэрэг зайлшгүй шаардлагатай тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэн, тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчиж болно.
3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	176.1. Ялтан нийгэмшиж буй байдлаа хувийн зан байдал, хөдөлмөрийн үр дүнгээрээ харуулсан бол 1 сард 5 хүртэл хоногийн шагналын хоног олгоно.
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	Биечилсэн хяналтын ажилтан нь зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавина.
5	Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам	“Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан үүрэн холбооны операторын төлбөрийг ял эдлэх хугацаагаар тооцож төлнө” гэсэн заалт шинээр нэмэх.

1. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд ашиглагдаж буй программ хангамжийн аюулгүй ажиллагаа, хэвийн нөхцөлийг хангах чиглэлээр серверийн өргөтгөл, хөгжүүлэлт хийх, үзүүлэлт өндөр, ялтны бие, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, “GPS”-ийн байршил, хөдөлгөөнийг оновчтой заадаг, цэнэгээ удаан хугацаанд хадгалдаг, бат бөх чанартай, бусад ухаалаг үзүүлэлт бүхий цахим бугуйвч хэрэглээнд нэвтрүүлж, нөөц бүрдүүлэх;
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, газруудад шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын ачааллыг бууруулахын тулд оргон зайлсан ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий бүтэц бий болгох;
3. Шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа ялтны оршин суух газар, байршил, чиглэлийг харгалзан ялгамжтай байдлаар оногдуулах, улмаар хөдөө, орон нутагт амьдарч буй малчны амьдралын хэв маягийг харгалзан үзэх;
4. Шийдвэр гүйцэтгэгч нь ялтанд хязгаарлалтын бүс, хүлээх үүргийн талаарх мэдээллийг бүрэн дүүрэн өгөх, энэ чиглэлээр тусгайлсан зааварчилгаа өгч байх;
5. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчдийн ур чадварт анхаарч, албаны сургалт, дадлагын хэлбэр, чанар, үр дүнд анхаарах нь зүйтэй. Түүнчлэн цахим хяналтын техникийн мэдлэг, чадварыг Дотоод хэргийн их сургуулийн сургалтын агуулга, хөтөлбөрт тусгах, хуулийн бусад их, дээд сургуулийг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр сургалтын хөтөлбөртэй болгох.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль, тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга. 2017.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017.

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

1. Б.Алтангэрэл. “Эрүүгийн ялын гүйцэтгэлийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ” судалгааны ажлын тайлан. УБ., 2018.
2. Нээлттэй Нийгэм Форум. “Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх арга зам /Харьцуулсан судалгаа/” судалгааны тайлан. 2016.
3. Б.Баярсайхан, С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009 он). УБ., 2011.
4. Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн эрх. УБ., 1969.
5. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 1989.
6. Т.Дэндэв. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй дэх ял шийтгэлийн тухай асуудал. УБ., 1975.
7. Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018.

Гурав. Гадаад хэлээр нийтлэгдсэн материал

1. Hans-Joerg Albrecht. Electronic Monitoring in Europe. A Summary and Assessment of Recent Developments in the Legal Framework and Implementation of Electronic Monitoring.
2. Mortimer, E., May, Ch.: Electronic monitoring in practice: the second year of the trials of curfew orders. London: Home Office, 1997.
3. Bishop, N.: Le controle intensif par surveillance electronique: un substitut suedois a l' emprisonnement. Bulletin d' information penologique 19/20 (1995),
4. Ministry of Justice: Electronic Monitoring. The Hague, 1996.
5. Haferkamp, R.: Elektronisch überwachter Hausarrest-Europa und die Schweiz. Neue Kriminalpolitik, 1999.
6. Mayer, M., Haverkamp, R., Levy, R. (eds.): Will Electronic Monitoring Have a Future in Europe? Freiburg, 2003.
7. Ceron I Riera, M.: The Pilot Project on Electronic Monitoring in Catalonia, Spain. In: Mayer, M., Haverkamp, R., Levy, R. (eds.): Will Electronic Monitoring Have a Future in Europe? Freiburg, 2003.
8. Schädler, W.: The Pilot Project on Electronic Monitoring in Frankfurt, Germany. In: Mayer, M., Haverkamp, R.

9. R., Levy, R. (eds.): Will Electronic Monitoring Have a Future in Europe? Freiburg, 2003.
10. M.: Modellprojekt Elektronische Fußfessel. Wissenschaftliche Befunde zur Modellphase des hessischen Projekts. Freiburg, 2004.
11. Nacro Youth Crime 2002, "Electronic monitoring of children remanded on bail or to local authority accommodation", Youth Crime Briefing, June.
12. Matt Black and Russell G. Smith. Electronic Monitoring system in Criminal Justice. Australian institute of Criminology. Canberra, 2003.
13. Section 44 (3) (b), Sentencing Act 1995 (NT).
14. Gable, Ralph K., and Robert S. Gable. 2005. "Electronic Monitoring: Positive Intervention Strategies." Federal Probation 69(1). Kansas Department of Corrections, 2014.
15. National Law Enforcement and Corrections Technology Center. 1999. Keeping Track of Electronic Monitoring. Washington, D.C.: U.S. Department of Justice, National Institute of Justice.
16. William D., Karen Mann, Thomas G. Blomberg, Gerald G. Gaes, Kelle Barrick, Karla Dhungana, and Brian McManus. 2010. "A Quantitative and Qualitative Assessment of Electronic Monitoring." Tallahassee, Fla.: Florida State University, College of Criminology and Criminal Justice, Center for Criminology and Public Policy Research.
17. Stephen V., Randy Gainey, Marcia I. Cohen, Eoin Healy, Martha Yeide, Alan Bekelman, Amanda Bobnis. 2013. Monitoring High-Risk Gang Offenders with GPS Technology: An Evaluation of the California Supervision Program Final Report. Bethesda, MD: Development Services Group.
18. Bonta, James, Suzanne Wallace-Capretta, and Jennifer Rooney. 2000. "Can Electronic Monitoring Make a Difference? An Evaluation of Three Canadian Programs."
19. Wiebush, Richard G. 1993. "Juvenile Intensive Supervision: The Impact on Felony Offenders Diverted from Institutional Placement."
20. Development Services Group, Inc. 2014. "Home Confinement and Electronic Monitoring." Literature Review. Washington, DC.: Office of Juvenile Justice and Delinquency Prevention.
21. Sklaver, Stacey L. 2010. "The Pros and Cons of Using Electronic Monitoring Programs in Juvenile Cases." Juvenile Justice Committee Newsletter, No.5. Washington, D.C.: American Bar Association
22. Gable (former Ralph Schwitzgebel), Journal of Criminal Justice, 1986.
23. Schmidt, Journal of Contemporary Criminal Justice, 1989.
24. RITA HAVERKAMP. Implementing Electronic Monitoring A comparative, empirical study on attitudes towards the measure in Lower Saxony/ Germany and in Sweden.
25. G Mair; C Nee. Electronic Monitoring: The Trials and Their Results. 1990.
26. Compare the overview of the average prison population of Walmsley 1998.
27. Haverkamp, in: Neue Kriminalpolitik 1999/4.

28. James Kilgore. Electronic Monitoring Is Not the Answer Critical reflections on a flawed alternative. Urbana-Champaign Independent Media Center A part of the Media Action Grassroots Network (MAG-Net). 2015.
29. Jeff Abell, Juvenile Offenders Housing Costs Spike: Board Explores Pulling Juveniles from Lee County Center, THE HAWK EYE, Mar. 5, 2010 available at 2010 WLNR 4744738.
30. ФСИН России: Ведомственная целевая программа «Внедрение современных информационно-коммуникационных технологий в деятельность Федеральной службы исполнения наказаний на 2011-2013 годы». М., 2010, с.66 (хандалт-2018.01.10).
31. Федеральное государственное унитарное предприятие “Центр информационно-технического обеспечения и связи Федеральной службы исполнения наказаний <http://www.citosfsin.ru/company/index.php> (хандалт-2018.01.10).

Доров. Цахим хаяг

1. www.legalinfo.mn
2. www.mojha.gov.mn



Хавсралт 2. Монгол Улсад ашиглахаар судалж буй цахим бугуйвчийн судалгаа



Туршилтын цахим төхөөрөмжүүдийн техникийн үзүүлэлт

	Цахим бугуйвчийн төрөл: Хөл Цахим бугуйвчийн загвар: DDX14 Өнгө: Хар Жин: 250 грамм Онцлог: Гэрийн хяналтад нэмэлт төхөөрөмж ашиглана. Нэг бүрийн үнэ: 160 ам. доллар (Alibaba.com) Үйлдвэрлэгч: БНХАУ-ын Шень Жэнь муж, Шишун технологийн компани
	Цахим бугуйвчийн төрөл: Гар Цахим бугуйвчийн загвар: DDX04 Өнгө: Хар Жин: 70 грамм Нэг бүрийн үнэ: 95 ам. доллар (Alibaba.com) Үйлдвэрлэгч: БНХАУ-ын Шень Жэнь муж, Шишун технологийн компани
	Цахим төхөөрөмжийн төрөл: Гэрийн хяналтын төхөөрөмж Цахим бугуйвчийн загвар: DDX15 Өнгө: Хар Жин: 250 грамм Нэг бүрийн үнэ: 160 ам. доллар (Alibaba.com) Үйлдвэрлэгч: БНХАУ-ын Шень Жэнь муж, Шишун технологийн компани

Хавсралт 3. Гадаадын зарим орны цахим бугуйвч

№	Улс орон	Цахим бугуйвч
1	Швейцарын Холбооны Улс	
2	Оросын Холбооны Улс	
3	Бүгд Найрамдах Солонгос Улс	
4	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	
5	Америкийн Нэгдсэн Улс	
6	Бүгд Найрамдах Франц Улс	
7	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	

8	Саудын Арабын Хаант Улс	
9	Япон Улс	
10	Израил Улс	



ISBN 978-9919-9926-5-1



9 789919 992651